ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2018 ОНЫ 6-Р САР

Лиахона

Дэлхийг бүхэлд нь адисалсан илчлэлт, х. 12

Журамт эцэг байх: Бурханлаг зан чанарыг зэрвэсхэн харах, х. 22

Зовж зүдэрч буй хүмүүст амь бие үл хайрлан үйлчлэх, х. 26

"Би ялтаснуудыг авсан" хэмээн Иосеф чанга хэлэв, х. 32

Тэргүүн Зөвлөлийн захиас бичгээс, 22-р хуудас.

Лиахона, 2018 оны 6-р сар

ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ

22 **Зөв шударга эцгийн нөлөө**
Мэган Воррэн
Миний амьдралд байсан эцгүүд зөв шударга эцэг хүн байхын ач холбогдлын талаар заасан.

26 **Нэг нэгнийхээ ачааг үүрэлцэх нь**
Ахлагч Жэффри Р.Холланд
Бид Христийн адил, Бурханы бүх хүүхдийн зовлонг ойлгож байгаагаа харуулснаар Эзэний ажилд оролцох боломжтой.

32 **Гэгээнтнүүд: Сүмийн түүх—4-р бүлэг: Сэргэг бай**
Олон жил өнгөрсний эцэст Иосеф Смитэд сэргэг бай хэмээн хэлж ялтаснуудыг өгчээ.

БУСАД ӨГҮҮЛЭЛ

4 **Итгэлийн хөрөг: Дэлва Нэтанэ**

6 **Тохинууллын зарчмууд: Сайн сонсогчдын хийдэг таван зүйл**

10 **Сүмд үйлчлэх нь: Бидний тусламж хэрэгтэй байгаа газар**
Вилфрайд ба Лора Эй

40 **Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой**

80 **Биднийг дахин уулзах хүртэл: Хүндэтгэлийн өдрийн ариун өргөө**
Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард

1978 ОНД ИРСЭН ИЛЧЛЭЛТИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ НЬ

12 **Санваарын адислалуудыг түгээх**
Санваарын талаарх 1978 оны илчлэлт хэрхэн хувь хүн, гэр бүлүүд болон Сүмийг адисалсан тухай

16 **Бидний цаг үед ирсэн илчлэлт**
1978 оны 6-р сарын 1-нд санваарын тухай илчлэлт хүлээн авахад ямар сэтгэгдэл төрснөө дөрвөн төлөөлөгч дурсан өгүүлнэ.

18 **Боломжтой бүхий л арга замаар адисалсан**
Ахлагч Эдвард Дуби
Би бүрэн цагийн номлогч байхдаа анх хар арьстангуудад санваар өгөхийг хориглодог болохыг мэдэж авсан.

20 **Санваарт хүндэтгэлтэй хандах нь**
Шарлотт Аккуа
Анхны номлогчдыг Ганад ирснээс хойш ердөө гуравхан сарын дараа би баптисм хүртсэн юм.

ХАВТСАН ДЭЭР
Гэрэл зураг Кристина Смит

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ


48

44 Тэвчээр бол тэнцвэржүүлэх үйл явц
Ахлагч Майкл Жон Ю.Тэ
Бурхан асуултад маань хариулахгүй байгаа мэт санагдах үед би юу хийх ёстой вэ?

48 Өөртөө болон Бурханд үнэнч хандах
Фэйт Садерлин Блакхөрст
Бурхан надад бардам зангаа орхин, бишопынхоо шүүмжлэлийг хүлээн авахад тусалсан.

Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Сэжүүр: Та ах, эгч, дүү нартаа хэрхэн үйлчилдэг вэ?

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

50 Амьдралын бэлтгэл: Халамжийн нийгэмлэг уйтгартай болов уу?
Шарлотт Ларкэбэл
Халамжийн нийгэмлэг миний бодож байсантай адил байсангүй.

52 Амьдралын бэлтгэл: Ахлагчдын чуулгад орсон анхны өдөр
Даллин Лүдкэ
Хэрэв хувь нэмрээ оруулах хүсэлтэй л байвал надад ахлагчдын чуулгад өгөх зүйл их байв.

54 Номлолын талбараас: Нэмэлт тусламж
Алий Арнэл

56 Бидний орон зай

58 Хуудас бүр дээр “Бид итгэдэг” гэсэн байлаа
Ричард М.Ромни
Ангийн хүүхэд маань мормончууд Христийн шашинтнууд биш гэж хэлсэн учраас би Мормоны Ном бидэнд юу заадгийг олж мэдэхээр шийдэв.

60 Асуулт, хариулт
Би хэрхэн өөртөө илүү итгэлтэй байж чадах вэ? Ялган таних бэлэг гэж юу вэ?

62 Авьяас бэлгээ олж мэд
Жастина Лихнэр

64 Зурагт хуудас: Сүнслэг гэрэл

65 Сүүлчийн үг: Гэрэл үргэлж байдаг
Ахлагч Дийтр Ф.Угдорф

52

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

76

66 Гэрлээрээ гэрэлтүүл: Хайраа харуулах нь
Би гэр бүлийнхэндээ үйлчилснээр Тэнгэрлэг Эцэгийнхээ хайрыг мэдэрдэг.

68 Фэликсийг оронд нь оруулах цаг
Хэйди Поэлмэн
Антон компьютерийн тоглоомоо үргэлжлүүлэн тоглохыг хүсэж байсан ч дүүдээ үйлчлэх нь үүнээс илүү чухал байв.

70 Тортияа ба амигас (найз нөхөд)
Линдзий Стивэнс ба Марисса Дэннис
Адриана хөрш Маргаритатай зууш хуваалцах болсондоо баярлаж байлаа. Гэхдээ тэр найз нь байгаад бүр ч их баяртай байлаа.

72 Дуу хөгжим: Гайхамшиг
Шона Бэлт Эдвардс

74 Төлөөлөгчид Христийн талаар гэрчилж байна
Ахлагч Дэйл Г.Рэнланд

75 Тэнгэрлэг Эцэг таныг мэднэ
Кристина Б.Франко

76 Судрын түүхүүд: Мосе Бурханыг дагадаг
Ким Вэбб Рэйд

79 Будах хуудас: Би амар тайванг тогтоогч байж чадна

2018 ОНЫ ЗУРГАДУГААР САР, 19, №3
ЛИАХОНА 14752 363
Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, Хэнри Б.Айринг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: М.Рассэлл Баллард, Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Ухтдорф, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд

Эрхлэгч: Хюго И.Мартинэз
Туслах редакторууд: Рэндэлл К.Бэннэтт, Кэрол Ф.Макконки
Зөвлөхүүд: Бриэн К.Эштон, Бонни Х.Кордон, Бага Лигранд Р.Куртис, Эдуард Дюб, Шэрон Юбанк, Доналд Л.Холлструм, Даглас Д.Холмэс, Эрих В.Көпишкэ

Удирдах захирал: Ричард И.Хийтон
Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг
Бизнесийн менежер: Гарффд Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон
Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр
Хэвлэлийн туслах: Фрэнсиска Олсон
Редакцийн баг: Мэрисса Дэннис, Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фуллэр, Гаррэт Х.Гарффд, Ларин Портэр Гаунт, Жон Рэйн Жэнсэн, Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мардок, Салли Жонсон Одэкөрк, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М. Ромни, Минди Сэлу, Чакэлл Вордлэй, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн
Зураглал чимэглэлийн удирдагч: Тадд Р.Петрсон
Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй П.Андрус, Мэндий Бэнтли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Эмили Чиэко Рэмингтон, Марк В.Робисон, Брэд Тиэри, К.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун
Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс
Хэвлэх баг: Ира Глэнн Адэйр, Жюли Бардэтт, Томас Ж.Кронин, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Дэрэк Ричардсон
Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис
Хуваарилалт хариуцсан захирал: Трой Р.Бэркир

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын, свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга, украйн, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2018 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн тухай мэдээлэл: Өөрөөр заагаагүй бол хувь хүмүүс *Лиахона* сэтгүүлээс арилжааны бус, хувьдаа (мөн Сүмийн дуудлагат ажилд) ашиглах зорилгоор материал хувилан авч болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй. Үзүүлэнгийн материалыг хэрэв зураг чимэглэлийн тухайд ямар нэг хязгаарлалт тогтоосон бол хуулбарлаж болохгүй. Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St., FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:
June 2018 Vol. 19 No. 3. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is $5.00 per year; Canada, $6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard, American Express) may be taken by phone. (Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ИНТЕРНЭТЭЭС ҮЗЭЖ БОЛНО

Liahona.lds.org гэсэн хаягаар өгүүллүүдийг уншиж мөн өөрийн түүхийг явуулна уу.

Сүнслэг өдөөлт бүхий захиасуудыг (англи, португаль, испани хэлээр) **facebook.com/liahona** хаягаар орж олон, бусадтай хуваалцана уу.

Санал хүсэлтээ **liahona@ldschurch.org** хаягаар илгээнэ үү.

Store.lds.org-оор орж захиална уу. Аль эсвэл хангамжийн төв дээр очин, тойргийн удирдагчаасаа асууж лавлан, 1-800-537-5971 (Америкийн Нэгдсэн Улс болон Канадад) дугаараар холбогдоно уу.

©GETTY IMAGES-ИЙН ШИГТГЭЭ ЗУРАГ

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Авьяас, *62*
Ариун Сүнс, *16, 48*
Ариун ёслол, *80*
Асран халамжлах, *26*
Ахлагчдын чуулга, *52*
Бардамнал, *48*
Бошиглогчид, *56, 76*
Гэр бүл, *4, 20, 44, 66, 68*
Дуулгавартай байдал, *32, 76*
Ерөнхий чуулган, *56*
Есүс Христ, *26, 58, 72, 74*
Залбирал, *4, 16, 43, 44*
Иосеф Смит, *32*
Итгэл, *4, 18, 44*
Итгэлтэй байдал, *60*
Мормоны Ном, *32, 56, 58*
Номлолын ажил, *41, 42, 54, 75*
Нөхөрлөл, *70*
Нэн чухал зүйлс, *44*
Санваар, *12, 16, 18, 20*
Сэргээлт, *32*
Судар, *58*
Сүмийн түүх, *32*
Сүнслэг бэлгүүд, *60, 62*
Сүнслэг гэрэл, *64, 66*
Тэнгэрлэг Эцэг, *40, 43, 75*
Үйлчлэл, *6, 10, 26, 56, 66, 70*
Үнэнч шударга байдал, *48*
Халамжийн нийгэмлэг, *50*
Хүндэтгэлийн өдөр, *80*
Хөрвөлт, хөрвүүлэг, *75*
Эцэг байх, *20*
Ялган таних чадвар, *60*

Хоёр дахь жирэмслэлтийнх нь дөрөв дэх сард Дэлвад ураг нь трисоми 13 нэртэй хромосомын ховор согогтой болохыг хэлжээ. Ургийн амьдрах магадлал бага байсан бөгөөд энэ нь бас Дэлвагийн амь насыг эрсдэлд оруулах магадлалтай байсан учраас эмч нар түүнд жирэмслэлтээ таслахыг удаа дараа зөвлөж байжээ. Үр дүн ямар байх нь тодорхойгүй байдалтай тулгарсан Дэлва юу ч болж байсан Тэнгэрлэг Эцэгт найдахаар шийдэв.

КРИСТИНА СМИТ, ЗУРАГЧИН

Дэлва Нэтанэ

АНУ, Калифорни муж

Найман сар хагас хүрч байхад би 4D эхо шинжилгээ хийлгэхээр явсан юм.

Өмнө нь эход харуулахад эмч нарт биеийн ямар ч эрхтнүүд нь харагдахгүй байлаа. Тиймээс охин маань мухар гартай, царайны гажигтай гарна гэж хэлж байсан юм. 4D эхоны зургууд илүү нарийн байсан тул техникч эхо шинжилгээг хийхэд охин маань бүрэн бүтэн гараараа дэлгэцээс над руу даллаж байгааг би харав. Би бас хоёр эрүүл нүд, амыг харсан. Надад яагаад ч юм тэр үхэхгүй юм байна гэсэн мэдрэмж төрж билээ.

Бидний охин Мэлаг төрөхөд хажууд зогсож байсан мэргэжилтнүүдийн хэрэг гараагүй юм. Мөн Мэлад трисоми 13 байсангүй. Эмч, мэргэжилтнүүд шалтгааныг тайлбарлаж чадахгүй байсан ч нөхөр бид хоёр энэ бол гайхамшиг байсныг мэдэж байв.

Тохинуулллын зарчмууд

САЙН СОНСОГЧДЫН ХИЙДЭГ ТАВАН ЗҮЙЛ

Чин сэтгэлээсээ сонсох нь таныг бусдын сүнслэг болон материаллаг хэрэгцээг хэрхэн Аврагчийн адил хангахаа мэдэж авахад тусална.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд "Магадгүй сонсох нь ярихаас илүү чухал байж болох юм. . . . Хэрвээ бид хайраар сонсох юм бол юу гэж хэлэх вэ гэж санаа зовохгүй байх болно. Энэ нь бидэнд Сүнсээр өгөгдөх болно"[1] гэж хэлсэн байдаг.

Сонсох бол бидний сурч болох чадвар юм. Сонсох нь бусдад бидний хайрыг харуулж, бат бөх харилцаа тогтооход тусалдаг бөгөөд хүмүүсийн хэрэгцээг ойлгоход тусалдаг ялган таних бэлгээр адислах Сүнсийг урин ирүүлдэг.[2] Бид дараах таван арга замаар сонсох чадвараа сайжруулж чадна.

Итгэж үнэмшдэг нийтлэг зүйлээ ол

Та хэлсэн болгонтой санаа нийлэхгүй байж болох ч өөрийн мэдрэмжийг буруугаар илэрхийлэхгүйгээр зарим зүйлтэй санаа нийлж болох юм. Нийцтэй байснаар сэтгэл зовнил болон хэт мэдрэмтгий байдлыг бууруулж чадна (Матай 5:25-ыг үзнэ үү).

Тунгаан бод

Юу сонссоноо мөн бусдыг хэрхэн ойлгож мэдэрснээ өөрийн үгээр илэрхийл. Энэ нь бусдад ойлгомжтой байсан эсэхийг мэдэж, тодруулах боломжийг тэдэнд өгч тусална.

Тэдэнд хугацаа өг

Ихэнх хүнд үг хэлэхийн өмнө боддоо цэгнэх хугацаа хэрэгтэй байдаг. Ямар нэг юм хэлэхийнх нь өмнө болон дараа тэдэнд бодох хугацаа өг (Иаков 1:19-ийг үзнэ үү). Тэдний яриад дууссан гэдэг нь шаардлагатай бүх зүйлээ хэлчихлээ гэсэн үг биш юм. Дуугүй байхаас бүү ай. (Иов 2:11–3:1 ба Алма 18:14–16-г үзнэ үү).

Анхаарлаа хандуул

Бид бусдыг үг хэлж амжихаас хурдан боддог. Хүмүүсийг ярьж дуусаагүй байхад шууд дүгнэх юм уу юу гэж хэлэхээ түрүүлж бодохоос татгалз (Сургаалт үгс 18:13-ыг үзнэ үү). Харин үүний оронд ойлгох зорилгоор сонс. Сонссоноор бүр сайн ойлгох тул хариулт тань илүү сайн байх болно.

Тодруул

Ойлгоогүй зүйлээ тодруулахын тулд асуулт тавихаас бүү ай. (Марк 9:32-ыг үзнэ үү). Тодруулах нь үл ойлголцлыг багасгаж, тухайн хэлж байгаа зүйлд анхаарал хандуулж байгааг тань харуулна.

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон “Нэг нэгнээсээ сонсохын тулд суралц, суралцахын тулд сонс” гэж заасан.[3] Та бусдаас суралцах зорилгоор сонсвол тэдний хэрэгцээг илүү сайн мэдэж авч, эргэн тойрны хүмүүсээ Аврагчтай адил хэрхэн халамжлах тухай санаануудыг олж сонсох болно.

Сонсох нь хайрлаж байна гэсэн үг

Сонсохын хүчний талаар ахлагч Холландын өгүүлсэн түүх:

“Трой Рассэлл гэдэг найз маань бага оврын ачааны машинаа гараашнаасаа аажуухан гаргаж байтал . . . машиных нь хойд дугуй нэгэн овгор зүйл дээгүүр гарахыг мэдэрсэн аж. . . . Машинаасаа бууגаад хартал, өөрийнх нь хайртай, есөн настай Остэн хүү зам дээр доошоо харан хэвтэж байв . . . Остэн нас баржээ.

Трой унтаж ч, тайвширч ч мөн тайтгарч ч чадахгүй байв. . . . Гэвч тэрхүү зовлон шаналлын үед . . . Жон Мэннинг ирсэн юм.

Би Жон залуу хамтрагчтайгаа хамт Рассэллын гэрт ямар хуваариар айлчлан очсоныг мэдэхгүй. . . . Би өнгөрсөн хавар Мэннинг ах Трой Рассэллыг тэрхүү зам дээрээс яг бяцхан Остэныг өргөж буй мэтээр өргөн авсан гэдгийг л мэднэ. Жон . . . сайн мэдээн дэх ахын хувьд Трой санваарын халамж, хамгаалалтандаа авсан юм. Тэр эхлээд ‘Трой, Остэн чамайг буцаад хөл дээрээ, мөн сагсан бөмбөгийн талбай дээрээ зогсоосой гэж хүсэж байгаа. Би энд өглөө бүр 5 цаг 15 минутад хүлээж байх болно. Бэлэн байгаарай. . . .’ гэж хэлжээ.

‘Би явахыг хүсээгүй’ гэж Трой надад хожим нь хэлээд, ‘яагаад гэвэл би өглөө бүр Остэныг авч гардаг байсан юм. . . . Гэвч Жоныг гуйсан болохоор би явсан. Эхний өдрөөс авахуулаад бид буцах замдаа ярилцаж, яг үнэндээ миний ярихыг Жон сонсох болсон. . . . Эхэндээ ингэх нь хэцүү байсан боловч цаг хугацаа өнгөрөх тусам би амьдралд маань нар дахин мандтал намайг хайрлаж бас сонсдог байсан Жон Маннингийн ачаар хүч чадлаа эргэн олж авсныг ойлгосон’ гэж ярьсан билээ.”[4] ■

АВРАГЧИЙН АДИЛ ҮЙЛЧЛЭХ НЬ

Есүсийг Иерихогоос гарч явахад хоёр сохор хүн түүн рүү, “Эзэн минь ээ, биднийгээ өршөөгөөч гэж хашхиралдав. . . .

Есүс зогсож тэднийг дуудаад,—Өөрсдийнхөө төлөө Надаар юу хийлгэхийг хүснэ вэ? гэхэд,

тэд—Эзэн, нүд маань нээгдэхийг бид хүсэж байна гэв.

Есүс тэднийг ихэд өрөвдөж, нүдэнд нь гар хүрэхэд тэр даруй тэд хараа орж Түүнийг дагалаа” (Матай 20:30, 32–34).

Бид Аврагчийн хэрхэн сонсож байгаагаас юу сурч болох вэ?

ЭШЛЭЛҮҮД

1. Jeffrey R. Holland, “Witnesses unto Me,” *Liahona,* July 2001, 16.
2. See David A. Bednar, in “Panel Discussion” (worldwide leadership training meeting, Nov. 2010), broadcasts.lds.org.
3. Russell M. Nelson, “Listen to Learn,” *Ensign,* May 1991, 23.
4. Жэффри Р.Холланд, “Сүмийн төлөөлөгчид,” *2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 52–54.

ЖЭЙМС ТИССОТ, *ЕСҮС ДОГОЛОН БОЛОН СОХОР ХҮМҮҮСИЙГ ЭДГЭЭЖ БАЙГАА НЬ* ЗУРГИЙН ХЭСГЭЭС

ҮЙЛДЭХЭД УРИХ

Та үйлчлэлдээ эдгээр зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх талаар бодож үз. Та тохинуулдаг хүмүүсээсээ тэдэнд юу хэрэгтэй байгааг асуу. Тэдний хариултыг болон Ариун Сүнсний шивнээг сонс. Сонссоныхоо дагуу үйлд.

Тохинууллын зарчмууд нь нэг нэгнээ халамжлахад бидэнд туслах зорилготой бөгөөд хуваалцах захиас биш юм. Бидэнд даалгасан хүмүүсийг таньж мэдэх үед тэдэнд халамж энэрлээс гадна ямар захиас хэрэгтэй байгааг Ариун Сүнс бидэнд шивнэн хэлэх болно.

БИДНИЙ ТУСЛАМЖ ХЭРЭГТЭЙ БАЙГАА ГАЗАР

Вилфрайд ба Лора Эй

Бид Нью-Йоркийн Бруклин руу нүүх сүнслэг өдөөлт хүлээн авснаар төсөөлж ч байгаагүй арга замаар үйлчлэн, адислалуудыг хүлээн авсан юм.

2013 онд бид АНУ-ын Нью-Йорк мужийн Манхэттэнд амьдарч байсан ба тойрогтоо дуртай байв. Бид анхны хүүхдээ өлгийдөн авахаар бэлдэж байсан учраас тойргийнхоо харьяалалд байх арай том байр хайж эхэлсэн юм. Яг тохирсон байраа олсон ч зөв гэж санагдахгүй байлаа.

Тэр хавар Лорад Бруклин руу нүүх хэрэгтэй байх гэсэн мэдрэмж төрөх болжээ. Харин Вилл үүнд эргэлзэж байв. Бид Бруклиний талаар юу ч мэдэхгүй байсан ба Вилл хөрөнгө оруулалтын банкны ажилдаа ойр байхыг хүсэж байлаа. Учир нь олон цагаар ажиллахаас гадна замд ажил руугаа иржь, очиход багагүй хугацаа зарцуулах шаардлагатай болох байв. Бид энэ талаар залбирч, Ерөнхий чуулганы үеэр хариултаа олж сонсохоор шийдэв.

Биднийг нэг өрөө байрандаа зөөврийн компьютероор чуулганыг үзэж байтал Далын ахлагч Стэнли Г.Эллис гадасны ерөнхийлөгч байхад нь тохиолдсон нэг үйл явдлаа хуваалцсан юм. АНУ-ын Техас дахь гадас руу нь нүүж очиж байгаа гэр бүлүүд ихэвчлэн аль нь хамгийн сайн тойрог вэ гэж асуудаг байжээ. Харин 16 жил болоход ганцхан гэр бүл аль тойрогт тусламж хэрэгтэй байна вэ хэмээн асуусан аж.[1]

Уг түүх бидний зүрхэнд хүрч, залбирлын маань хариулт болов. Тиймээс бид таалагддаг, тохь тухтай, маш сайн бага насны хүүхдийн анги болон Хүүхдийн хэсэгтэй тойрогтоо үлдэхийн оронд ахлагч Эллисийн зөвлөгөөг хүлээн авч, хаашаа нүүх хэрэгтэй вэ гэж залбирсан.

Тэр үед бид Нью-Йоркийн Манхэттэн ариун сүмд ёслолын ажилтнаар үйлчилдэг байв. Тэндхийн нэг ажилтан Нью-Йорк хотыг сайн мэддэг байлаа. Тэр тусламж хэрэгтэй байж болох хоёр тойргийг санал болгов. *Тэдгээр нь хоёулаа Бруклинд байлаа.*

Эхний тойрог нь Виллийн ажлаас хэт хол, харин удаах нь арай ойрхон байсан ба уг тойргийн ариун ёслолд суух үед бидэнд зөв газраа олсон гэсэн мэдрэмж төрсөн юм. Тэнд Гаитигээс цагаачилж ирсэн олон гишүүн байв. Вилл Габоноос ирсэн бөгөөд франц хэлтэй байсан учраас тэр тойрог бидний хувьд гэр орон маань болно хэмээн бидэнд бодогдож билээ.

Гайхамшигт үйл явдлууд

Хэдэн долоо хоногийн дараа бид байраа олж, нүүв. Удалгүй Вилл гайхалтай арга замаар үйлчлэх дуудлага хүлээн авсан юм. Хэл амаа ойлголцоход хэсэг хугацаа шаардагдсан ч тэр удалгүй Гаитигийн креол аялгаар чөлөөтэй ярьдаг болж, гишүүдэд цуглаан дээр болон ярилцлагын үеэр хөрвүүлж туслах болов. Лора ч гэсэн адислагдан олон дуудлагад үйлчилж, бид номлолын ажилд оролцох болсон билээ.

Гаитигээс сурахаар ирсэн Нормил Ромэлус нэртэй залуухан сонирхогчтой бид найзлах болов. Тэр номлогчидтой хамт манай гэрт ирдэг байсан бөгөөд бид франц, кореол хэлээр заахад нь тусалдаг байлаа. Нормилыг баптисм хүртсэний дараа бид түүнийг Сүмийн боловсролтой болох арга зам хөтөлбөрт хамруулсан бөгөөд тэнд тэр ирээдүйн эхнэртэйгээ учирсан юм. Вилл Манхэттен ариун сүмд тэдний хуриман дээр очих болсондоо талархаж байв.

Түүнчлэн бид хорт хавдраа эмчлүүлэхээр Гаитигээс Нью-Йорк руу ирсэн нэгэн итгэлтэй эгчтэй уулзсан. Тэнд байх хугацаанд нь тойргийн зөвлөлөөс уг эгчийг эмчилгээнд нь хүргэж өгөн, буцааж гэрт нь авчрах зэргээр тусалж, хэрэгтэй бүхнээр нь хангахын тулд бүхий л арга хэмжээг авч байв. Түүн дээр яг тэр үед нь очиж, үйлчилж байснаараа бид адислагдсан. Бүх зүйл сайн болоосой гэж хүсэж байсан ч тэр өөд болсон юм.

ЭЙ ГЭР БҮЛИЙН ЗУРАГ

Энэ хоёр туршлага тухайн тойргийнхон хүмүүст тусалж, дэмжиж, тэдний төлөө юу хийж байсныг харуулж байгаа жишээ юм. Бид эдгээр болон бусад гайхалтай туршлагыг олж авсандаа талархдаг.

Юу үнэхээр чухал вэ?

Их Эзэнд мөн Түүний хүүхдүүдэд үйлчлэх үед Тэрээр бидний асуудлыг шийдвэрлэдэг гэдгийг бид мэдэж авсан. Бруклинаас олж авсан туршлага маань биднийг даруу байхад тусалсан. Тэр тусмаа эдгээр нь Волл Стрит дэх гял цал байдалд анхаарлаа хандуулалгүй, харин юу хамгийн чухал вэ гэдгээ мартахгүй байхад Виллд тусалсан юм. Хөрөнгө оруулалтын банкинд бараг хүн бүр ням гарагт ажилладаг байв. Вилл заримдаа дутуу орхисон ажлаа нөхөхийн тулд гэрээсээ ажилладаг байсан ч Их Эзэн түүнийг адисалж, хэзээ ч ням гарагт ажилдаа явах шаардлага түүнд гарч байгаагүй юм.

Бид Бруклинд нүүж очихдоо, бага насны хүүхдүүдтэй хоёрхон гэр бүлийн нэг нь байна гэж бодож байлаа. Харин биднийг нүүж очсоноос хоёр долоо хоногийн дараа тойргийн хил хязгаар өөрчлөгдөж, бага насны хүүхэдтэй өөр хэдэн гэр бүл нүүж ирсэн.

Хэзээ нэгэн цагт бид Габон руу очиж амьдрахаар төлөвлөж байгаа. Бруклинээс олж авсан туршлага маань биднийг Африк дахь сүм болон хүмүүст илүү сайн туслахад бэлдсэн гэж бид боддог. Бид нүү гэсэн сүнслэг өдөөлтийг сонссондоо талархдаг. Их Эзэн биднийг төсөөлж ч байгаагүйгээр адисалсан ба цаашид ч адислах болно. ■

Зохиогчид нь АНУ-ын Массачусетс мужид амьдардаг.

ЭШЛЭЛ

1. Стэнли Г.Эллис, "Их Эзэний зам," *2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 43–46-г үзнэ үү.

САНВААРЫН АДИСЛАЛУУДЫГ ТҮГЭЭХ

Бурхан Өөрийн бүх хүүхдэд хайртай бөгөөд бид бүгдэд Өөрт нь эргэн ирэх арга замыг хангаж өгсөн.

Редакторын тэмдэглэл: Хүн бүр энэ тухай сонсохдоо хаана байснаа санаж байдаг тийм чухал үйл явдал ховорхон тохиолддог. 1978 оны санваарын талаарх илчлэлт тухайн үеийн гэгээнтнүүдэд бүхэлд нь ийм нөлөө үзүүлсэн юм. Энэ илчлэлтийн түүхийг эсвэл Бурханы гэр бүлд үзүүлсэн үүний гүнзгий нөлөөг хангалттайгаар тайлбарлахад хэвлэлийн хуудасны зай хүрэлцэхгүй болович энэ илчлэлтийн 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд Лиахона *дараах товч танилцуулгыг дагалдуулан хувийн өгүүллүүдийн богино хэмжээний цуглуулгыг толилуулж байна. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах бол 21 дэх хуудасны нэмэлт материалын жагсаалтыг үзнэ үү.*

Мормоны Ном нь “хар ба цагаан, боол ба чөлөөт, эр болон эм” хэн ч “Бурханд бүгд адил” (2 Нифай 26:33) хэмээн заадаг. Бурхан бид бүгдэд хайртай учраас Тэр бид бүхэнд Өөрт нь эргэн очих арга замыг хангаж өгсөн (Мосе 5:9; Итгэлийн тунхаг 1:3-ыг үзнэ үү). Сүмийн түүхийн турш олон улс орны бүхий л үндэстэн ястны хүмүүс энэ зорилгоор баптисм хүртэж, хожмын үеийн гэгээнтнүүдийн хувиар итгэлтэй амьдарсаар ирсэн.

1978 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр гишүүд Албан тунхаг 2-ыг санал нэгтэй хүлээн зөвшөөрөх үеэр Тэргүүн Зөвлөлийнхэн зогсож байгаа нь. Санваарын талаарх илчлэлт гэр бүлүүдийг адисалж, ариун сүмийн адислал хүлээн авах үүд хаалгыг нээсэн юм. Баруун талд: Африкт баригдаж байгаа эсвэл үйл ажиллагаа явуулж байгаа найман ариун сүмийн нэг болох Ганагийн Аккра ариун сүмийн талбай дээр явж байгаа гэр бүл.

1978 ОНЫ ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛИЙН ЗУРГИЙГ СҮМИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Сүм 1800-аад оны дунд үеэс хар арьстай африк гаралтай эрэгтэйчүүдийг санваарт томилохыг эсвэл хар арьстай эрэгтэй, эмэгтэйчүүдийг ариун сүмийн хувийн хишиг юм уу лацдан холбох ёслолуудад оролцохыг зөвшөөрдөггүй байжээ.[1] Энэхүү тогтсон заншлын үүслийг тайлбарладаг ямар ч тэмдэглэл байдаггүй бөгөөд Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд эдгээр хоригийг тайлбарлахаар ямар ч онол гаргасан бай, энэ бол хэзээ ч үргэлжлүүлэх ёсгүй "цуу яриа" юм гэдгийг: "Хэчнээн сайн санааны үүднээс тайлбарласан байлаа ч энэ бүхэн хангалтгүй эсвэл буруу гэж би боддог. Бид энэ заншил яагаад бий болсныг ч мэдэхгүй шүү дээ"[2] хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг.

Бригам Янг зэрэг Сүмийн олон бошиглогч, ерөнхийлөгч зохистой бүх эрэгтэй санваар хүлээн авах өдөр ирнэ гэж амласан байдаг. Эдгээр амлалтыг мэдэж байсан учраас мөн хар арьстай хожмын үеийн гэгээнтнүүд итгэлтэй байсан учраас 20-р зууны дундад үеийн сүмийн удирдагчид "Их Эзэнээс тэнгэрлэг удирдамж эрэлхийлэн удаан хугацаанд, чин сэтгэлээсээ гуйсан."[3]

Бурханы илчлэлт

Энэ удирдамж ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллд (1895–1985) "ариун сүмийн ариун өрөөнүүдэд удаан бясалган, залбирсны эцэст" иржээ. 1978 оны 6-р сарын 1-нд Их Эзэн Өөрийн бошиглогч, Тэргүүн Зөвлөлийн болон Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдэд "сүм дэх зохистой, итгэлтэй эрэгтэй хүн бүр ариун санваарыг хүлээн авч, үүнийг бурханлаг эрх мэдлийг хэрэглэх хүчтэй болох мөн тэндээс үүдэлтэй адислал бүрийг, түүний дотор ариун сүмийн адислалуудыг хайртай хүмүүсийнхээ хамт эдэлж болох тэрхүү эрт дээр үед амлагдсан өдөр ирлээ" гэдгийг илчилсэн.[4]

Тэргүүн Зөвлөл уг илчлэлтийг зарлахдаа "Их Эзэн дэлхий даяарх бүх хүүхдээ адислахын төлөө Өөрийн таалалыг мэдүүлснийг бид бууръ суурьтайгаар тунхаглаж байна"[5] гэжээ.

Дараагийн Ерөнхий чуулганаар Тэргүүн Зөвлөл уг илчлэлтийг гишүүдэд танилцуулахад тэд үүнийг "Их Эзэний үг, хийгээд таалал" хэмээн хүлээн авч, Албан тунхаг 2-ыг судрын хэсэг болгон санал нэгтэй дэмжин баталсан юм.

Илчлэлтийн үр дүн

Илчлэлтийн үр нөлөө маш их байв. Бурхан санваарын болон ариун сүмийн адислалуудыг арьс өнгөнөөс хамаарахгүйгээр зохистой бүх гишүүнд олгоод зогсоогүй, амьдарч байсан хүн бүрийн төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэх боломжтой болгосон.

Уг илчлэлтээр дамжуулан номлолын ажлыг өргөжүүлэх боломж нээгдсэн төдийгүй олон үндэстэн, ястан, хэлтэн, хүмүүсийн дунд гишүүдийн тоо өсөн нэмэгджээ.

Сүмийн сургаалууд

Их Эзэний ажил дэлхий даяар түгэхийн хэрээр Сүмийн гишүүд агуу эв нэгдлийн эрин үед амьдарч байна. Сүмийн гишүүд олон улс үндэстэн, соёл, ёс

Залуу эрэгтэй дэлхийн олон үндэстний гишүүд цуглардаг Францын Парис хотод чуулгын цуглаан дээр хичээл зааж байгаа нь.

заншил бүхий газраас ирсэн хүмүүстэй харилцах харилцаа нь нэмэгдэх тусам Сүмийн удирдагчид бие биенээ хайрлаж, хүчирхэгжүүлэх, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдлыг арилгахын ач холбогдлыг тодотгосоор ирсэн.

"Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч, ерөнхийлөгч Рассэлл М.Баллард "Бид Бурханы үр хүүхдүүдийг энэрэн хайрлаж, арьс өнгө, хүйс, үндэс угсаагаар нь ялгаварлан гадуурхах аливаа гадуурхлыг үгүй хийх ёстой. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний адислал Бурханы хүүхэд бүрд зориулагдсан гэдэгт бид чин үнэнээсээ итгэдэг[6] хэмээн заасан. Бурханы мөнхийн гэр бүлийн талаар ярьж байхдаа ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон: "Бурханы жинхэнэ Эцэг байх ёсыг ойлгосон үед л хүмүүний жинхэнэ ах дүүс байх ёсыг бүрэн дүүрэн ойлгож болно. Энэ ойлголт л тусгаарласан ханануудын оронд хамтын ажиллагааны гүүрийг бий болгох хүслийг төрүүлдэг"[7] гэж заасан.

Хамтдаа урагш тэмүүлэх

Бид бүх зүйлийг мэдэхгүй ч хүн бүр цөөн хэдэн зүйлийг мэдэж авч чадна. Бурхан бидэнд хайртайг, мөн биднийг нэгдмэл, мөнхийн гэр бүлтэй болгохын тулд Түүнд бид бүхэнд зориулсан төлөвлөгөө байгааг бид мэдэж авч чадна. Энэ бол Их Эзэний сэргээгдсэн Сүм бөгөөд Тэр үүнийг бошиглогчдоороо дамжуулан удирддаг гэдгийг бид мэдэж авч чадна. Эдгээр үнэний талаар хувийн гэрчлэлтэй болох нь биднийг Түүнтэй адил болох зам дээр аливаа боломж, сорилт бэрхшээлийн дундуур хамтдаа урагш тэмүүлэхэд тусалж чадна (Моронай 7:48-ыг үзнэ үү). ■

ЭШЛЭЛҮҮД

1. "Race and the Priesthood," Gospel Topics, topics.lds.org.
2. "The Mormons" (interview with Jeffrey R. Holland, Mar. 4, 2006), pbs.org/mormons/interviews; түүнчлэн Dallin H. Oaks, "Apostles Talk about Reasons for Lifting Ban," *Daily Herald,* June 5, 1988, 21.
3. Албан тунхаг 2
4. Албан тунхаг 2
5. Албан тунхаг 2
6. М.Рассэлл Баллард, "Аян зам үргэлжилсээр!" *Ensign* эсвэл *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган.*
7. Рассэлл М.Нэлсон, "Teach Us Tolerance and Love," *Ensign,* May 1994, 70.

БИДНИЙ ЦАГ ҮЕД ИРСЭН **ИЛЧЛЭЛТ**

1978 оны илчлэлтийн талаарх бошиглогч, төлөөлөгчдийн дурдатгал

Редакторын тэмдэглэл: Ерөнхийлөгч Томас С.Монсон бол Бурхан Тэргүүн Зөвлөл, Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгад санваарын адислалыг арьс өнгөнөөс үл хамааран бүх зохистой гишүүнд өгөх цаг ирснийг илчлэх үед тэр өрөөнд байсан хамгийн сүүлийн амьд төлөөлөгч байсан. Тэр өдөр тэнд байсан ах нараас дөрвийнх нь товч тэмдэглэлийг энд тавив.

Эрэлхийлсэн нь



Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985)
Сүмийн 12 дахь ерөнхийлөгч

“Өдрөөс өдөрт би ариун сүмийн дээд өрөөнд агуу хүндэтгэлтэй мөн хянамгай байдлаар ганцаараа очдог байв. Тэнд би хөтөлбөрийг урагшлуулах тухай асуун, өөрийн бодгаль болон хичээл зүтгэлийг өргөл болгон өгдөг байсан. Би [Бурханы] хүссэнийг хийхийг хүсэж байлаа. . . .

Их Эзэн хаа газрын бүх зохистой эрэгтэй, эмэгтэй хүн сайн мэдээний бүрэн дүүрэн адислалуудыг хамт өвлөгч, хүртэгч байж болох цаг ирснийг тодорхой харуулсан гайхамшигтай туршлага бидэнд тохиосон юм. Би Аврагчийн онцгой гэрчийн хувьд ариун сүмийн дээд өрөөнд тоо томшгүй олон удаа орохдоо, заримдаа өдөрт хэд хэдэн удаа ганцаараа орох үедээ Түүнд болон Тэнгэрлэг Эцэгтээ ямар их ойр байгаагаа мэдэрснийг та нарыг мэдээсэй гэж хүсэж байна. Их Эзэн юу хийгдэх ёстойг надад маш тодорхой мэдэгдсэн юм.”

***Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* (2006), 238, 239.**

Залбирал

Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018)
Сүмийн 16 дахь ерөнхийлөгч

“Тэргүүн Зөвлөлтэй болон Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгатай уулзсан уулзалтынхаа төгсгөлд бид [ариун сүмийн] тахилын ширээний өмнө онцгойлон залбирсан бөгөөд энэ залбирлыг ерөнхийлөгч Кимбалл хэлсэн юм. Тэр Их Эзэнээс өргөн үр нөлөө бүхий энэ асуудал дээр гэрэл ба мэдлэгийг гуйн залбирсан. Түүнийг эрхэмсэг дуудлагадаа удирдамж эрэлхийлэх үед түүний даруухан гуйлтыг сонсох нь ах нарт агуу тайтгарал болж байв.

Тэргүүн Зөвлөл ‘Уулзалтыг бүрхэн авсан амар амгалан, эв нэгдлийн сүнс нь урьд хожид хэзээ ч байгаагүй тийм гайхалтай байсан төдийгүй, . . . энэ нь Их Эзэн бидний хэлэлцүүлгийг таалж байсны нотолгоо байсан” гэж хожим нь талархал илэрхийлсэн байдаг.’ . . .

. . . Энэ бол баяр хөөрт мөч байсан, учир нь Их Эзэний бошиглогч Их Эзэний энэ үед зориулсан илчлэлтээ тунхаглаж байхыг бид сонссон билээ.”

Heidi S. Swinton, *To the Rescue: The Biography of Thomas S. Monson* (2010), 393.

Бразилийн Манау хотын диконууд ариун ёслол түгээж байгаа нь. 1978 оны илчлэлтийн ачаар зохистой санваартнууд арьс өнгөнөөс үл хамааран санваарын ёслолуудыг гүйцэтгэж чадах болсон.

Илчлэлт

Ахлагч Брүс Р.Макконки (1915–1985)
Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч

"Их Эзэн өөрийн мэргэн ухаанд Тэргүүн Зөвлөл болон Арван хоёрын дээр Ариун Сүнсээ цутгасан юм. . . . Илчлэлт Сүмийн ерөнхийлөгч дээр мөн тэнд байсан бүх хүн дээр нэг бүрчлэн ирсэн. Арван хоёрын зөвлөлийн арван гишүүн, Тэргүүн Зөвлөлийн гурван гишүүн тэнд цугларсан байв. Бидэнд ирсэн шууд болон хувийн илчлэлтээр ерөнхийлөгч Кимбалл ба бидний хүн нэг бүр бусдаас үл хамааран сайн мэдээ ба үүний бүх адислал, үүргийг, үүний дотор санваар ба Их Эзэний өргөөний адислалуудыг бүх үндэстэн, ястанд, үүний дотор хар арьстнуудад түгээх цаг болсныг мэдэж авснаар үүний үр дүн гарсан юм. Юу болсон талаар, эсвэл ирсэн үг, захиасын талаар ямар ч асуулт гараагүй."

"All Are Alike unto God" (Brigham Young University devotional, Aug. 18, 1978), 4, speeches.byu.edu.

Баталгаа

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008)
Сүмийн 15 дахь ерөнхийлөгч

"Өрөө гэгээрүүлж ариусгасан уур амьсгалтай байлаа. Би ах нартайгаа хамт өвдөг сөгдсөн бөгөөд миний хувьд учирлан гуйж буй Бурханы бошиглогч, бурханлаг сэнтий хоёрын хооронд суваг нээгдсэн мэт санагдаж байв. Бурханы Сүнс тэнд байлаа. Тэнд буй Ариун Сүнсний хүчээр түүний залбирсан зүйл зөв, цагаа олсон байсан ба одоо санваарын гайхамшигт адислалууд дэлхийн өнцөг булан бүрд байх бүх зохистой эрэгтэй хүнд, гарал үүслээс нь хамаарахгүйгээр өгөгдөх ёстой гэсэн баталгаа бошиглогчид ирсэн юм.

Тэр хүрээн дэх эрэгтэйчүүд бүгд Ариун Сүнсний хүчээр адил зүйл мэдэрсэн. . . .

. . . Тэр тохиолдлын үед тэнд байсан бидний хэн нь ч үүний дараа өмнөхтэйгөө адил байж чадаагүй. Сүм ч гэсэн урьдын адил байхаа больсон юм."

"Priesthood Restoration," ***Ensign,*** **Oct. 1988, 70.**

Lds.org/go/061816 хаягаар орж, ерөнхийлөгч Кимбалл, ерөнхийлөгч Хинкли нарын энэ илчлэлтийн талаар дурсан ярьсныг сонсоно уу.

Далын ахлагч
Ахлагч Эдвард Дүби

БОЛОМЖТОЙ **БҮХИЙ Л АРГА ЗАМААР** АДИСАЛСАН

Энэ илчлэлт намайг болон миний гэр бүлийг мөн Африк дахь Сүмийг хэрхэн адисалсан тухай.

Редакторын тэмдэглэл: 1978 оны илчлэлт санваарыг хэн хүртэж болох талаарх хоригийг цуцалсан ч гэсэн Бурхан яагаад эдгээр хоригийг эхэндээ зөвшөөрснийг ойлгох хүсэлтэй олон гишүүн байдаг. Ахлагч Дүби энэ асуултад хувийнхаа туршлагаар хариулж байна.

Хар арьстнуудыг санваар хүртэхийг хориглодог байсныг би анх номлолд байхдаа сонсож байв. Би энэ хоригийг аль хэдийн цуцлагдчихсан байхад буюу 1984 онд баптисм хүртсэн. Хоёр жилийн дараа би Өмнөд Африкийн Йоханнесбург номлолд үйлчлэхээр дуудагдав.

Зимбабвегийн Булавайод томилогдсон, миний хамтрагч ахлагч Франсис Жак бид хоёр нэг идэвх султай эгчийнд айлчилж очсон юм. Түүний нөхөр өөр сүмийн шашны номлолын профессор байв. Тэр биднээс хар арьстай Африкийн үр удамд яагаад санваар олгодоггүй байсныг асууж билээ. Тэр миний урьд өмнө сонсож байгаагүй, хэцүү санагдсан олон зүйлийн талаар ярьсан. Уг өрөөнөөс гарахдаа би маш их сэтгэлээр унасан байв.

Ахлагч Жак бид хоёр юу ч ярилгүй дугуйнуудаа унан, гэр рүүгээ явав. Гэртээ очсоны дараа тэр над руу хараад, "Ахлагч Дуби, юу болсон бэ? Чиний сэтгэл зовсон харагдаж байна" гэлээ.

"Чи түүний юу хэлснийг сонсоогүй гэж үү? Нээрээ яагаад ийм зүйл болсон юм бол?" гэж би хариулав.

"Ахлагч аа, чи Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр Иосеф хүүд үзэгдсэн гэдэгт итгэдэг үү?" гэхэд нь би

"Тийм ээ. Тэгээд юу гэж?" гэж хэлэв.

"Энэ чинь л бүх зүйлийн хариулт шүү дээ. Бид илчлэлтэд итгэдэггүй гэж үү?" гэж ахлагч Жак хариулж билээ.

Би түүний үгийг болон проффесорын хэлсэн зүйлсийг бодож үзэв. Би тэр орой шөнө дунд сэрж, аз жаргал, амар амгаланг мэдэрсэн.

Сайн мэдээний асуулт бүрийн хариулт 1820 онд болсон зүйлтэй холбоотой байдаг. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр Иосеф Смитэд үзэгдсэн гэдгийг мэдэж байгаа нь тэр бол бошиглогч бөгөөд энэ бол Их Эзэний Сүм гэснийг илтгэдэг. Хэрэв Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр Иосеф хүүд үзэгдсэн л юм бол бүх сайн мэдээний зарчим, асуултууд ойлгомжтой болно. Энэ бол илчлэлтийн сүм бөгөөд Их Эзэн тодорхой цаг үед тодорхой үйл явцыг Өөрийн үйлчлэгч, бошиглогчдод илчилдэг бөгөөд энэ нь надад амар амгаланг авчирсан.

Би үсэрч дэвхцэн, хамтрагчаа сэрээгээд, "Тийм ээ, тийм! Чиний зөв байж, ахлагч Жак! Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр Иосеф хөвгүүнд үзэгдсэн. Энэ Сүм бол Их Эзэний Сүм!" гэж хамтрагчдаа хашгирах шахам хэлж билээ.

Энэ хоригийг цуцалсан нь Африк даяарх гишүүдэд адислал болсон юм. Санваар намайг, миний гэр бүлийг боломжтой бүх арга замаар адисалсан. Бид ариун сүмийн адислалуудыг хүртэж, гэр бүлээрээ мөнхөд хамт амьдрах боломжтой гэдгийг мэдсэн минь надад их хүч өгсөн юм.

Санваарыг ашиглах боломжтой болсон нь Африкийг адисалсан. Эндхийн хүмүүс аз жаргалтай, эерэг хүмүүс байдаг ч сайн мэдээ үүнийг улам бүр нэмэгдүүлсэн билээ. Гэр бүл Африкт маш чухал байр суурь эзэлдэг учраас ариун сүмийг агуу адислал гэж үздэг. Сүм энд маш хурдан өсөж байна.

Эндхийн гишүүд Бурханы хүслийг сонсоод, явж мөн үйлддэг. Энэ нь гишүүдийг адисалсаар байна. Африкийн зарим бүсэд хүн амын 90 хувьд ажилгүйдэл нүүрлэсэн байхад ч манай гишүүд бие даах чадварынхаа ачаар дажгүй сайн байгаа. Санваар ба санваарын удирдагчдаас ирдэг удирдамж биднийг адисалдаг.

Би санваар хүртэх боломжинд мөн амьдралдаа хүлээн авсан адислалуудынхаа төлөө, энэ нь Африк тив дэх гишүүдийг хэрхэн адисалсаар байгаад Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт маш их талархаж байна. ■

Ахлагч Эдвард Дуби Зимбабвед төрсөн бөгөөд эхнэр Науми болон дөрвөн хүүхдийн хамт амьдардаг.

Өсвөр үеийнхэн Английн Прэстон ариун сүмд очоод байгаа нь. 1978 оны илчлэлт газар дэлхий дээр амьдарч байсан бүх хүнд ариун сүмийн ёслолуудыг боломжтой болгосон юм.

САНВААРТ **ХҮНДЭТГЭЛТЭЙ** ХАНДАХ НЬ

Шарлотт Аккуа

1978 оны илчлэлт намайг болон гэр бүлийг маань хэрхэн адисалсан тухай

Редакторын тэмдэглэл: Энэ илчлэлтийн үр нөлөө бүх үндэстний зохистой эрчүүдэд санваарын томилгоог санал болгохоос илүү өргөн цар хүрээтэй байсан юм. Энэ нь ариун сүмийн ёслол, гэрээнүүдийн онцгой эрх, үүрэг бүхий санваарын бүхий л адислалыг бүх хүнд боломжтой болгосон. Гана дахь Сүмийн анхны гишүүдийн нэг Шарлот Аккуа энэ илчлэлт гэр бүлийг нь хэрхэн бүхэлд нь адисалсан мөн Африкт Сүм албан ёсоор байгуулагдахыг нүдээр үзэж, гэртээ санваартантай болж, ариун сүмд гэр бүлээрээ лацдан холбуулсан талаар ярьжээ.

Би ээжийгээ 1968 онд Жосеф В.Б.Жонсон ахын бүлэгт нэгдэх үед Сүмийн талаар анх удаа сонсож байж билээ.[1] Тэгэхэд би 10 орчим настай байсан. Аавын маань бизнес 1966 оны төрийн эргэлтээс болж муудсан байсан ба гэр бүл маань бэрхшээлтэй үеийг туулж байв. Тиймээс ээж маань сүнслэг тусламж эрэлхийлэх нь зүйтэй гэж үзсэн байлаа.

1978 оны илчлэлтээс өмнө хар арьстнуудад санваар олгодоггүй байсан учраас Сүм албан бус байв. Харин уг илчлэлтийн дараа Сүм санваарын эрх мэдлээр зохион байгуулагдсан. Би 1979 оны 2-р сарын 24-нд баптисм хүртсэн.[2]

Нөхөр маань Сүмд нэгдэхийн тулд 2 жилийг судалж мөн бага зэрэг мэтгэлцэж өнгөрүүлсэн юм. Тэр эцэст нь 1980 онд баптисм хүртэж, дараа нь санваар хүртсэн. Тэр маш тайван хүн болсон байсан учраас гэрийнхэн нь түүний ингэтлээ өөрчлөгдсөнд итгэж ч чадахгүй байв. Тэр санваартаа болон Их Эзэний өмнө үргэлж зөвийг үйлдэж байгаа эсэхээ бататтахын тулд хянамгай байдаг байв. Хэрэв тэр санвааргүй байсан бол олны дунд нэр хүнд, магтаал олж авах гэж хөөцөлдөх байсан гэж хэлдэг. Харин түүнд санваар байгаа учраас хамгийн чухал зүйлс бол гэрлэлт, гэр орон, гэр бүл мөн бусдад үйлчлэх явдал юм гэдгийг тэр мэддэг болсон.

Манай орны уламжлалаар эцгийн үг хууль байх ёстой байдаг. Гэвч бид санваарыг ийм арга замаар ашигладаггүй. Бид гэр бүлийн зөвлөлөөрөө хамтдаа сууж хэлэлцдэг. Эцгүүд зааж байгаа зүйлээ зөв болохыг ойлгоход нь эхнэр, хүүхдүүддээ тусалдаг.

Сүмийн гишүүн эрэгтэйчүүд эхнэрээрээ үйлчлүүлэхийн оронд тэдэнд үйлчилдэг. Энэ нь тэднийг бие биенээ хайрлаж, сэтгэл тайван байхад тусалдаг.

Би түүнийг хамгийн анх "хорионы" үед ариун ёслол адислахыг харсан. Бид энэ үед гэртээ ариун ёслолын цуглаан хийдэг байв.[3] Би тэр үед түүнийг санваар эзэмшиж байгаад нь маш их баярладаг байсан. Хэн ч бидний төлөө ариун ёслол адислахаар манайд ирэх шаардлагагүй байсан ба тэр л үүнийг хийсэн. Энэ нь онцгой зүйл байсан тул бид баяртай байв.

Хар арьстнуудад санваар эзэмшихийг зөвшөөрдөггүй талаарх ном зохиолыг би хорионы үед анх уншиж байсан ба энэ үед мормончуудын эсрэг ном зохиол нийтэд дэлгэрч байсан юм. Би Сүм үнэн гэдгийг мэддэг учраас үүнийг тийм ч их анхааралгүй. Бид өөрсдийн амьдралыг өөр хэн нэгэнд бус, харин Есүс Христ болон Түүний цагаатгах золиослол дээр төвлөрүүлэх ёстой гэж заалгадаг. Тиймээс, миний итгэл ч үүн дээр төвлөрдөг.

1996 оны 12-р сарын 17-нд бид Өмнөд Африкийн Иоханнесбург ариун сүм рүү явах боломжтой байсан. Ялангуяа би төрөөд хэдхэн өдрийн дараа нас барсан ууган хүүг минь бидэнтэй лацдан холбохыг сонсоод үнэхээр баярласан. Би түүний гэм зэмгүйг мэдэж байсан ч өнгөрчихсөн болохоор хэзээ ч харахгүй гэж боддог байв. Харин түүнийг бидэнтэй лацдан холбосон нь миний хувьд хэзээ ч мартагдашгүй сүнслэг үйл явдал байсан юм.

Иймээс хүмүүсийг биднээс хэдэн хүүхэдтэй вэ гэж асуух үед би тэдэнд найман хүүхэдтэй гэж хэлдэг. Тэднийг “Яагаад?” гэж асуухад нь би “Тийм ээ, ууган хүү маань биднийг хүлээж байгаа, тиймээс бид эргэн очиж, гэр бүлээрээ хамтдаа байхын тулд Бурханы зарлигуудад дуулгавартай дагаж амьдрах эсэх маань биднээс л шалтгаална” гэж хэлдэг.

Санваар бол Бурханы хүч юм. Би санваараар дамжуулан олон адислал хүлээн авсан. Хүүхдүүд маань аавaасаа санваарын адислал хүсэх үед би үргэлж баяртай, өөдрөг сэтгэлтэй байдаг. Тэд аавдаа итгэдэг бөгөөд Тэнгэрлэг Эцэг санваар атгаж буй аавaар нь дамжуулан ажилладаг гэдэгт итгэдгийг би мэднэ. Би гэр орондоо санваарыг хүндэтгэдэг. Одоо гурван хүү маань гэрлэж, өөрсдийн гэр оронд санваараа ашиглаж байна.

Санваар Бурханы хүч учраас үнэн гэдгийг мөн Тэнгэрлэг Эцэг амьд учраас энэ бол амьд хүч гэдгийг би мэднэ. Тэр энэхүү хүчнийхээ нэг хэсгийг газар дэлхий дээрх эрэгтэй хүүхдүүддээ өгсөн. Эмэгтэйчүүд бид санваарыг хамтран ашигладаг. Би санваарыг хүндэлдэг. Санваар манай гэр бүлд тусалсан бөгөөд тусалсаар байх болно. ■

Зохиогч нь Гана дахь Сэнтрал бүсэд амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Ганад 1960-аад оны дундуур Жосеф Виллиам Билли Жонсон Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд зэрэг судрыг олж авсан ба Сүмийн албан бус цуглаануудыг зохион байгуулах ёстойг мэдэрчээ.
2. Номлогчид 1978 оны 11-р сард анх удаа Гана руу албан ёсоор явахаар томилогдсон байна.
3. 1989 оны 6-р сарын 14-нд Ганагийн засгийн газар номлогчдыг хөөн гаргаж, Сүмийг хориглосон ч гишүүдийг гэр орондоо үйлчлэлээ үргэлжлүүлэхийг зөвшөөрчээ. 18 сарын дараа засгийн газар Сүмийг гишүүддээ засгийн газрын хуулиудад дуулгавартай байж, арьсны өнгөөр ялгаварлалгүй зохицох байдлыг хөхиүлэн дэмжихийг зааж байгаад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн бөгөөд 1990 оны 12-р сарын 1-нд Гана улсаас Сүмийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахыг зөвшөөрсөн.

ДЭЛГЭРЭНГҮЙГ ОНЛАЙНААР ОЛЖ ҮЗНЭ ҮҮ

- Илүү дэлгэрэнгүй судлахыг хүсвэл **topics.lds.org.** хаягаар орж, Gospel Topics хэсгээс “**Race and the Priesthood**” хэсгийг үзнэ үү.
- 1978 оны илчлэлт өөрсдийнх нь амьдрал, хөрвөлтөд хэрхэн нөлөөлснийг харуулсан хар арьстай хэдхэдэн гишүүний хуваалцсан хүчирхэг туршлагуудыг унш.
  —Charlotte and William Acquah (Ghana), Helvécio and Rudá Martins (Brazil), ба Joseph and Toe Freeman (USA) in “Witnessing the Faithfulness: Official Declaration 2” **lds.org/go/061820a**.
  —George Rickford (England), “I Will Take It in Faith” **lds.org/go/061820b**.
  —Victor Nugent (Jamaica), “It Was the Truth!” **lds.org/go/061820c**.
- **lds.org/go/061820f** хаягаар орж; Баруун Африкт очоод, баптисм хүртэхээр бэлтгэгдсэн олон зуун хүнийг олсон анхдагч номлогчдын зураг, видео бичлэгүүдийг үзнэ үү.

Зөв шударга эцгийн нөлөө

Би зөв шударга эцгүүдийг мөн Тэнгэрлэг Эцэгийг харснаар эцэг хүний талаар суралцсан.

Мэган Воррэн

Би эцэггүй өссөн учраас Тэнгэрлэг Эцэгийнхтэй адил хайрыг мэдрэх боломж надад байсангүй. Үүний оронд Түүний хайрыг үзүүлдэг, жинхэнэ эцэг хүний үлгэр жишээ болсон эрчүүдийг ажигласан юм. Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Жэймс Э.Фауст (1920–2007): "Журамт эцэг байх нь Тэнгэрлэг Эцэгийн бурханлаг зан чанарыг зэрвэсхэн харах боломжийг бидэнд олгодог"[1] хэмээн заасан. Хамаатан садан, Сүмийн удирдагч, судар дээрх зөвт эрчүүд, тэр ч бүү хэл хичээнгүй гэрийн багш нар зэрэг олон эцгийн үлгэр жишээгээр дамжуулан би Тэнгэрлэг Эцэгийн шинж чанар, Түүний үлгэр жишээг дагахын тулд дэлхий дээрх эцгүүдийн хөгжүүлж болох эрхэм дээд зан чанаруудын талаар суралцсан билээ. Эцэст нь би эцэггүй өссөн сэтгэлийн зовлон шаналлаа Тэнгэрлэг Эцэгтэйгээ хөгжүүлж болох ойр дотно харилцаанаас ирэх баяр баясгалангаар сольсон юм.

Хувиршгүй хийгээд түшиг тулгууртай

Тэнгэр дэх Эцэг маань өөрчлөгддөггүй. Тэрээр "өчигдөр, өнөөдөр бас үүргэлжид адил байх буюу" (Мормон 9:9) хэмээн бид уншдаг. Би дэлхий дээрх журамт эцгүүд Тэнгэрлэг Эцэгийн гуйвшгүй байдлын үлгэр жишээг дагадаг болохыг олж харсан. Журамт эцгүүд бүх зүйлд хэлсэн үгэндээ үнэнч байдаг. Тогтвортой байдал бол аюулгүй мөн хайрлагддаг болохоо мэдрэхэд түүний хүүхдүүдэд тусалдаг гэдгийг тэр ойлгодог бөгөөд хүнд хэцүү, баяр баясгалантай аль ч үед хажууд нь байдаг.

ЗОХИОГЧИЙН НӨХӨР, ОХИН ХОЁРТОЙГОО ХАМТ АВАХУУЛСАН ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЖЭСС ВОРРЭН АВАВ.

Мөн бидний Тэнгэрлэг Эцэг Өөртэй нь хамт мөнхөд амьдрахуйц зохистой байхын тулд хэчнээн их хөдөлмөрлөх хэрэгтэй гэдгийг ойлгодог. Тэрээр биднийг нэрээр маань мэддэг бөгөөд биднийг цэвэршүүлэхийн тулд саад бэрхшээлийг өгдөг. Дэлхий дээрх журамт эцгүүд ч мөн адил зовлон бэрхшээл өсөж хөгжих боломж олгодог гэдгийг мэддэг учраас зарим үед хүүхдүүддээ зовлон гэж юу болохыг мэдрүүлдэг.

Нөхөр маань зодооны урлагийн чадварлаг тамирчин. Аав нь түүнд зааж өгсөн бөгөөд тэр түүнд бусад суралцагчаас илүү хатуурхдаг байсан талаар үргэлж ярьдаг. Аавынх нь хүмүүжил түүнийг хүчирхэгжүүлж, харьцангүй богино хугацаанд ахиц гаргахад тусалжээ. Журамт эцгүүд бидний Тэнгэрлэг Эцэгийн адил хүүхдүүдээ хүчирхэгжүүлж, хайрлан, дэмжихийн зэрэгцээ хамгийн сайнаараа хийхэд урамшуулан дэмждэг.

"Эцэс төгсгөлгүй ажил"

Тэнгэрлэг Эцэгийн маань ажил мөнхийн хийгээд эцэс төгсгөлгүй (Алма 12:25–33-ийг үзнэ үү). Үүнтэй адил журамт эцгүүдийн ажилд ч эцэс төгсгөл гэж үгүй. Журамт эцгүүд үргэлж сайн үйлийг хийж, зөв шударга байхыг хичээдэг. Тэд Бурханы зарлигуудыг шударга, үнэнчээр дагадаг. Тэд бас хувийн ашиг сонирхлоо гэр бүлийнхээ сайн сайхны төлөө хойш тавьдаг. "Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг"-т амьд бошиглогчид "Тэнгэрийн загвараар эцэг нь гэр бүлээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, хэрэгцээт зүйлсээр нь хангаж, хамгаалах үүрэгтэй"[2] хэмээн заасан. Үүнд биеэрээ хамгаалахаас гадна сүнслэг байдлын хувьд хамгаалах нь ордог. Журамт эцгүүд үлгэр жишээгээрээ удирддаг ба үр хүүхдүүдээ хайрлаж, тэдэнд зөвлөгөө өгдөг. Тэд мөн шаардлагатай үед сүнслэг аюулын эсрэг сэрэмжлүүлдэг.

Хүч чадал өгдөг гэр бүлийн түүхүүд

Брүс Филэр *New York Times* дээрх "The Stories That Bind Us" буюу "Биднийг холбодог түүхүүд" нийтлэлдээ гэр бүлүүд устаж үгүй болж байгаа талаарх судалгаануудыг товч танилцуулжээ. Тэдгээр судалгаагаар бол дасан зохицох чадвар сайтай хүүхдүүд өөрсдөөсөө агуу том зүйлийн нэгэн хэсэг гэдгээ мэдрэхэд тусалж, хүч чадал өгдөг гэр бүлийн түүхээ сонсдог байсныг тогтоосон байна. Филэрийн хэлснээр "Хэрэв та аз жаргалтай гэр бүлтэй болохыг хүсэж байвал гэр бүлийнхээ сайн сайхан үйл явдлууд болон хүнд хэцүү үеийг давж гарах чадварынхаа талаарх түүхийг бий болгон, сайжруулж, уламжлан ярь. Таны энэхүү ганцхан үйлдэл гэр бүлийн тань ирээдүйд үе үеэрээ цэцэглэн хөгжих магадлалыг нэмэгдүүлж магадгүй."[3]

Үүний жишээг Мосе 1-ээс харж болно. Мосе Бурханы төлөвлөгөө болон өөрийнхөө тэнгэрлэг мөн чанарын талаарх мэдлэгээр хүчирхэгжиж байсан. Сатан Мосе дээр ирэн сориход тэрээр гуйвалгүй, "Чи хэн бэ? Учрыг болгоогтун, түүний Төрсөн Ганцын адил Бурханы хүү байна би; мөн бибээр чамайг шүтэх ёстой тэр алдар суу чинь хаана байна?" (Мосе 1:13) хэмээн асуусан билээ. Тэр ч бүү хэл Мосе Сатанд зайл хэмээн тушаах зоригтой байсан.

Дэлхийн журамт эцгүүд хүүхдүүддээ Бурханы сүнслэг хүүхдүүдийн хувьд өөрсдөд нь байх бурханлаг мөн чанарыг сануулан хүчирхэгжүүлдэг. Тэд өөрсдийн сайн үлгэр жишээгээр мөн хүүхдүүдээ үүнд татан оролцуулахад анхаарснаар хүчтэй гэр бүлийг бий болгоход тусалдаг. Энэ нь хүүхдүүдийг нь өмнөө зорилготой мөн амжилтад хүрнэ гэдэгтээ итгэх итгэлтэй болгодог.

Журамт нөхрийг хайх

Би болзож байхдаа журамт эцэг болох мөнхийн ханиа хайж байсан. Хүүхэд байхдаа тийм үлгэр жишээ болчих хүнгүй өссөн учраас буюу дэлхийн журамт эцэгт байх ёстой зан чанарыг мэдэхгүй байсан тул надад хэцүү байв. Патриархын адисалд минь Тэнгэрлэг Эцэгийн гэрлээсэй гэж хүссэн хүний талаар ямар ч нарийн ширийн удирдамж байгаагүйд миний урам хугарч билээ. Тэнд зөвхөн намайг ариун сүмд авч орох хэн нэгнийг л хайж олох хэрэгтэй гэж хэлсэн байв. Ийм энгийн мэт зааврыг хүртэл дагахад хэцүү байлаа. Хэдийгээр би хэд хэдэн сайхан болзоонд явсан ч тийм хүн огт байдаггүй эсвэл сэтгэл зүрхэндээ тоолохын аргагүй олон шархтай болно байх хэмээн дотроо байнга санаа зовдог байсан юм.

Хэдийгээр сэтгэл түгшүүртэй байсан ч би хүүхдүүддээ зөв шударга эцэг нь байж, тэднийгээ хайрладаг, амьдралд нь үргэлж хамт байдаг нөхөртэй болохын төлөө залбирсаар байв. Би итгэлтэй ээжийнхээ адил юу ч болсон бай, Мөнхийн Эцэгээсээ тусламж дэмжлэг авах боломжтой гэдгээ мэддэг байсан.

Намайг гайхшируулж, баярлуулсан зүйл бол Тэнгэрлэг Эцэг яг тохирсон цаг хугацаанд миний залбиралд хариулсан явдал байв. Эцэг хүн ямар байх ёстой гэдгийн үлгэр

Зохиогч нөхөр, охин хоёрынхоо хөргийг усан будгаар зурсан нь. Амьдрал дахь эцэг хүний үлгэр жишээ байсан гэрийн багш нь түүнд уран зургаар хичээллэх сэдлийг төрүүлсэн байна.

жишээг хайртай нөхрөөсөө олж харах нь сэтгэлийн минь шархыг эдгээж байна. Тэр бошиглогч, төлөөлөгчдийн харуулсан үлгэр жишээгээр намайг харамгүй нандигнан хайрладагт би талархдаг. Намайг хайрладаг нөхрийн минь үлгэр жишээ хүүхдүүдийг маань ч бас адисалдаг. Сорилт бэрхшээлд итгэлтэй байж, шаргуу хөдөлмөрийн үлгэр жишээг үзүүлэн, санваарыг ашиглах зохистой байж, залуу эцгийн хувьд үзүүлдэг гуйвшгүй хайр халамжинд нь би сэтгэл зүрхэндээ талархдаг.

Бидний эргэн тойронд байх эцгүүд

Мосегийн адил өөрийгөө хэн гэдгийг ойлгодог хүний үзүүлэх нөлөөнд хил хязгаар гэж үгүй. Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх байсан Шэри Дью эгч асарч халамжилдаг бүх эмэгтэй эх хүн болоогүй ч эх хүний үүргийг гүйцэтгэдэг хэмээн заасан. Тэрээр "*Бид бүгд Израилийн эх* бөгөөд өсөн өндийж буй үеийнхнийг мөнх бус амьдралын аюултай гудамжаар явахад нь хайрлаж, удирдан залахад нь туслах нь бидний дуудлага билээ"[4] хэмээн гэрчилсэн. Зөв шударга үлгэр жишээ болсон эрчүүд Израилийн эцгийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд тэдний зөвт үлгэр жишээ гэр бүлийнх нь хүрээнээс гадуур үйлчилдэг байна.

Бага насандаа туулсан зовлон бэрхшээлийн дараа мөнхийн ханьдаа итгэж найдахын тулд надад яг юу хэрэгтэй байсныг Тэнгэрлэг Эцэг мэдэж байсан гэдэгт би итгэдэг. Тэр миний амьдралд эцэг хүний гуйвшгүй олон үлгэр жишээг харуулсан. Тэдний дунд Их Эзэнийг хайрладаг зөв шударга өвөө мөн гэр бүлийн маань санхүүгийн бэрхшээлийг ойлгож, намайг өөрийн урланд авч сурган, өөрийнх нь мэргэжлээр замнах сэдлийг надад төрүүлсэн хичээнгүй гэрийн багш минь байсан билээ. Залуу насандаа би гэнэт адислагдаж, зөв шударга хойд аавтай болсон маань бурханлаг илааршлыг авчрахад мөн тусалсан. Тэр эцэг хүнийх нь хувьд итгэхдээ эргэлзэхэд тэвчээртэй байж, надад үргэлж сайхан ханддаг байсан.

Эдгээр эцэг хүний нөлөөнөөс би найдвар, илааршил, баяр баясгаланг олсон билээ. Би Тэнгэр дэх Эцэгийн үзүүлсэн үлгэр жишээг дагадаг мөн журамт эцгийн үлгэр жишээ болохыг хичээдэг эрчүүдэд талархдаг. ■

Зохиогч нь АНУ-ын Калифорни мужид амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. James E. Faust, "Them That Honour Me I Will Honour," *Liahona,* July 2001, 54.
2. "Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг," *Liahona,* May 2017, 145.
3. Bruce Feiler, "The Stories That Bind Us," *New York Times,* Mar. 15, 2013, nytimes.com.
4. Sheri L. Dew, "Are We Not All Mothers?" *Liahona,* Jan. 2002, 113.



Арван хоёр
Төлөөлөгчийн Чуулгын
**Ахлагч Жэффри Р.
Холланд**

“Нэг нэгнийхээ ачааг үүрэлцэх нь”

2017 оны 6-р сард ХҮГ-ийн Гэр бүлийн үйлчлэлийн ажилтнуудад хандаж хэлсэн үгнээс. Ахлагч хэлсэн үгийнхээ энэ хувилбарыг олон хүнд хүргэх зорилгоор өөрчилсөн болно.

Есүс Христийн шавь нар “бүгд энэрэнгүй” (1 Петр 3:8) байх ёстой хэмээн төлөөлөгч Петр бичсэн. Та нарын олонх нь энэ зарлигийг амьдралдаа өдөр бүр нэр хүндтэй, бахархмаар сайн биелүүлдэг. Өнөөдөр бусдыг энэрэн хайрлах хэрэгцээ хэзээ хэзээнээс илүү болоод байна. Сүүлийн үеийн статистик үзүүлэлтээр Нэгдсэн Улсын насанд хүрэгчдийн таван хүний нэг нь (ойролцоогоор 43,8 сая хүн) жил бүр сэтгэцийн өвчинд нэрвэгддэг гэжээ.[1] Порнограф хүчээ авч, зөвхөн 2016 онд л гэхэд ганцхан вэбсайт 23 тэрбум хандалттай байсан аж.[2] “Нэгдсэн Улсад элэг бүтэн гэр бүлийн тоо огцом буурч байхад гэр бүл салалт, . . . хамтран амьдрагчид, [гэрлэлтээс гадуурх төрөлтийн] тоо ихэсчээ. . . . Өнөөдөр амжилттай арван төрөлтийн дөрөв нь ганц бие эмэгтэй эсвэл гэрлээгүй эцэг эхэд төрж байна.”[3]

Аврагчийн хүмүүс хэмээн нэрлэгдэж, Түүний Сүмд байхын тулд бид “нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд үүрэлцэхэд бэлэн байв; Тийм ээ, мөн гашуудах тэдний хамт гашуудахад; тийм ээ, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулахад, мөн ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч” (Мозая 18:8–9) байх ёстой.

Миний хувьд бусдын ачааг үүрэлцэнэ гэдэг нь Есүс Христийн Цагаатгалын энгийн боловч хүчирхэг тодорхойлолт юм. Бид бусдын ачааг үүрэлцэхийг эрэлхийлснээр “Сион уулан дээрх аврагчид” (Обадиа 1:21) болдог. Бид өөрсдийгөө дэлхийн Гэтэлгэгч болон Түүний Цагаатгалтай бэлгэдэл хэлбэрээр мөр зэрэгцүүлж байгаа хэрэг. Бид “шаналсан

Хэдийгээр бид аяллыг өөрчилж чадахгүй байж болох ч хэнийг ч орь ганцааранг явуулахгүй байхад анхаарч болно. Нэг нэгнийхээ ачааг үүрэлцэх гэж үүнийг л хэлнэ.

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ
ЗУРГИЙН ХЭСГЭЭС ХРИСТ БА САА ӨВЧТЭЙ ХҮН, Ж.КӨРК РИЧАРДСЫН

Бид бусдын ачааг үүрэлцэхийг эрэлхийлснээр "Сион уулан дээрх аврагчид" болдог буюу өөрсдийгөө дэлхийн Гэтэлгэгч болон Түүний Цагаатгалтай бэлгэдэл хэлбэрээр мөр зэрэгцүүлж байгаа хэрэг.

зүрхтэй хүмүүсийг эдгээн, олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглаж, хүлээстэй хүмүүсийг чөлөөл[ж байгаа хэрэг]" (Исаиа 61:1).

Бусдын зовлонг ойлгодог бурханлаг чанар

Христийн Цагаатгалын энэ чанарын талаар үргэлжлүүлэн хэлэлцэцгээе. Хэрэв би сургаалыг зөв ойлгосон бол Цагаатгалын үйл явцад Есүс Христ Адам, Ева хоёроос эхлэн дэлхийн төгсгөл хүртэлх бүх хүн төрөлхтний ачааг буюу гэм нүгэл, харуусал гуниг, зовлон бэрхшээл, унагасан нулимсыг өмнөөс нь үүрсэн билээ. Үүнийг хийхдээ Тэр Өөрөө нүгэл үйлдээгүй ч нүгэл үйлдсэн хүмүүсийн зовлон, үр дагавар ямар байдгийг мэдэрсэн. Хэдийгээр Тэр өөрөө гэр бүл салалтыг үзээгүй ч гэр бүл салж байсан хүмүүсийн зовлон, үр дагавар ямар байдгийг мэдэрсэн. Тэр бэлгийн хүчирхийлэл, шизофрени, хорт хавдар эсвэл хүүхдээ алдахыг өөрийн биеэр үзээгүй ч ийм зүйл тохиолдсон хүмүүсийн зовлон, үр дагавар гэх мэт урт жагсаалт бүхий амьдралын хүнд ачаа, сэтгэл зүрхний шархыг мэдэрсэн билээ.

Цагаатгал хэрхэн ажилладаг тухай ойлголт нь дэлхий дээр *бусдын зовлонг ойлгодог чанарын* цорын ганц бурханлаг үлгэр жишээ болохыг харуулдаг. Мэдээж ертөнцийн хамгийн чухал үйлдлийг ямар ч үгээр бүрэн илэрхийлэх боломжгүй ч өнөөдөр надад үүнээс илүү сайн арга зам байхгүй тул би үгээр илэрхийлье.

Бусдын зовлонг ойлгодог чанарыг "өнгөрсөнд байсан буюу одоо цагт байгаа хэн нэгнийг ойлгож . . . мөн түүний мэдрэмж, бодол, туршлагыг өмнөөс нь мэдрэх үйлдлийг хэлнэ"[4] хэмээн тодорхойлжээ. Дээр дурдсанаар "өмнөх," "одоо" гэдэг дээр "ирээдүйг" нэмэх юм бол энэ нь үнэндээ цагаатгах үйл явцын талаар боломжийн тайлбар болох юм.

Бурханы олон хүүхэд чимээгүй, ганцаар зовж шаналж байгаа гэдгийг бид бүгдээрээ мэднэ. Жишээлбэл, нэг залуу захидалдаа өөрийн гэрчлэлийг гайхалтай уран үгээр илэрхийлснээ, ижил хүйстэндээ татагддаг хүний хувьд ямар ч өсөлт хөгжил, ирээдүйн баяр баясгалан байхгүй гэж бодоход сэтгэл зүрх нь шимширдэг талаар нэмж бичсэн байлаа.

"Би насан туршдаа ганцаардмал шөнө, гунигтай жихүүн өглөөг өнгөрүүлэх болно. Би ганц бие залуучуудын тойрогтоо үнэнчээр очдог бөгөөд долоо хоног бүр сүмээс явахдаа тэнд үнэхээр таарахгүй юм байна гэдгээ мэдэрдэг. Би хэзээ ч хүүдээ дугуй унахыг зааж чадахгүй. Бяцхан охин минь хөлд ороходоо миний хуруунаас барихыг би хэзээ ч мэдрэхгүй. Би хэзээ ч ач зээтэй болохгүй.

Өдрөөс өдөрт, сараас сард, хэдэн арван жил өнгөрсөн ч намайг хүйтэн хоосон гэр угтаж, зөвхөн Христэд найдах найдвар л торгооно. Заримдаа яагаад Тэр намайг ийм болгож, байж боломгүй золиослол гаргахыг надаас хүсэж байгаа юм бэ гэж би боддог. Шөнө дөлөөр, хэн ч байхгүй үед би уйлдаг. Би үүнийг хэнд ч, ээж аавдаа ч хэлээгүй. Тэд мөн найз нөхөд маань . . . мэдэх юм бол надаас өмнө энэхүү замыг туулж байсан бусад хүнээс нүүр буруулсан шигээ надаас мөн нүүр буруулна. Би үргэлж бусдаас өөр, зааг ирмэг дээр амьдрах болно. Би ганц бие байгаагийнхаа төлөө доромжлуулах бөгөөд бусад хүн надаас цэрвэх болно эсвэл учир шалтгаанаа хэлснийхээ төлөө өрөвдүүлж, үл тоомсорлогдох болно. Амьдрал надад бүүдгэр харагдаж байна. Гилеадад ямар ч гавар байхгүй гэж үү?"[5]

Ийм их зовлон шаналал, гуниг гутрал мөн мухардалд орсон хүнд ганцаараа биш гэдгийг нь ойлгуулахын тулд хичээл зүтгэл гаргах нь бидний зүгээс гарцаагүй хийж чадах зүйлийн нэг юм. Бурхан ч, тэнгэр элчүүд ч мөн бид ч гэсэн түүнтэй хамт байна гэдгийг түүнд байнга онцлон хэлж байх ёстой.

Ж.КӨРК РИЧАРДС, *"ЭДГЭЭГДСЭН ЭМЭГТЭЙ"*, ЗУРГИЙН ХЭСЭГ

Бусдын зовлонг ойлгодог чанар. Хангалттгүй мэт сонсогдож байж болох ч үүнээс эхэлж болно. Хэдийгээр бид аяллыг өөрчилж чадахгүй байж болох ч хэнийг ч орь ганцааранг явуулахгүй байхад анхаарч болно. Нэг нэгнийхээ ачааг үүрэлцэх гэж яг үүнийг л хэлнэ. Тэд *чинь* ачаа шүү дээ. Мөн мөнх бус амьдралд тэдгээр нь хэзээ үүрэгдэх эсвэл бүр үүрэгдэх үгүйг хэн ч хэлж мэдэхгүй. Гэхдээ бид хамтдаа алхалж, ачаагаа үүрэлцэж болно. Есүс Христ биднийг өргөн дэмждэгийн адил бид ч гэсэн ах, эгч нараа өргөн дэмжиж чадна (Алма 7:11–13-ыг үзнэ үү).

Энэ бүхнээр дамжуулан бид Аврагчийн бидний төлөө хийсэн зүйлийг өөр өнцгөөс, өөдрөгөөр харж талархах болно. Өмнө нь хэлж байснаар:

"Юуны өмнө эдгээр хүнд асуудлын талаар бага ч болов сэтгэлийн тайтгарал, ойлголтыг олж авахыг эрэлхийлэхдээ, бурхантай адил болох гэсэн бидний эрэл хайгуул тэнгэрлэг төлөвлөгөөний дагуу ахин дахин соригдож, шалгагдах ёстой унасан ертөнцөд амьдарч байгаа буюу амьдрахаар сонгосон гэдгээ бид санаж байх нь нэн чухал билээ. Үүнийг хийхэд Аврагчийг илгээсэн Эцэг болон ирсэн Хүү хоёрын төлөөс хэмжээлшгүй их байсан ч Бурханы төлөвлөгөөн дэх хамгийн агуу баталгаа нь Түүнд итгэх итгэлийнхээ хэмжээгээр шалгуур, сорилтуудыг ялгуусан байдалтайгаар даван туулахад бидэнд туслах Аврагч, Гэтэлгэгч амлагдсан явдал юм. Энэхүү бурханлаг хайрын тухай ойлголт нь биднийг өөрсдийн өчүүхэн зовлонг эхлээд тэвчиж чадахуйц, дараа нь ойлгож чадахуйц, эцэст нь ариусгахуйц болгодог билээ."[6]

Бидний чадлаараа, амь бие хайрлалгүй үзүүлсэн үйлчлэл хүмүүсийн хүсэн хүлээснээр хангалттай тайтгаруулж, урам зориг өгөхгүй байгааг маш хурдан ухаардаг. Эсвэл нэг удаа чадсан зүйлээ дахин хийж чадахгүй байж болно гэдгээ мэддэг. Эсвэл бүр бид анхаарал халамж тавьдаг хүмүүсээ хуучин байдалдаа эргэж орохоос нь урьдчилан сэргийлдэг супер баатрууд биш гэдгээ ойлгодог. Иймээс бид эцсийн эцэст Есүс Христэд хандаж, Түүнд найдах ёстой (2 Нифай 9:21-ийг үзнэ үү).

Ихэвчлэн бид тусалж чаддаггүй буюу бүр байг гэхэд тусламжаа үргэлжлүүлэн үзүүлж чаддаггүй, эсвэл заримдаа хийж чадсан зүйлээ дараа нь дахиад хийж чаддаггүй. Харин Христ тусалж чадна. Бурхан Эцэг тусалж чадна. Ариун Сүнс ч тусалж чадах бөгөөд бид Тэдний төлөөлөгчид болохыг үргэлжлүүлэн хичээж, чадах газраа, боломжтой цагтаа тусалж байх хэрэгтэй.

Өөрийгөө дахин хүчирхэгжүүл

Бусдын ачаанаас үүрэлцэхийг чин сэтгэлээсээ эрэлхийлдэг хүмүүст хандан хэлэхэд та нараас хүмүүс ихийг шаардаж, үнэхээр ихийг авсны дараа өөрсдийгөө дахин хүчирхэгжүүлж, эргүүлэн хөл дээрээ босгох нь чухал юм шүү. Хэзээ ч ядарч, бухимддаггүй, өөртөө анхаарал

Бусдын ачааг үүрэлцэхдээ үзүүлдэг бидний үйлчлэл амин чухал буюу өөрөөр хэлбэл Эзэний ажил билээ.

халамж тавих хэрэгтэй гэдгээ анзаардаггүй тийм хүчтэй хүн гэж байдаггүй. Есүс ядарч, хүч нь суларч байгааг мэдэрч байсан. Тэрээр зөвхөн өгч байсан ба энэ нь өөрийн гэсэн үнэ цэнтэй байсан бөгөөд олон хүн Түүнд тулгуурлаж байсны нөлөөг Тэр ч бас мэдэрсэн. Цус алддаг өвчтэй байсан нэгэн эмэгтэй олны дунд Түүнд гар хүрэхэд нь Тэрээр уг эмэгтэйг эдгээсэн ч "Өөрөөс нь хүч гарсныг мэд[сэн]" (Марк 5:25–34-ийг үзнэ үү).

Галилийн тэнгисийн маш хүчтэй, ширүүн шуурганы үеэр, бүр туршлагатай загасчин шавь нар нь хүртэл завиа живэх нь хэмээн бодож байхад Түүнийг унтаж байсан гэдгийг унших надад гайхалтай санагддаг. Тэр ямар их ядарсан байсан бол? Та толгойгоо ч өргөх чадалгүй болтлоо хэдэн сургаал номлож, хэдэн адислал өгч чадах вэ? Асарч халамжлах хүмүүсийг ч гэсэн асран халамжлах хэрэгтэй. Та бусдад хуваалцахын тулд өөрийн саванд түлштэй байх ёстой.

Розалин Картэр гэдэг асрамжийн институтийн зөвлөлийн ерөнхийлөгч Розалин Картэр нэг удаа "Энэ дэлхий дээр асарч халамжилдаг байсан, одоо асарч халамжилж байгаа, ирээдүйд асарч халамжлах мөн асран халамжлагч хэрэгтэй гэсэн дөрөвхөн төрлийн хүмүүс байдаг"[7] хэмээн хэлсэн.

Мэдээж, "асрагч, асруулагч хоёрын хоорондын харилцаа [чухал бөгөөд бүр] ариун юм."[8] Гэхдээ бид нэг нэгнийхээ ачааг үүрэлцэхдээ бэрхшээлтэй тулгарвал бидний хэн нь ч асран халамжилдаг хүнийхээ өвчин зовлонг ойлгохын нөлөөллөөс зайлсхийж чадахгүй гэдгийг санах хэрэгтэй.

Тэнцвэртэй байлгахыг эрэлхийл

Асрагчийн үүргээ ажил төрөл, гэр бүл, харилцаа холбоо, дуртай үйл ажиллагаа гэх мэт амьдралынхаа бусад талтай тэнцвэртэй байлгах арга замыг хайж олох нь чухал. Энэ сэдвээр Ерөнхий чуулган дээр хэлсэн үгэндээ би "их зүйлийг хийдэг, бусдад санаа тавьдаг, мөн 'сайныг хийх хүсэлтэй' хөдөлмөрлөдөг бүх хүнийг хүндэлж явдгаа илэрхийлэх гэсэн юм. Өгөөмөр хүмүүс их бий. Та нарын зарим нь амьдралдаа [сэтгэл санааны мөн санхүүгийн асуудалтай] байгаа ч [бусадтай] хуваалцах ямар нэгэн зүйл олдог. Хаан Бенжамин хүн өөрт нь буй хүчнээс илүү хурдан гүйх шаардлагагүй бөгөөд бүх зүйл эмх цэгцэнд хийгдэх ёстой (Мозая 4:27)"[9] хэмээн өөрийн хүмүүст анхааруулсан. Ийнхүү хэлсэн байтал та нарын дунд олон хүн маш хурдан гүйж, энерги болон сэтгэл ханамжийн үзүүлэлт тань заримдаа тэг дээр очсон байдгийг би мэднэ.

Асуудал хэт том мэт санагдах үед Дэвид Баттигийн бичсэн эссэний дараах мөрийг санана уу. Тэрээр:

"Найдвар нь мэдрэмж биш юм. Энэ нь асуудлын дунд мэдрэгддэг баяр баясгалан ч биш.

. . . Мөн найдвар нь асуудлыг алга болгодог шидэт саваа биш. Найдвар нь таныг амьдралын шуурганд цөхрөхөөс сэргийлдэг аврах татлага юм.

Есүст найдсанаар та өөрийг тань хэзээ ч орхиж, хаяхгүй мөн таны сайн сайхны төлөө бүхнийг хийнэ гэсэн Түүний амлалтад итгэж байна гэсэн үг. Хэдийгээр та маш том асуудал дунд байсан ч найдвар нь Есүс алхам бүрд тантай хамт байна гэдгийг мэдэж, амар тайван байх боломжийг олгодог"[10] гэжээ.

Паулын энэ асуудал, шаардлагыг хангахгүй байна гэсэн мэдрэмжээ хэрхэн шийдвэрлэсэн нь надад таалагддаг. Их Эзэн судруудад Түүний нигүүлсэл Паулд хангалттай бөгөөд үнэндээ Түүний хүч "мөхөс байдал дотор . . . бүрэн төгс

Ж.КӨРК РИЧАРДС, *"ТЭРЭЭР ОЛНЫГ ЭДГЭЭСЭН"*, ЗУРГИЙГ ХЭСГЭЭС

болно" гэдгийг тайлбарласан. Дараа нь Паул: "Иймд би ихэд баяртайгаар мөхөс байдлуудаараа илүү сайрхана. Ингэх нь Христийн хүч миний дотор оршихын тулд билээ" (2 Коринт 12:9)[11] хэмээн бичсэн байдаг.

Эцэг болон Хүүд найд

Та санаа тавьдаг хүмүүстээ хэрхэн хандлагатай яг адил Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр бидэнд болон бидний хийж буй зүйлсэд үнэхээр санаа тавьдаг, мөн Тэд биднийг "мөхөс байдал дотор төгс болгохыг" хүсдэг гэдэгт бид итгэж найдах ёстой.

Бурхан бидний ачааг мэдэх бөгөөд бусдыг хүчирхэгжүүлэхэд биднийг хүчирхэгжүүлнэ гэдгийг би гэрчилж байна. Энэ нь бидний асуудлууд үргэлж үгүй болно эсвэл дэлхий ертөнц гэнэт амар тайван болно гэсэн үг биш юм. Гэхдээ энэ нь та нарын залбирлыг мөн бэлэвсэрсэн, салсан, мөн ганцаардсан, цөхөрсөн, донтсон, өвчилсөн, найдвараа алдсан буюу бүх хүний залбирлыг сонсохгүй гэсэн үг биш ээ.[12]

Ах, эгч нар аа, бусдын ачааг үүрэлцэхдээ үзүүлдэг бидний үйлчлэл амин чухал буюу өөрөөр хэлбэл Эзэний ажил билээ. Ажил дээрээ хүлээн авдаг захидлын тоо хэчнээн их тусламж хэрэгтэй байгааг надад нотолдог. Тэрхүү тусламж нь саад бэрхшээлтэй тулгарч байгаа хүмүүсийн хувьд тэнгэрээс бууж ирсэн маннатай адил юм.

Би өмнө нь "Гэвч бид Бурханы мутарт зэмсэг болдог хүмүүсийн тухай ярихдаа тэнгэр элчүүд бүгдээрээ сүнсний дэлхийгээс болон тэнгэрээс ирдэггүйг санах ёстой. Тэдний зарим нь өдөр бүр бидэнтэй хамт алхлан, ярьж хөөрч явдаг. Зарим нь бидэнтэй хөрш зэргэлдээ амьдардаг. Мөн зарим нь бидэнд хүүхэд төрүүлж өгдөг ба миний хувьд л гэхэд тэдний нэг нь надтай гэрлэхийг зөвшөөрсөн юм. Хүмүүсийн нинжин сэтгэл, бие сэтгэл бүхнээ зориулсан зан чанарт илэрхийлэгдсэн Бурханы хайрыг бид харахад, тэнгэр хэзээ ч ийм ойрхон байгаагүй юм шиг санагддаг. Хүмүүс ийм сайхан, ийм цэвэр ариун байгаа үед л "*тэнгэр элч шиг*" гэсэн үг санаанд орж ирдэг"[13] гэж хэлж байсан.

Миний хувьд та нар бусдын ачааг хөнгөлөх гэж хичээхдээ жинхэнэ утгаараа нигүүлслийн тэнгэр элч болдог билээ. Та нарын өгөх гэсэн бүх зүйл зуу дахин нэмэгдэж ирэх болтугай. ■

ЭШЛЭЛҮҮД

1. "Mental Health by the Numbers," National Alliance on Mental Illness, nami.org-ийг үзнэ үү.
2. "World's Largest Porn Site Reveals the Most-Searched Porn Genre of 2016," Fight the New Drug, Jan. 9, 2017, fightthenewdrug.org.
3. "Parenting in America," Pew Research Center, Dec. 17, 2015, pewsocialtrends.org; see also D'Vera Cohn and Andrea Caumont, "10 Demographic Trends That Are Shaping the U.S. and the World," Pew Research Center, Mar. 31, 2016, pewsocialtrends.org-ийг үзнэ үү.
4. *Merriam-Webster's Collegiate Dictionary,* 11th ed. (2003), "respect."
5. Хувийн захидал
6. Жэффри Р.Холланд, "Хагарсан сав шиг," *2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 46–49.
7. Rosalynncarter.org/UserFiles/Jensen.pdf; see also Rosalynn Carter, in Randi Kaplan, "How to Care for the Caregiver," May 13, 2015, health.usnews.com-ийг үзнэ үү.
8. Nancy Madsen-Wilkerson, "When One Needs Care, Two Need Help," *Ensign,* Mar. 2016, 38.
9. Jeffrey R. Holland, "A Handful of Meal and a Little Oil," *Ensign,* May 1996, 31.
10. David Batty, "Finding Hope in the Midst of Life's Problems," livingfree.org.
11. Anne C. Pingree, "Making Weak Things Become Strong," *Ensign,* Dec. 2004, 28–30-ийг үзнэ үү.
12. Dallin H. Oaks, "He Heals the Heavy Laden," *Liahona,* Nov. 2006, 6–9-ийг үзнэ үү.
13. Жэффри Р.Холланд, "Тэнгэр элчүүдийн үйлчлэл," *2008 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 35.

4-Р БҮЛЭГ

Сэргэг бай

Энэ бол "Гэгээнтнүүд: Хожмын үеийн Есүс Христийн Сүмийн түүх" нэртэй Сүмийн шинэ дөрвөн боть түүхэн өгүүллийн *номын 4-р бүлэг юм. Уг ном 14 хэл дээр хэвлэгдэн гарах бөгөөд Gospel Library аппликэйшны Сүмийн түүх хэсэгт болон гэгээнтнүүд.lds.org дээр тавигдана. Энэ оны сүүлээр уг номын 1-р боть хэвлэгдэн гарах хүртэл дараагийн хэдэн бүлгийг ирэх дугаарууддаа нийтлэх болно. Тэдгээр бүлэг нь Gospel Library аппликэйшн болон гэгээнтнүүд.lds.org вэбсайт дээр 47 хэлээр тавигдах юм.*

Хорин нэгэн настай Эмма Хэйл анх Иосеф Смитийн талаар 1825 оны намар түүнийг Жозайя Стоуэллынд ажиллахаар ирэхэд нь сонсжээ. Жозайя эдлэн газарт нь булаастай байгаа эрдэнэсийг олоход туслуулахаар залуу эрийг аавынх нь хамт хөлсөлж авчээ.[1] Хэдэн зуун жилийн өмнө хэсэг хайгуулч уг газраас мөнгөний орд илрүүлж, нуусан эрдэнэсийг ухаж гаргасан гэх нутгийн хууч яриа байдаг байжээ. Жозайя Иосефыг үзмэрчийн чулуунууд ашигладаг авьяас чадвартай гэдгийг мэдэх тул түүнийг эрэл хайгуулд нь тусалбал сайн хөлс өгч, олсон зүйлээсээ хувь хүртээхээр санал болгов.[2]

Эммагийн аав Исаак уг аз туршсан саналыг дэмжив. Иосеф аавтайгаа хамт Палмирагаас урагш 240 орчим км зайд орших Пеннсильванийн Хармони тосгон дахь Стоуэллын фермд ирж, гэрээнд гарын үсэг зурахад Исаак гэрчээр оролцов. Мөн тэрээр ажилчдыг өөрийнхөө гэрт амьдрахыг зөвшөөрчээ.[3]

Эмма удалгүй Иосефтой танилцав. Иосеф түүнээс дүү байсан бөгөөд 1.8 метр гаруй өндөртэй, хүнд хүчир ажилд сурамгай нэгэн мэт харагдаж байлаа. Тэр цэнхэр нүдтэй, цайвар царайтай, үл ялиг доголж явдаг байв. Түүний хэл яриа нь сайн биш, заримдаа өөрийгөө илэрхийлэхдээ хэт нуршуу үг ашигладаг ч ярих нь эрүүл ухамсартай байдлыг нь харуулдаг байлаа. Иосеф болон түүний аав Эммагийн гэр бүлийнхэнтэйгээ хамрагддаг байсан сүмд явахын оронд хувиараа шүтэн биширэхийг илүүд үздэг сайн хүмүүс байв.[4]

ЖОН МАКНООТОН, *КУМОРА ГУВЭЭ*

Иосеф, Эмма хоёр хоёулаа гадаа нар салхинд байх дуртай байлаа. Эмма хүүхэд байхаасаа морь унах, гэрийнхээ ойролцоох голд хөнгөн завиар явах дуртай байжээ. Иосеф морь унахдаа сайн биш ч барилдах, бөмбөгтэй тоглоом тоглоход гарамгай байлаа. Тэр хүмүүстэй эв найртай байж, байнга инээмсэглэн, үргэлж хөгжилтэй түүх ярьж, хошигнодог байв. Эмма илүү даруу боловч сайхан хошигнолд дуртай, хэнтэй ч ярьж чаддаг мөн унших, дуулах дуртай байв.[5]

Өдөр хоног өнгөрсөөр Эмма Иосефыг илүү сайн мэддэг болоход түүний эцэг эх тэдний харилцаанд санаа зовниж эхлэв. Иосеф өөр мужаас ирсэн ядуу ажилчин байсан учир тэд охин нь түүнийг сонирхохоо болиод, нутгийнхаа чинээлэг гэр бүлүүдийн нэгэнтэй ураг барилдаасай гэж хүсэж байв. Эммагийн аав эрдэнэсийн энэхүү эрэлд болгоомжтой хандах болж, үүнд Иосефын гүйцэтгэх үүргийг сэрдэж байжээ. Юу ч гарахгүй нь тодорхой болоход Иосеф Жозайя Стоуэллыг хайгуулаа зогсоохыг ятгахаар оролдсон нь Исаак Хэйлд огт хамаагүй юм шиг байлаа.[6]

Эммад таньдаг бусад бүх эрээс нь Иосеф илүү таалагдсан бөгөөд тэрээр түүнтэй хамт цагийг өнгөрүүлэхээ болиогүй юм. Иосеф Жозайяг мөнгө эрэхээ зогсоохыг ятгаж чадсаныхаа дараа түүний фермд ажиллахаар Хармонид үлдэв. Заримдаа тэрээр уг нутгийн өөр нэг фермэр айл болох Иосеф, Поли Найт нарынд ажиллаж байв. Тэр ажиллаагүй үедээ Эмма дээр очдог байлаа.[7]

Удалгүй Иосеф болон түүний үзмэрчийн чулуу Хармонид хов ярианы гол сэдэв болов. Тосгоны зарим хөгшчүүл үзмэрчдэд итгэдэг байхад тэдний ихэнх

2015 онд Сүм Исаак болон Элизабет Хэйлийн Пеннсильванийн Хармони дахь гэрийн загвар байшинг дахин барьсан. Иосеф Смит тэдний эзэмшил газарт амьдарч, Жозайя Стоуэллын доор ажиллаж байхдаа охин Эмматай нь танилцжээ.

Смитийн гэр бүлийн Нью-Йоркийн Манчестер дэх байшинг эх барилгыг нь ашиглан сэргээн барьсан. 1827 онд гэрлэснийхээ дараа Иосеф, Эмма хоёр Иосефын эцэг эхтэй хамт тэнд амьдардаг байжээ.

хүүхэд, ач зээ итгэсэнгүй. Жозайягийн дүү Иосефыг ахыг нь ашигласан гэж үзэн, луйварчин хэмээн зарга үүсгэж, шүүхэд дууджээ.

Иосеф орон нутгийн шүүгчийн өмнө зогсоод, хэрхэн тэр чулууг олсноо тайлбарлав. Иосефын үзмэрчийн тэрхүү гайхамшигт бэлэгний талаар Өөрийн хүслийг тэдэнд үзүүлэхийг Бурханаас үргэлж гуйж байснаа Ахмад Иосеф гэрчилжээ. Эцэст нь Жозайя Иосеф өөрийг нь луйвардаагүйг шүүхийн өмнө мэдэгдэв.

"Та энэ хэрэгтэн уг чулууны тусламжтайгаар үзэж харж чадна гэдэгт итгэдэг гэж би ойлгож болох уу?" гэж шүүгч асуув.

Жозайя "Үгүй ээ, би үүнийг үнэн гэдгийг лавтай мэднэ" гэж батлан хэллээ.

Жозайя нутагтаа ихэд хүндлэгддэг нэгэн байсан тул хүмүүс түүний үгийг хүлээн авав. Эцэст нь уг байцаалтаар Иосеф түүнийг мэхэлсэн гэх ямар ч нотолгоо олдоогүй тул шүүгч хэргийг хэрэгсэхгүй болгов.[8]

1826 оны есдүгээр сард Иосеф ялтсуудын төлөө гүвээн дээр ирсэн хэдий ч Моронай түүнийг мөн л эдгээр зүйлд бэлэн биш байгааг хэлжээ. "Мөнгө ухагчидтай хамтрахаа боль" хэмээн тэнгэр элч түүнд хэлэв. Тэдний дунд ёс бус хүмүүс байжээ.[9] Моронай түүнд өөрийнхөө хүслийг Бурханыхтай нийцүүл хэмээн дахин нэг жилийн хугацаа өгөв. Хэрвээ тэгэхгүй бол түүнд хэзээ ч ялтсуудыг итгэл хүлээлгэн өгөх боломжгүй байв.

Тэнгэр элч мөн түүнд дараагийн удаа өөртэйгөө хамт хэн нэгнийг авчир хэмээн хэлжээ. Энэ нь гүвээн дээр Иосефыг анх удаа ирээд буцах үед түүний тавьсан хүсэлттэй адил байлаа. Алвин нас барсан байсан болохоор Иосеф гайхан,

"Зөв хүн нь хэн юм бол?" гэж асуулаа.

"Чи мэдэх болно" хэмээн Моронай хэлэв.

Иосеф үзмэрчийн чулуугаараа дамжуулан Их Эзэний удирдамжийг эрэлхийлэв. Түүний олж мэдсэнээр зөв хүн нь Эмма байлаа.[10]

Иосеф Эмматай уулзангуутаа түүнд татагдсан. Эмма түүнийг Их Эзэнд ажлаа гүйцэтгэхэд нь хэрэгтэй хүн болоход Алвины нэгэн адил тусалж чадах тийм хүн байв. Гэхдээ Эмма үүнээс ч илүү утга учиртай байв. Иосеф түүнд хайртай байсан бөгөөд түүнтэй гэрлэхийг хүсэж байв.[11]

Арван хоёрдугаар сард Иосеф хорин нэгэн нас хүрэв. Өмнө нь тэр түүний авьяас чадварыг ашиглахыг хүссэн хүмүүсийн хүсэл эрмэлзэлд янз бүрийн байдлаар автаж байжээ.[12] Гэвч гүвээ рүү хамгийн сүүлд очсоныхоо дараа тэрээр ялтсуудыг хүлээн авахад өөрийгөө бэлтгэхийн тулд илүү ихийг хийх ёстойгоо ойлгов.

1827 оны 9-р сарын 22-ны орой Иосеф, Эмма хоёр Мормоны Номыг булсан байсан энэ гүвээ рүү тэргээ жолоодон ирсэн. Иосеф ялтаснуудыг авсныхаа дараа тэдгээрийг эрдэнэсийн ангуучдаас хамгаалахын тулд хэсэг хугацаанд хөндий модны тайрдсан дотор нууж байжээ.

Хармони руу буцахаасаа өмнө Иосеф эцэг эхтэйгээ ярилцав. “Би гэрлэхээр шийдлээ” гэж тэр тэдэнд хэлээд, “та нар дургүйцэхгүй бол би Эмма Хэйл авхайг сонгож байна” гэв. Эцэг эх нь түүний шийдвэрт баярлаж, гэрлэснийхээ дараа тэдэнтэй хамт амьдрахаар ирэхийг Люси гуйв.[13]

Заримдаа цас орж, Хэйлийнхний гэр рүү явахад хэцүү үед Иосеф Найтуудын чаргыг гуйн авах зэргээр тэр өвөл аль болох их цагийг Эмматай хамт өнгөрүүлж байв. Гэвч Эммагийн эцэг эх түүнд дургүй хэвээр байж, тэдэнд таалагдах гэсэн түүний хичээл зүтгэл талаар болов.[14]

Эмма 1827 оны нэгдүгээр сард Стоуэллынхны гэрт ирснээр гэрийнхнийхээ дургүйцсэн царайг харахгүйгээр Иосефтэй хамт байх болов. Тэнд Иосеф Эммаг өөртэй нь гэрлэхийг гуйхад Эмма эхлээд гайхсан янзтай байв. Эцэг эх нь энэ гэрлэлтийг эсэргүүцнэ гэдгийг тэр мэдэж байлаа.[15] Гэвч Иосеф түүнийг энэ талаар бодож үзэхийг гуйв. Тэд тэр даруй гэрлэж болох байв.

Эмма гэрлэх саналыг бодож үзжээ. Иосефтэй гэрлэснээр эцэг эхийнхээ урмыг хугалах боловч энэ нь түүний сонголт бөгөөд тэр түүнд хайртай байв.[16]

Хэсэг хугацааны дараа 1827 оны нэгдүгээр сарын 18-нд Иосеф, Эмма хоёр нутгийн захирагчийн гэрт гэрлэв. Дараа нь тэд Манчестер явж, Иосефын эцэг эхийн шинэ гэрт хамтдаа амьдралаа эхлүүлэв. Байшин тохилог хэдий ч Ахмад Иосеф, Люси хоёр үүнд хэт их мөнгө зарцуулсны улмаас төлбөрөө хоцроож, өмчлөх эрхээ алджээ. Тэд одоо үүнийг шинэ эзнээс нь түрээсэлж байлаа.[17]

Смитийнхэн Иосеф, Эмма хоёрыг тэдэнтэй хамт байгаад дуртай байдаг байв. Гэсэн хэдий ч хүүгийнх нь тэнгэрлэг дуудлага тэдний санааг зовоож байв. Уг нутгийнхан алтан ялтсуудын талаар сонссон тул тэдгээрийг заримдаа хайж байлаа.[18]

Нэгэн өдөр Иосеф ажлаар хот руу явав. Түүнийг оройн хоолон дээр ирэхийг хүлээж байсан эцэг эх нь ирээгүйд нь сэтгэл түгшив. Тэд хэдэн цаг хүлээгээд унтаж чадсангүй. Эцэст нь Иосеф хаалга онгойлгон ихэд ядарчихсан орж ирээд, сандал дээр хайнга гэгч суув.

“Чи яагаад ийм их оройтов оо?” гэж аавыгаа асуухад

“Би амьдралдаа хамгийн хурц ширүүнээр зэмлүүллээ” гэж Иосеф хэлэв.

“Хэн чамайг зэмлэсэн юм бэ?” гэж аав нь асуулаа.

“Их Эзэний тэнгэр элч” гэж Иосеф хариулаад, “Тэр намайг хайнга байна гэсэн” гэв. Моронайтай уулзах дараагийн уулзалтын өдөр ойртож байлаа. “Надад яаралтай хийх зүйл зөндөө байна. Би Бурхан надаар хийлгэхээр зарлигласан зүйлсийг хийж эхлэх ёстой” гэж тэр хэлэв.[19]

Намрын ургац хураалтын дараа Жозайя Стоуэлл, Иосеф Найт нар ажил хэргээр Манчестер руу явав. Тэд Иосефын гүвээн дээр анх очсоны дөрвөн жилийн ой тун дөхөөд буйг мэдэж байсан бөгөөд Моронайг эцэстээ ялтсуудыг түүнд даатган өгөх эсэхийг мэдэхийг тэсэн ядан хүлээж байлаа.

Мөн нутгийн эрдэнэсийн эрэлчид Иосеф цэдгийг авах цаг болсныг мэдэж байв. Тэдний нэг болох Самуел Лоурэнс гэх нэгэн эр сүүлийн үед ялтсуудыг хайн гүвээгээр эргэлдэх болжээ. Самуелыг асуудал үүсгэх вий гэж сэтгэл зовнисон Иосеф есдүгээр сарын 21-ний орой аавыгаа Самуелын гэрийг ажиглан, хэрэв тэр гүвээ рүү явж байгаа юм шиг байвал түүнийг зогсоолгохоор явуулж байв.[20]

Иосеф тэгээд ялтсуудыг авахад өөрийгөө бэлдэв. Гүвээ рүү жил бүр очдог өдөр нь маргааш болох гэж байхад тэрээр эрдэнэс хайгчдаас урьтахын тулд шөнө дундаас хойш, яг есдүгээр сарын 22-ны өглөө хэн ч түүнийг гадуур байна гэж тааварлаагүй үед гүвээ рүү очихоор төлөвлөв.

Иосефыг гүвээнээс буухын өмнө Моронай түүнд Их Эзэнээр томилогдсон хүнээс өөр хэнд ч ялтаснуудыг үзүүлж болохгүй гэдгийг сануулав.

Гэсэн ч тэрээр ялтсуудыг авсныхаа дараа хамгаалах арга олох хэрэгтэй байлаа. Гэрийнхнийгээ унтсан хойно тэр ээжээсээ цоожтой хайрцагтай эсэхийг аяархан асуув. Люсид тийм хайрцаг байгаагүй учир санаа нь зовлоо.

“Зүгээр ээ” гэж Иосеф хэлээд “Үүнгүйгээр би яг одоо маш сайн хийж чадна” гэв.[21]

Удалгүй Эмма мориор явахаар хувцаслан гарч ирээд, Иосеф тэр хоёр Иосеф Найтын сүйх тэргэнд суугаад харанхуй шөнөөр явж одлоо.[22] Тэднийг гүвээн дээр ирэхэд Иосеф ялтсууд буй газар руу налуу замаар авирах хооронд Эмма сүйх тэрэгтэйгээ хүлээж байв.

Моронай үзэгдэж, Иосеф алтан ялтас болон үзмэрчийн чулуунуудыг чулуун хайрцагнаас нь гарган авлаа. Иосефыг гүвээн дээрээс буухаас өмнө Моронай түүнд Их Эзэний томилох хүмүүсээс өөр хэнд ч ялтсуудыг үзүүлэх ёсгүйг сануулаад, хэрвээ тэр тэдгээрийг хадгалахын тулд өөрийн хүч хүрэх бүхнийг хийвэл ялтсууд хамгаалагдана гэдгийг түүнд амлав.

“Чи үүрэг даалгавартаа сэрэмжтэй, үнэнч байх ёстой” гэж Моронай түүнд хэлээд, “үгүй бол ёс бус хүмүүс тэдгээрийг чамаас булаан авч болох бүхий л арга зам, заль мэхийг ашиглан чамайг дийлэх болно. Тэгээд хэрэв чи үргэлжлүүлэн анхаарал болгоомжгүй байвал тэд санасандаа хүрэх болно” гэв.[23]

Иосеф ялтсуудыг авч, гүвээнээс бууугаад, сүйх тэргэнд хүрэхээсээ өмнө цоожтой хайрцаг олж автлаа тэдгээрийг аюулгүй байлгах модны хонгилд сайтар нуув. Дараа нь тэр Эммаг олоод, нар мандах гэж байхад гэртээ харив.[24]

Смитийн гэрт Ахмад Иосеф, Иосеф Найт, Жозайя Стоуэлл нарт Люси өглөөний унд бэлтгээд Иосеф, Эмма хоёрыг сэтгэл түгшин хүлээж байлаа. Ажлаа хийх үедээ түүний зүрх түргэн цохилж, хүү нь ялтсуудгүй ирэх вий хэмээн эмээж байв.[25]

Хэсэг хугацааны дараа Иосеф, Эмма хоёр гэрт орж ирлээ. Люси Иосефт ялтсууд байгаа эсэхийг хартал түүний гар хоосон байгааг үзээд өрөөнөөс чичрэн гарав.

Иосеф түүнийг дагалаа. “Ээж ээ, санаа бүү зов” гэж тэр хэлээд, түүнд алчууранд боосон юм өгөв. Люси даавууны цаанаас том гэгчийн нүдний шил гэмээр зүйл мэдэрлээ. Энэ бол Их Эзэний ялтсуудыг орчуулахад бэлтгэгдсэн үзмэрчийн чулуунууд болох Урим ба Туммим байв.[26]

Люси маш их баярлав. Иосефын мөрнөөс маш хүнд ачаа авагдсан мэт харагдлаа. Гэхдээ тэр гэрийн бусад хүнтэй хамт өглөөний хоолоо чимээгүйхэн идэхдээ уруу царайтай байв. Тэр хооллож дууссаныхаа дараа шанаагаа тулаад, толгойгоо урамгүйгээр гудайлган, “Миний урам хугарч байна” гэж Иосеф Найтад хэллээ.

“За даа, надад ч бас харамсалтай байна” гэж настай эр хариулав.

“Миний урам маш их хугарч байна” гэж Иосеф давтан хэлээд, царай нь хувирч инээмсэглэн “Энэ нь бодсоноос маань арав дахин дээр байлаа!” гэв. Тэрээр ялтсуудын жин, хэмжээг дүрслэн, Урим ба Туммимын талаар сэтгэл хөдлөн ярьж гарав.

“Би юуг ч харж чадна. Тэд үнэхээр гайхалтай” гэж тэр хэллээ.[27]

Ялтсуудыг авсныхаа дараа өдөр нь Иосеф цоожтой хайрцаг авах мөнгө олохоор зэргэлдээх хот руу худаг засах ажилд явлаа. Тэрхүү өглөө Смитийн гэрээс дөнгөж гүвээний цаахна ажлаар явж байгаад, Ахмад Иосеф бүлэг

хүмүүсийн алтан ялтсуудыг хулгайлахаар төлөвлөж буйг санаандгүй сонсов. “Жөү Смит эсвэл тамын бүх чөтгөрүүд байсан ч бид ялтсуудыг авна” гэж тэдний нэг нь хэлэв.

Сандарсан Ахмад Иосеф гэртээ хариад Эммад хэлэв. Тэрээр ялтсууд хаана байгааг мэдэхгүй ч Иосеф тэдгээрийг хамгаалсан гэдэгт итгэлтэй байгаагаа хэллээ.

“Тийм ээ” гэж Ахмад Иосеф хариулаад, “гэхдээ жаахан зүйлийн төлөө Есав адислал, ууган хүүгийн эрхээ алдсаныг санаарай. Иосеф ч адилхан байж болох юм” гэв.[28]

Ялтсууд аюулгүй байгааг лавтай мэдэхийн тулд Эмма морио унаад, Иосефын ажиллаж байсан ферм рүү цаг гаруй давхив. Тэр түүнийг худгийн хажуугаас өдрийн ажлынхаа шороо тоос, хөлсөндөө хутгалдсан байхад нь олов. Болсон аюултай явдлыг сонсоод Иосеф Урим ба Туммим руу харж, ялтсууд аюулгүй байгааг үзлээ.

Гэртээ үлдсэн Ахмад Иосеф байшингийнхаа гадна нааш цааш холхин, Иосеф, Эмма хоёрыг хартлаа минут тутам зам руу хяламхийн харж байв.

“Аав аа” гэж Иосеф явдал дундаа хэлээд, “бүх юм зүгээр—айх ямар ч шалтгаан байхгүй” гэв.[29]

Гэвч одоо л үйлдэл хийх цаг байлаа.

Иосеф гүвээ рүү яаран очиж, ялтсуудыг нуусан модыг олоод, тэдгээрийг авч, цамцандаа болгоомжтой ороов.[30] Тэрээр түгшсэн байдалтайгаар ой руу далд орж, гэрийн зүг явлаа. Ой мод түүнийг төв зам дээрх хүмүүсээс далдалж байсан ч энэ нь хулгайчдад нуугдах маш олон газрыг өгч байв.

Иосеф цэдгийн хүнд жингээс болоод ядарч байсан ч хүчээ шавхан, аль болох хурднаараа моддын дундуур алхалж байлаа. Урдах замыг нь хааж унасан модны дээгүүр харайхдаа тэр араас нь ямар нэгэн хатуу юм цохихыг мэдрэв. Тэр эргэж хараад, бууг бороохой шиг барьсан хүн түүн рүү ирж байхыг харлаа.

Нэг гараараа ялтсуудыг сайтар атгаад, Иосеф нөгөө эрийг газарт унатал нь цохичихоод ойн гүн рүү хурдлав. Түүнийг километр орчим газарт гүйж байтал өөр нэг хүн модны цаанаас үсрэн гарч ирээд, түүнийг бууныхаа бөгсөөр дэлсээд авлаа. Иосеф өнөөх эртэй зодолдож дийлээд, ойгоос гарахаар санаа шулуудан гүйж одов. Гэвч тэр нэг их хол явж амжаагүй байтал гурав дахь эр дайрч, түүнийг гуйвтал нь хүнд цохилт өглөө. Иосеф бүх хүчээ шавхан түүнийг чангахан гэгч цохичихоод гэр рүүгээ гүйв.[31]

Хэрэв Иосеф ялтаснуудыг хадгалахын тулд чадах бүхнээ хийх юм бол тэдгээр нь хамгаалагдана хэмээн Моронай түүнд амлав.

Байшиндаа ирээд Иосеф нэг гартаа хүнд боодолтой юм сугавчилсан тэр чигтээ хаалгаар шурдхийн орлоо. “Аав аа” гэж тэр хашгираад, “Би ялтсуудыг авсан” гэв.

Гэрийн бусад хүн түүнийг тойрон цугларч байх хооронд арван дөрвөн настай дүү Катерин нь боодолтой зүйлийг ширээн дээр тавихад түүнд туслав. Иосеф аав, эрэгтэй дүү Виллям хоёр нь ялтсуудын боодлыг тайлахыг хүсэж байгааг ойлгож байсан ч тэднийг хориглолоо.

“Бид эднийг үзэж болохгүй юм уу?” гэж Ахмад Иосеф асуув.

“Үгүй ээ” гэж Иосеф хэлээд, “Би эхний удаа дуулгаваргүй байсан ч энэ удаад үнэнч байхыг зорьж байна” гэлээ.

Тэр тэднийг даавууны цаанаас ялтсуудыг мэдэрч чадна гэж хэлсэнд түүний дүү Виллям боодолтой зүйлийг тэмтэрч үзэв. Энэ нь чулуунаас хүнд бөгөөд номны хуудас шиг хөдөлдөг хавтаснуудтай гэдгийг Виллям хэлж чадахаар байлаа.[32] Мөн Иосеф хамгийн бага эрэгтэй дүү Дон Карлосыг эхнэр Иеруша, шинэ төрсөн охин хоёртойгоо зам дагуу амьдардаг Хайрумаас цоожтой хайрцаг авчруулахаар илгээв.

Хайрум удалгүй ирж, ялтсуудыг хайрцганд найдвартай хийсний дараа Иосеф ойролцоох ор руу өнхрөөд, гэрийнхэндээ ойд байсан хүмүүсийн талаар ярьж эхлэв.

Тэр ярьж байх үедээ гар нь хөндүүрлэж байгааг мэдлээ. Дайралтуудын үеэр тэр эрхий хуруугаа мулталчихсан байв.

“Би ярихаа зогсоох хэрэгтэй байна. Аав аа, та миний эрхий хурууг байранд нь оруулаад өгөөч” гэж тэр хэлэв.[33] ■

Эш татсан бүтээлүүдийн бүрэн жагсаалт saints.lds.org вэбсайтад англи хэл дээр бий.

Тэмдэглэл дэх *Сэдэв* гэсэн үг нь дэлгэрэнгүй мэдээлэл онлайнаар, гэгээнтнүүд.lds.org вэбсайт дээр байгааг илэрхийлнэ.

ЭШЛЭЛҮҮД

1. Agreement of Josiah Stowell and Others, 1825 оны 11-р сарын 1, *JSP,* D1:345–52.
2. Смит, *Biographical Sketches,* 91–92; Оливер Каудери, “Letter VIII,” *LDS Messenger and Advocate,* 1835 оны 10-р сар, 2:200–202; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 7–8, *JSP,* H1:234 (draft 2); Смит, *On Mormonism,* 10. **Сэдэв:** Treasure Seeking (Эрдэнэсийн эрэлд)
3. Agreement of Josiah Stowell and Others, 1825 оны 11-р сарын 1, *JSP,* D1:345–52.
4. Пратт, *Autobiography,* 47; Бурнэт, *Recollections and Opinions of an Old Pioneer,* 66–67; Вүдрафф, Journal, 1843 оны 7-р сарын 4, 1855 оны 10-р сарын 20; Эммэлин Б. Уэллс, “L.D.S. Women of the Past,” *Woman's Exponent,* 1908 оны. 2-р сар, 36:49; Иосеф Смит III,

Иосеф үүнтэй адилхан цоожтой хайрцгийг Хайрум ахаасаа түр хугацаагаар зээлдэн авч, Мормоны Номын ялтаснуудыг хадгалж байв.

ЖЕД А.КЛАРКИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

"Last Testimony of Sister Emma," *Saints' Herald,* 1879 оны 10-р сарын 1, 289; Стэйкэр ба Аштон, "Growing Up in the Isaac and Elizabeth Hale Home"-г мөн үзнэ үү; and Ashurst-McGee, "Josiah Stowell Jr.–John S. Fullmer Correspondence," 108–17.

5. Бо, "Joseph Smith's Athletic Nature," 137–50; Пратт, *Autobiography,* 47; Бурнэт, *Recollections and Opinions of an Old Pioneer,* 66–67; *Recollections of the Pioneers of Lee County,* 96; Youngreen, *Reflections of Emma,* 61, 67, 65, 69; Эммэлин Б. Уэллс, "L.D.S. Women of the Past," *Woman's Exponent,* 1908 оны 2-р сар, 36:49.
6. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 8, *JSP,* H1:234 (draft 2); Смит, *Biographical Sketches,* 92; Бушмэн, *Rough Stone Rolling,* 51–53; Стэйкэр, "Isaac and Elizabeth Hale in Their Endless Mountain Home," 104.
7. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 7–8, *JSP,* H1:234–36 (draft 2); Knight, Reminiscences, 2; Иосеф Смит III, "Last Testimony of Sister Emma," *Saints' Herald,* 1879 оны 10-р сарын 1, 290.
8. Виллям Д. Пурпл, "Joseph Smith, the Originator of Mormonism," *Chenango Union,* 1877 оны 5-р сарын 2, [3]; An Act for Apprehending and Punishing Disorderly Persons (1788 оны 2-р сарын 9)-ыг мөн үзнэ үү, *Laws of the State of New-York* (1813), 1:114. **Сэдэв:** Joseph Smith's 1826 Trial (Иосеф Смитийн 1826 оны шүүх хурал)
9. "Mormonism—No. II," *Tiffany's Monthly,* 1859 оны 7-р сар, 169.
10. Knight, Reminiscences, 2.
11. Lucy Mack Smith, History, 1844–45, 96; Knight, Reminiscences, 2-ыг мөн үзнэ үү.
12. "The Original Prophet," *Fraser's Magazine,* 1873 оны 2-р сар, 229–30 -ийг үзнэ үү.
13. Lucy Mack Smith, History, 1845, 97.
14. Knight, Reminiscences, 2; Иосеф Смит III, "Last Testimony of Sister Emma," *Saints' Herald,* 1879 оны 10-р сарын 1, 289.
15. Иосеф Смит III, "Last Testimony of Sister Emma," *Saints' Herald,* 1879 оны 10-р сарын 1, 289; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 8, *JSP,* H1:236 (draft 2).
16. Иосеф Смит III, "Last Testimony of Sister Emma," *Saints' Herald,* 1879 оны 10-р сарын 1, 290; Joseph Lewis and Hiel Lewis, "Mormon History. A New Chapter, about to Be Published," *Amboy Journal,* 1879 оны 4-р сарын 30, 1; Оливер Каудери, "Letter VIII,"-г мөн үзнэ үү, *LDS Messenger and Advocate,* 1835 оны 10-р сар, 2:201.
17. Joseph Smith History, 1838–56, volume A-1, 8, *JSP,* H1:236 (draft 2); Lucy Mack Smith, History, 1844–45, book 4, [11]–[12]; book 5, [1]–[3]. **Сэдэв:** Sacred Grove and Smith Family Farm (Ариун ойн цоорхой ба Смитийн гэр бүлийн аж ахуй)
18. "Mormonism—No. II," *Tiffany's Monthly,* 1859 оны 7-р сар, 167–68.
19. Lucy Mack Smith, History, 1844–45, book 5, [4]–[6].
20. Knight, Reminiscences, 2.
21. Lucy Mack Smith, History, 1844–45, book 5, [6].
22. Lucy Mack Smith, History, 1845, 105.
23. Lucy Mack Smith, History, 1844–45, book 6, [1].
24. "Mormonism—No. II," *Tiffany's Monthly,* 1859 оны 6-р сар, 165–66; Lucy Mack Smith, History, 1844–45, book 5, [6].
25. Lucy Mack Smith, History, 1844–45, book 5, [6]–[7]; Knight, Reminiscences, 2.
26. Lucy Mack Smith, History, 1844–45, book 5, [7]–[8].
27. Knight, Reminiscences, 2–3; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 5, *JSP,* H1:222 (draft 2); Алма 37:23-ыг мөн үзнэ үү.
28. Lucy Mack Smith, History, 1844–45, book 5, [8]–[10]; "Mormonism—No. II," *Tiffany's Monthly,* 1859 оны 8-р сар, 166; Смит, *Biographical Sketches,* 103; Эхлэл 25:29–34-ийг мөн үзнэ үү.
29. Lucy Mack Smith, History, 1844–45, book 5, [10] мөн adjacent paper fragment.
30. Lucy Mack Smith, History, 1844–45, book 5, [11]. **Сэдэв:** Gold Plates (Алтан ялтсууд)
31. Lucy Mack Smith, History, 1844–45, book 5, [11].
32. "The Old Soldier's Testimony," *Saints' Herald,* 1884 оны 10-р сарын 4, 643–44; Салисбури, "Things the Prophet's Sister Told Me," 1945, Church History Library; Болл, "The Prophet's Sister Testifies She Lifted the B. of M. Plates," 1954, Church History Library; Смит, *William Smith on Mormonism,* 11; Lucy Mack Smith, History, 1844–45, book 5, [11]; Иосеф Смит III, "Last Testimony of Sister Emma," *Saints' Herald,* 1879 оны 10-р сарын 1, 290.
33. Lucy Mack Smith, History, 1844–45, book 5, [11]–[12]. **Сэдэв:** Lucy Mack Smith (Люси Мак Смит)

СҮМ *ЭНД* БАЙНА ГЭЖ ҮҮ?

Би 36 насандаа Сүмд нэгдсэн бөгөөд заримдаа сүнслэг байдлын хувьд хүчтэй байгаагаа мэдэрдэг байв. Харин заримдаа энэ нь янз бүр байдаг байлаа. Ажлын ачаалал, эхнэр маань шинэ мэргэжлээр ажиллаж эхэлсэн, эрүүл мэнд муудсан зэрэг бас бус асуудлууд дунд би сүнслэг байдлаараа доройтож эхлэв. Би сүмдээ явж, диконы чуулгад заахад тусалдаг байсан ч түүнээс илүүг хийж чадахгүй байлаа. Би судраа нээж, өвдөг сөгдөн залбирах хүч тэнхээг олж чадахгүй байв.

Ажлын шугамаар Чилийн хойд хэсгээр аялах үедээ би асуудалтай хэвээр байсан юм. Бид Копиапо дахь нисэх онгоцны буудлаас Чилийн Атакама элсэн цөл дэх нарны цэнэгээр ажилладаг төхөөрөмж суурилуулах төслийн газар руу очихын тулд машинаар хоёр цаг явав. Тэр нь хот суурингаас хол, алслагдсан газар байсан нь намайг гайхшируулав. Олон бээр газар туулахад улайран харагдах цөлөөс өөр юу ч байсангүй. Байгалийн уйтгартай дүр зураг гайхал төрүүлэм байв.

Төслийн газарт бид ойролцоогоор долоо хоносны дараа хамгийн ойрын хотхон руу хоол хүнсээ базаахаар машинаар явлаа. Тэндэхийн нэгэн барилга миний нүдэнд өртөв. Би жолоочоос замын хажууд зогсохыг хүслээ. Барилгын гадна тохижилт үнэхээр сайхан байсан ба хар өнгийн төмөр хашаагаар хүрээлүүлсэн байлаа. Барилгын гадна "La Iglesia de Jesucristo de los Santos de los Últimos Días" буюу "The Church of Jesus Christ of Latter-day Saints" гэсэн танил хаяг байв.

"Сүм *энд* байна гэж үү?" гэж би бодсон. Дэлхийн ийм алслагдсан газарт Сүм байгаад би гайхлаа. Би цуглааны байрны зургийг аваад, эхнэртээ мессежээр явуулав. "Тэнгэрлэг Эцэг газар бүхэнд байх Өөрийн хүмүүсийг мэддэг" гэсэн түүний хариулт надад гүн гүнзгий нөлөөлсөн юм.

Энэ нь Тэнгэрлэг Эцэгээс надад зориулсан захиас байсан. Өдөр тутмын амьдралын дарамтад орсон би Тэнгэрлэг Эцэг Өөрийн бүх хүүхдийг хайрладаг гэдгийг мартсан байсан ба үүнийг эргэн санах хэрэгтэй байсан юм. Тэрээр элсэн цөл дунд орших тэрхүү жижигхэн, алслагдсан хотхоны гэгээнтнүүдэд хайртай бөгөөд намайг ч мөн хайрладаг.

Орой нь би өвдөг сөгдөн, тэр өдөр надад өгсөн адислуудынх нь төлөө Тэнгэрлэг Эцэгтээ талархаж билээ. Тэр намайг хайрладаг гэдгийг олж мэдсэн маань надад сүнслэг байдлаа эргүүлэн сэргээхэд тусалсан бөгөөд өдөр бүр хүчирхэгжүүлдэг хэвээр. ■

Жон Эванс, АНУ, Калифорни муж

Бидниййг хоол хүнсээ базаахаар хамгийн ойрын хотхон руу машинаар явж байхад хажуугаар өнгөрсөн нэгэн барилга миний нүдэнд өртөв.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АЛЛЕН ГАРНС

ХОЁР НОМЛОЛ, АДИСЛАГДСАН ХОЁР ГЭР БҮЛ

Аризона Меса номлолд үйлчилж байхдаа би Аргентинд байгаа том эгчээсээ үргэлж э-мэйл хүлээж авдаг байлаа. Наталиа Сүмийн гишүүн биш байв. Хэдэн жилийн өмнө охин нь нас барснаас хойш гэр бүлийнхэн маань түүнтэй сайн мэдээг хуваалцах гэж хичээсэн ч тэр огт хүлээж авахгүй байсан юм.

Би номлолд байхдаа түүнтэй гэрчлэлээ хуваалцсаар байлаа. Нэг э-мэйлдээ би хамтрагчтайгаа хамт уулзсан нэг эмэгтэйн талаар дурдав. Түүний охин бас нас барсан байлаа. Бид мөнхийн гэр бүлийн талаар гэрчилсэн бөгөөд тэр бидний хуваалцсан зүйлээс итгэл найдварыг мэдэрсэн байв. Та ч гэсэн үүнийг мэдэрч болно хэмээн би Наталиад хэлсэн юм. Тэр хариу бичихдээ тийм итгэл найдварыг мэдрэхийг хүсэж байгаа ч өөрт нь хангалттай итгэл байхгүй гэж боддогоо бичсэн байв.

Би Наталиад гараараа захидал бичихээр шийдэж, итгэхэд тусламж хүсэн залбирахад түүнийг урилаа. Нэг догол мөрийг англиар номлогчид хандан бичье гэсэн сүнслэг өдөөлт надад төрөв. Наталиа зөвхөн испани хэл мэддэг байсан тул би түүнийг номлогчдыг хайж олон тэднээр орчуулуулаарай гэлээ. Номлогч нь англи хэл мэдэх байх гэж найдав.

Удалгүй би Наталиагаас э-мэйл авлаа. Тэр номлогчдыг олж, тэднээс миний захиаг орчуулж өгөхийг хүссэн аж. Тэд чимээгүй уншсанаа, инээмсэглэжээ. Намайг юу бичсэн байна гэж Наталиаг асуухад нь тэд "Бичсэн зүйлийн талаар ярилцацгаая" гэсэн байна. Би Наталиаг охин нь нас барсан явдлыг хүндээр тусгаж авсан гэдгийг тайлбарлаад, түүнд авралын төлөвлөгөөг зааж өгөхийг номлогчдоос хүссэн юм.

Номлогчид богинохон захиас хуваалцсан ба заасан зүйл нь Наталиад таалагджээ. Наталиа дараа нь намайг АНУ-ын Аризона Меса номлолд үйлчилж байгааг тэдэнд хэлэхэд ахлагчдын нэг нь болох ахлагч Ларсон тэндээс ирсэн гэдгээ хэлжээ.



Жилийн дараа намайг ахлагч Ларсоны гэр бүлийн амьдардаг газар руу шилжүүлэв. Би түүний гэрийнхэнтэй, харин тэр миний гэр бүлтэй танилцаж, хоёр гэр бүл хоёулаа адислагдсан юм. Ахлагч Ларсон гэрчлэлээ хүчирхэгжүүлэхээр хичээж байгаа эрэгтэй дүүгийнхээ төлөө залбирч байжээ. Солилцоогоор хэд хэдэн удаа дүүтэй нь хамт явж, гэрчлэлийг нь хүчирхэгжүүлэхэд туслах боломж надад олдсон юм. Ахлагч Ларсон хамтрагчтайгаа хамт Наталиад үргэлжлүүлэн зааж, тэр эцэст нь баптисм хүртсэн билээ. Их Эзэн биднийг хоёр өөр зүгт буюу намайг Аризона руу, ахлагч Ларсоныг Аргентин руу явуулсан бөгөөд ингэснээр бид гэр бүлүүдээ сайн мэдээнд хүчирхэгжүүлэхэд нь Түүнд туслах боломжтой байсан гэдгийг би мэднэ. ■

Хуан Мануэл Гомэз, Аргентин, Розарио

Би Аризонад, харин ахлагч Ларсон Аргентинд томилогдож, Их Эзэн бидний гэр бүлийнхнийг адислахад нь бид хоёул туслах боломжтой байсанд би талархдаг.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭРОЛИН ВИББЭРТ

Би маш их сандарч байсан ч биеэ цэхлэн, зоригтойгоор "Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд" явдаг гэж хэлсэн.

ИТГЭЛЭЭ ТУНХАГЛАСНААР ИРСЭН АДИСЛАЛ

Би 19 настай байхдаа баптисм хүртсэн юм. Гэр бүл, найз нөхдөөс маань олон хүн миний Сүмд нэгдэх шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй ч энэ нь намайг зогсоогоогүй. Үүнээс хоёр долоо хоногийн дараа би коллежийнхоо хоёрдугаар курст орсон. Би сургуулийнхаа хотхонд буцаж очоод, шинэ итгэлийнхээ талаар санаа зовж байлаа.

Би шашин шүтлэгээ хамгаалах зоригтой байж чадах болов уу гэж сэтгэл түгшиж эхлэв. Би ганцаардаж байв. Би коллеж дээрээ хэзээ ч Сүмийн гишүүнтэй тааралдаж байгаагүй бөгөөд цуглааны байрыг хаанаас олохоо, тэр бүү хэл ойр хавьд тойрог, салбар байдаг эсэхийг ч мэдэхгүй байлаа. Би Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, намайг зоригжуулахыг гуйв. Шинэ итгэл үнэмшлээ хамгаалах итгэлтэй болохын төлөө би залбирсан юм.

Хэдэн өдрийн дараа би хэсэг хүнийг нүүж ороход нь туслалаа. Тэгээд би Брайн гэдэг залуутай танилцаж, бид найзууд болов. Нэг өдөр бид сургуулийн хотхоноор алхаж байтал тэр надаас ням гарагт юу хийхээр төлөвлөж байгааг асуув. Намайг түүнд сүм рүү явах гэж байгаагаа хэлэхэд,

тэр "Чи аль сүмд явдаг вэ?" гэж асуусан.

Би дотроо их сандарч байсан ч биеэ цэхлэн, зоригтойгоор "Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд" явдаг гэв.

Би өөрөөрөө бахархаж байсан ч Брайныг юу гэх бол гэж санаа зовж байлаа. Яг тэр үед би номлогчдыг харсан юм. Брайныг ямар нэг зүйл хэлэхээс өмнө түүнийг түр хүлээж байгаарай гээд би номлогчид руу гүйв. Тэд надтай уулзахдаа баяртай байсан ба маргааш нь сүмд очиход надад хэрэгтэй бүх мэдээллийг өгсөн.

Би Брайн дээр эргэн очоод, юу болсныг тайлбарлав. Би бас түүнтэй Сүмийн талаар багахан зүйл хуваалцсан ба бид яриагаа хэвийн үргэлжлүүлсээр цааш алхах үед хөл минь хөнгөрсөн юм шиг л санагдсан. Түүнчлэн би гагцхүү Сүнс л өгч чадах тэрхүү халуун дулаан, амар амгаланг мэдэрсэн. Би ганцаардаж бас Сүм рүү хаашаа явахаа мэдэхгүй байсан болохоор түгшиж байсан билээ. Гэвч эдгээр номлогч яг тэр үед тухайн мөчид ирсэн нь итгэлээ тунхагласны минь төлөө Тэнгэрлэг Эцэгээс ирүүлсэн адислал байсан гэдэгт би итгэдэг.

Хэдийгээр одоо 10 гаруй жил өнгөрсөн ч гэсэн би тэр өдрөөс хойш хэзээ ч "Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн" гэж хэлэхээсээ айж байгаагүй. ■

Кристин Макэлдэрри, АНУ-ын Массачусетс

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДИЛЛИЙН МАРШ

ТАРХИНЫ ХОЁР МЭС ЗАСЛЫГ ИХ ЭЗЭНИЙ ТУСЛАМЖТАЙ ДАВЖ ГАРСАН

Нурууны өвчний улмаас хөдөлгөөн заслын эмчилгээ хийлгэж байхдаа би биеийнхээ зүүн талыг сул, мэдрэмжгүй байгааг анзаарав. Би эдгээр шинж тэмдгийг хөдөлгөөн засалчдаа хэлэхэд тэрээр санаа зовж, эмчид үзүүлэхийг зөвлөлөө.

Томографийн шинжилгээ хийлгэхэд миний ууpaг тархи гавлын ясныхаа доороос ургаж, хүзүү хэсэгт нугасны шингэнийг олон жилийн турш хаасан байсан нь илрэв. Энэ нь байнгын хүчтэй толгойны өвчин болон өвдөлтийн шалтгаан болж байсан байв. Цорын ганц боломж бол мэс засал хийлгэх явдал байлаа. Гэвч мэс засал хийлгээд ч өвдөхөө больсонгүй.

Зургаан сарын дараа би эмч дээрээ дахин ирэхэд хаагдсан нугасны шингэн бүр ихэссэнийг нэмэлт шинжилгээгээр олж мэдэв. Би дахиад хүнд мэс засалд орно гэхээс ихэд айж байлаа. Нөхөр бид хоёр хэд хэдэн эмчийн саналыг сонссоны эцэст тархины минь нэг хэсгийг авах нь тус болно гэдэгт итгэлтэй байсан нэгэн эмчээр мэс засал хийлгэхээр болов.

Тархины хоёр дахь мэс заслыг хийлгээд эргэн тэнхрэх нь амьдралын маань хамгийн хүнд бэрх туршлага байсан юм. Би Сүнснээс тайтгарлыг цөхрөлтгүй эрэлхийлж байлаа. Би хэлсэн үгс, дууллуудыг сонсож, тасралтгүй залбирч, санваарын олон адислал авч билээ.

Энэхүү хүнд бэрх тэнхрэх үйл явцаар дамжуулан би Тэнгэрлэг Эцэг миний болон миний төлөөх бусдын залбирлыг сонссон гэдгийг мэдэж авсан. Тэр хэрэгтэй үед над руу хүмүүсийг илгээдэг байв. Манай тойргийн сувилагч эмэгтэй надад эм тангаа хэрхэн зохицуулахыг зааж өгч тусалсан. Нагац ах, эгч хоёр маань шингэн дутагдаж байгааг минь олж хараад намайг эмнэлэг рүү авч явсан. Харин Хүүхдийн хэсгийн нэг хүү манай гэр бүлд туслахын тулд хүүд маань зориулан тоглоомоо үүдэн дээр орхисон байв. Энэ болон өөр олон туршлагын ачаар Аврагч миний зовлонгоос үүрэлцэж мөн гэрчлэл маань өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгааг би мэдэрсэн. Энэхүү үнэхээр хүнд хэцүү туршлагаас би гайхалтай бөгөөд ариун нандин туршлагыг олж авсан билээ.

Хэдийгээр миний хоёр дахь мэс засал амжилттай болсон ч тав тухгүй мэт мэдрэмж төрсөөр байсан бөгөөд би архаг өвчинтэйгөө эвлэрч сурахаас гадна энэ бүх зүйлд зориулсан зорилго Тэнгэрлэг Эцэгт байгаа гэдэгт итгэж сурсан. Гэхдээ сорилт бэрхшээлтэй үеэр Тэрээр намайг үргэлжлүүлэн хүчирхэгжүүлнэ гэсэн амлалтад нь би итгэж найддаг. Учир нь Тэрээр "Би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно" (С ба Г 84:88) хэмээн хэлсэн. ■

Брин Бүүкэр, АНУ, Айдахо муж

Томографийн шинжилгээ хийлгэхэд миний ууpaг тархи гавлын ясныхаа доороос ургаж, хүзүү хэсэгт нугасны шингэнийг олон жилийн турш хаасан байсан нь илрэв.



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БОННИ ХОФКИН

Далын
Ахлагч Майкл Жон Ю.Тэ

Тэвчээр бол тэнцвэржүүлэх үйл явц

Би саяхан өнөөгийн залуучуудын тулгамдаж байгаа асуулт, сорилт бэрхшээл, цөхрөл, ялалтын талаар ойлголт авахын тулд өөрийн хүүхдүүд, ах дүүсийн охидтой болон залуу найзтайгаа ярилцсан юм. Тэдний надтай хуваалцсан зүйлсийг тунгаан бодож, залбирсны эцэст би эдгээр асуулт, бэрхшээлийн заримд нь хариу болж магад гэж үзэн хэдэн гол санааг гаргаж ирсэн.

Ариун Сүнсийг сонс

Тэнгэрлэг Эцэг бидний залбиралд Өөрийнхөө арга замаар хариулдаг гэдгийг би тунхаглаж байна. Та нарын зарим нь заримдаа үүнээс өөрөөр боддог байж болох юм. Дараах судруудыг тунгаан бодоорой.

“Учир нь гуйсан болгон хүлээн авдаг; мөн эрэлхийлэх тэр нь олдог; мөн тогшсон түүнд энэ нь нээгдэх болно” (3 Нифай 14:8).

“Хэрэв та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно” (Иаков 1:5).

“Болгоогтун, чамд ирж мөн зүрх сэтгэлд чинь орших Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд ярих болно” (С ба Г 8:2).

Тэгвэл бид хэрхэн хариулт, илчлэлт хүлээн авдаг вэ? Бид хэрхэн энэ нь Ариун Сүнс бөгөөд бидний өөрсдийн бодол биш гэдгийг мэддэг вэ? Би амьдралд минь загвар болсон хоёр туршлагыг хуваалцъя.

Тэ эгч бид хоёр хэсэг болзсоны дараа би түүнтэй мөнхөд хамт байхыг хүсэж байгаагаа мэдсэн юм. Ингээд би үүний талаар чин сэтгэлээсээ залбирч, мацаг барив. Ямар нэг тодорхой өөрчлөлт мэдрээгүй бөгөөд чээжинд шатах мэт мэдрэмж төрсөнгүй. Гэвч надад шийдвэр маань зөв санагдаад байсан тул зорьсондоо хүрсэн. Тэ эгч ч гэсэн адил хариулт авсан учраас бид одоо энд байна. Энэ туршлагаас хойш би олон шийдвэрээ үүнтэй төстэй загвараар гаргаж ирсэн (С ба Г 6:22–23-ыг үзнэ үү).

Бид Ариун Сүнсний өдөөлтийг дагаж, хилэнцтийн оронд сайныг сонгож, үүргүүдээ тэнцвэртэй байлгаснаар “эцсээ хүртэл баяр баясгалантай” байж чадна гэдгийг би гэрчилж байна.

Үүнийг Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгаас надад оноосон гадасны шинэ ерөнхийлөгч дуудах тодорхой даалгавартай харьцуулмаар байна. Би энэ даалгавартаа залбирлын болон мацгийн сүнсээр хандах үед хэн дуудагдах ёстойг мэдэхэд тусалдаг онцгой мэдрэмжээр адислагддаг. Энэ мэдрэмж заримдаа

ярилцлагын өмнө, заримдаа ярилцлагын үеэр, заримдаа бүр дараа нь ирдэг. Би үргэлж чээжиндээ шатах мэт мэдрэмжийг мэдэрдэг. Түүнээс хойш ийм үүрэг даалгавар авсан үед Ариун Сүнс намайг иймэрхүү замаар удирдан чиглүүлдгийг би мэддэг болсон.

Яагаад Ариун Сүнс надтай өөр өөр арга замаар харилцдаг вэ? Би мэдэхгүй. Хамгийн чухал нь би эдгээр загварыг хувийн илчлэлт хүлээн авах өөрийн арга зам гэдгийг л сурч авсан. 'Чи даруу бай; тэгвэл чиний Бурхан Их Эзэн чамайг гараас чинь хөтөлж мөн залбирлуудад чинь чамд хариу өгөх болно' (С ба Г 112:10) гэсэн зөвлөмжөөс би тайтгарал, итгэл найдвар олж авдаг.

Хилэнцтийн оронд сайныг сонго

Зарим хүн буруугаас зөвийг ялган танихад улам бүр хэцүү болж байна гэж боддог. Тэдгээрийн хоорондох ялгаа харагдах байдлаараа улам бүр багасаж байна. Өнөө үеийн нийтэд дэлгэрсэн, буруу үзэл санаануудын олон нь нарийн хэмжээст линзээр онцгойлон харах үед зөв мэт санагдах болжээ. Гэвч хуучин хог хаягдлыг шинэ баглаа боодлоор боож, бүтээлчээр сурталчлан таниулсан ч хог хэвээрээ л үлддэг.

Зөв буруут ялган таних нь түвэгтэй зүйл биш юм. Бид Ариун Сүнсний бэлгийг хүлээн авахаасаа өмнө ч Христийн гэрлээр адислагдсан байдаг:

"Учир нь болгоогтун, Христийн Сүнс хүн бүрд тэрбээр сайныг хилэнцтээс ялган мэдэж болохын тулд өгөгдсөн байдаг, иймийн тул, би та нарт дүгнэх аргыг үзүүлье; учир нь Христэд итгүүлэхээр ятгахыг, мөн сайныг хийхийг урьдаг юм болгон нь, Христийн хүч болон бэлгээр илгээгдсэн байдаг; иймийн тул та нар энэ нь Бурханаас гэдгийг төгс мэдлэгээр мэдэж болно.

Гэвч хилэнцтийг хийхийг мөн Христэд үл итгэхийг, мөн түүнийг үгүйсгэхийг, мөн Бурханд эс үйлчлэхийг хүмүүнд ятгах юуг боловч, тэгвэл та нар энэ нь чөтгөрөөс гэдгийг төгс мэдлэгээр мэдэж болно; учир нь чөтгөр энэ маягаар ажилладаг, учир нь тэрбээр сайныг хийхийг хүмүүнд ятгадаггүй" (Моронай 7:16–17).

Өнөө үеийн хамгийн хэцүү сорилтуудын нэг бол амьд бошиглогчийг дэмжих явдал юм. Бидний ихэнх нь "Өө, энэ амархан шүү дээ. Би аль хэдийн дэмждэг. Шалгаад үз" гэх байх.

Гэвч амьд бошиглогчийг дэмждэг гэж өөрсдийгөө үздэг зарим хүний өнөөгийн нийтлэг үзэл бодолд хэрхэн хандаж байгааг харахад хачирхалтай санагддаг. Бидний зарим нь үе тэнгийнхний дарамттай тулгарсан үедээ амьд бошиглогч байдгийг мэдэхгүй гэж бодогдмоор үйлдэл хийдэг эсвэл тийм үзэл бодолтой мэт болчихдог.

Зөв тэнцвэрээ ол

Та нарт маш олон зүйл хийдэг учраас тал тал тийшээ татагдаж байгаа мэт санагддаг уу? Юу гээч? Энэ нь яваандаа илүү хэцүү болно. Тэгвэл танд зөв тэнцвэрээ хэрхэн олох вэ? гэдэг асуулт гарна.

Сүнснийхээ мөнхийн мөн чанар, Бурханы хүү, охин гэсэн тодотголоо өөрсдийнхөө зам заагч гэрэл болго. Энэ үнэнд, энэ нь юу гэсэн үг вэ гэдэгт бүх хүчээ хандуул. Ингэснээр бусад бүх зүйл амьдралаас тань алга болж эсвэл зохих байр байрандаа очих болно.[1] Дараах хоёр судар удирдах зарчим болдог.

"Харин та нар эхлээд Бурханы хаант улсыг мөн түүний зөв шударгыг эрэлхийл, мөн эдгээр бүх зүйл та нарт нэмэгдэн өгөгдөх болно" (3 Нифай 13:33).

"Тэнгэрт эд баялгийг өөрсдөдөө хураа. Учир нь тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэггүй, хулгайч ч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй.

Учир нь баялаг тань хаана байна, тэнд зүрх сэтгэл тань түүнчлэн байдаг" (Матай 6:20–21).

Би та нарын оронд байж үзсэн гэвэл та нар итгэх үү?. Тэ эгч бид хоёр бяцхан гэр бүлээ өсгөж байх үедээ би бүрэн цагийн ажлынхаа дараа оройн цагаар хичээлд явж, хичээлийнхээ дараа өглөө болтол

хоёр дахь хагас цагийн ажлаа хийдэг байсан. Би хоёр сарын турш долоо хоногт хэдхэн өдөр цөөхөн цагаар унтаж байв. Энэ бүхний хажуугаар би тойргийн бишопын зөвлөлд үйлчилж байсан юм.

Энэ бол миний амьдралдаа хамгийн үр бүтээлтэй өнгөрүүлсэн үе байсан. Би хэзээ ч өдрийн 24 цагийг энэ үе шиг ийм их үр бүтээлтэй ашиглаж байгаагүй.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) бид өөрсдийн гэр бүл, ажил олгогчийн өмнө мөн Их Эзэний болон өөрсдийнхөө өмнө хариуцлага хүлээдгийг бидэнд сануулсан.

Бид хэрхэн энэ хариуцлагуудаа тэнцвэртэй авч явах вэ? Ерөнхийлөгч Хинкли “Би үүнийг хэцүү зүйл гэж бодохгүй байна. Би энэ Сүмд олон үүрэгт ажилд үйлчилж байсан. Би энэ олон үүрэгт ажилд үйлчилж байхдаа бага насны болон өсөж том болж байсан таван хүүхдийн эцэг байсан юм. . . . Бид амьдралдаа сэтгэл хангалуун байж, гэр бүлийн үдшээ хийдэг байсан. Бид зүгээр л Сүмийн биднээс хийхийг хүссэн зүйлсийг хийдэг байсан”[2] гэжээ.

Эцсээ хүртэл баяр баясгалантай бай

Эцсээ хүртэл тэвчинэ гэдэг нь сайн мэдээний жагсаалтын дагуу хийж дуусган, “Би болж байна. Би одоо үргэлжлүүлэн хийхэд л хангалттай” гэж хэлэхийг хэлдэггүй Харин энэ нь байнга суралцаж, өсөж хөгжихийг хэлдэг. Есүс Христийн сайн мэдээ бол тогтмол наманчилж, өөрчлөгдөх явдал юм. Энэ нь үргэлж хичээж чармайхыг шаарддагаас гадна тийм ч амар хялбар байдаггүй.

Хаан Бенжамин “Мөн эдгээр бүх зүйлс мэргэн ухаанд мөн эмх цэгцэнд хийгддэг байхыг мэдэгтүн, учир нь хүн өөрт нь буй хүчнээс илүү хурдан гүйх шаардлагагүй” (Мозая 4:27) гэж хэлсэн.

Зарим хожмын үеийн гэгээнтэн илүү сайн хичээх эсвэл хамгийн сайнаараа үйлдэх хүсэлгүй байгаагаа энэ шүлгээр зөвтгөдөг. Тэд зөвхөн шүлгийн эхний хагаст анхаарлаа хандуулж байгаа нь хамгийн гол асуудал юм.



Хоёр дахь хагаст нь: “Тэрээр хичээнгүй байх шаардлагатай, тэгснээр тэр шагналыг хожиж болохын тулд бөлгөө; тиймийн тул бүх зүйл эмх цэгцэнд хийгдэх ёстой” гэсэн байдаг. Энэ хоёр хэсэг нийлээд, аливаа зүйлийг мэргэн ухаан болон эмх цэгцэнд хийнэ гэсэн нь юу гэсэн үг болохыг тайлбарладаг.

Нэг тамирчин найз маань *хоёр дахь хандлага* хэмээх хандлагын тухай надад танилцуулсан бөгөөд энэ нь ядарсан үед ч танд хийх хүч өгдөг шинэчлэгдсэн эрч хүчийн мэдрэмж юм.

Амьдралынхаа бусад тал дээр хоёр дахь хандлагаа олсон талаараа найз маань: “Коллежийн оюутнуудын хувьд гэртээ оройтож хариад орой нь залбирах, судар унших, тэр байтугай ариун сүмд тогтмол очиход дэндүү ядардаг гэдгээр шалтаглах нь амархан байдаг. Ялангуяа коллежийн оюутнуудад эдгээрийг хийхгүй байх олон шалтаг гарч болно. Гэвч эцсийн эцэст бид хоёр дахь хандлагаа олж, тэдгээр жижиг зүйлийг хийх хэрэгтэй” гэж хэлсэн юм.

Магадгүй, эцсээ хүртэл *тэвчихийн* оронд бид хоёр дахь хандлагаа буюу сүнслэг хандлагаа олж, эцсээ хүртэл *баяр баясгалантай* байж чадна. Бид Ариун Сүнсний өдөөлтийг дагаж, хилэнцтийн оронд сайныг сонгон, үүрэг хариуцлагаа тэнцвэржүүлэх замаар үүнийг хийж чадна гэдгийг би гэрчилж байна. ■

2015 оны 6-р сарын 9-нд Айдахо дахь Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн “These Are Your Days” үгээс авав. Англи хэл дээрх бүрэн эхийг web.byui.edu/devotionalsandspeeches хаягаар орж үзнэ үү.

ЭШЛЭЛҮҮД

1. Ezra Taft Benson, “The Great Commandment —Love the Lord,” *Ensign,* May 1988, 4.
2. *Teachings of Gordon B. Hinckley* (1997), 33.

Өөртөө болон Бурханд үнэнч хандах

Фэйт Садерлин Блакхөрст

Номлолын хугацааныхаа талд ороод байтал хамтрагч бид хоёр тойргийн номлолын удирдагчтайгаа сайн ажиллаж чадахгүй зовж байлаа. Олон удаа санал зөрж, маргалдаж байсан учраас бид бишоптой уулзаж, юу хийж болохоо ярилцахаар шийдэв. Би дотроо бишоп түүнтэй ярилцаж, бидний хооронд үүссэн асуудлыг өмнөөс маань шийдэж өгөх байх хэмээн найдаж байлаа.

Гэтэл бишоп намайг бардам бөгөөд бусдад хэт шүүмжлэлтэй хандаж байна гэж хэлэв. Би буруу ойлгогдож, бачимдсандаа гэр рүүгээ уууртайгаар дэвслэн алхлаа. Тэр яаж миний талаар тэгж хэлж чадаж байна вэ? Сайн мэдээг хуваалцах гэж бид ямар их зовдгийг тэр мэдэж байгаа юм уу?

Явах зуураа би өөрт төрсөн мэдрэмжийг хамтрагчдаа хэлэв. Гэтэл гэнэт "Гэмтнүүдэд үнэн нь хатуу санагд[даг]" (1 Нифай 16:2) гэсэн үгс толгойд минь орж ирлээ. Энэ үг намайг тэр бодлоо өөрчлөхөд хүргэсэн юм. Энэ бодол Сүнснээс ирсэн нь илт байв. Бардам зан маань надад бишопын зэмлэлийг хүлээн авахад саад болж байсан бол би Ариун Сүнстэй үнэхээр тэрсэлдэж чадна гэж үү?

Миний буруу байсан бөгөөд Бурхан надад буруу гэдгийг мэдүүлж байлаа.

Бардам зан маань надад бишопын зэмлэлийг хүлээн авахад саад болж байсан бол би Ариун Сүнстэй үнэхээр тэрсэлдэж чадна гэж үү?

Өөрийгөө зөвтгөх үзлээс салах

Тэр үед надад буруу хийсэн зүйлээ тэгсгээд өнгөрөөх нь илүү эвтэйхэн байв. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф санал нэгтэйгээр "Бидний хэн нь ч зөв замаасаа хазайж байгаагаа хүлээн зөвшөөрөх дургүй. . . . Тиймээс бид амьдралаа дүгнэж цэгнэхдээ зохисгүй бодол, үйлдлүүдээ зөвтгөж байдаг өрөөсгөл үзэл, шалтаг, шалтаануудаар халхлагдсан тийм л цонхоор харддаг билээ"[1] хэмээн хэлсэн.

Миний хувьд би бусийнхээ номлолын ажлыг сайжруулах үүднээс гомдол мэдүүлсэн гэдэгт өөрөө өөрийгөө итгүүлсэн байв. Тойргийн номлолын удирдагчийнхаа итгэлтэй үйлчлэлийг, хэдийгээр төгс бус хэмээн надад бодогдож байсан ч хүлээн зөвшөөрөхийн оронд би өөрөө талархалгүй, тэвчээргүй, эх захгүй, эелдэг бус байснаа гэнэт харав. Сүнсний өдөөлтийн ачаар би өөрийнхөө үйлдлийг үнэндээ яг ямар байсныг олж харж чадсан юм.

Сүнслэг байдлын бодит шалгалт

Сүнснээс ийнхүү шууд зэмлэл хүртэх хэцүү байсан ч энэ нь миний тусын тулд байв. Энэ нь өөрийнхөө алдаа дутагдалд шударга байх хэрэгтэй гэдгийг ухааран ойлгоход надад тусалсан.

Энэ үйл явцад Сүнс бол миний хамгийн агуу холбоотон юм байна гэдгийг би юуны түрүүнд олж мэдсэн юм. Далын ахлагч Ларри Р.Лорэнс Сүмийн гишүүдэд хандан "'Өсөж хөгжихөд маань надад юу саад болж байна вэ?'. . . гэсэн асуултыг Их Эзэнд даруухнаар тавь.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ИОШУА ДЭННИС

Хэрэв та чин сэтгэлээсээ асуусан бол хариулт нь удалгүй тодорхой болно. Энэ нь зөвхөн танд зориулагдсан илчлэлт байх юм"[2] хэмээн хэлсэн нь яг надад зориулан хэлсэн үг мэт байлаа. Сул талуудаас гадна тэдгээрийг хэрхэн засаж залруулж болох тухай сүнслэг өдөөлтийг хүлээн авах хүч надад байгааг би мэдэж байсан.

Сул дорой байдлаас хүчирхэгжих

Энэ үйл явдал "хэрвээ [би] сул тал, дутагдлуудаа сүүдэрт нуун далдлаад байвал Аврагчийн гэтэлгэх хүч тэдгээрийг эдгээж, хүчирхэг болгож чадахгүй"[3] гэдгийг надад заасан.

Гэхдээ би эмзэг байхаас эмээлгүй, сул талаа даруухнаар хүлээн зөвшөөрөх юм бол Бурхан ач ивээлээрээ надад тэдгээрийг маань хүчирхэгжүүлж өгөх болно (Ифер 12:27, 1 Петр 5:5-ыг үзнэ үү).

Эцсийн эцэст өөрсдийн сул талыг хүлээн зөвшөөрөх буюу байгаагаар нь харах нь эерэг өөрчлөлт хийх зам дээр хийдэг анхны алхам юм. Би шударга байж, Сүнсний удирдамжийг эрэлхийлэх юм бол Тэнгэрлэг Эцэг маань амьдралдаа юугаа өөрчлөх хэрэгтэй гэдгийг надад хэлж өгнө. Мөн би Есүс Христ, Түүний Цагаатгал, цэвэршүүлэгч хүчинд нь итгэж найдах юм бол өөрөөсөө өөрчлөлтийг олж харах болно.

Хэдийгээр зэмлэл хүртэх мөчид алдаагаа хүлээн зөвшөөрөх тийм сайхан байгаагүй ч даруухан байж, өөртөө болон Бурханд шударга байснаар би илүү аз жаргалтай болж, өөрөө өөрийгөө хүлээн зөвшөөрдөг болсон. Хэдийгээр надад алдаа дутагдал байдаг ч би Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө бурханлаг үнэ цэнтэй гэдгээ мөн Тэрээр намайг сайжраасай хэмээн хүсдэг болохыг мэднэ. Түүний Хүү Есүс Христийн хүчээр мөн чин сэтгэлийн наманчлалаар дамжуулан би өөрийн төсөөлж ч байгаагүй тийм сайн хүн болж чадна. ■

Зохиогч нь АНУ-ын Юта мужид амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Дийтр Ф.Угдорф, "Би биш биз дээ, Эзэн минь?" *2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 67.
2. Ларри Р.Лорэнс, "Надад юу дутагдаж байна вэ?" *2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 17.
3. Дийтр Ф.Угдорф, "Би биш биз дээ, Эзэн минь?" 67.

ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГ УЙТГАРТАЙ БОЛОВ УУ?

Би Халамжийн нийгэмлэгт нэгдэнэ гэхээс ихэд сандарч байсан ч тэд намайг сайхан хүлээж авсан тул дуртай болсон юм.

Шарлотт Ларкэбэл
Сүмийн сэтгүүлүүд

Би 18 хүрсэндээ маш их баярлаж байв. Ямар өсвөр насны хүүхэд баярлахгүй байх билээ дээ? Мэдээж би ахлах сургуульд сурдаг, нүүрэндээ батгатай бас АНУ-ын Калифорни мужид байдаг гэртээ ойр зуурын гэр орны ажлыг хийдэг хэвээр байсан ч насанд хүрсэн байлаа. Би амьдралынхаа цоо шинэ үе шатанд орж байгаадаа баярлаж байв. Нэг зүйлийн талаар тийм ч баяртай байгаагүй нь Халамжийн нийгэмлэгт "хөгшин эмэгтэйчүүдтэй" хамт байх явдал байлаа. Тэд үр хүүхэдтэй, ажил мэргэжилтэй бас удаан чанагчтай, магадгүй гэрийн шаахайгаа өмсөөд жимсний бялуу жигнэх дуртай хүмүүс байх. Харин би бол гэрийн даалгавартай, усанд сэлэлтийн тэмцээнтэй, цэнхэр хумсны будагтай мөн өрөөгөө цэвэрлэхээс аль болох зайлсхийх дуртай нэгэн байв. Би яаж тэнд байгаа хүмүүстэй ойлголцох юм бэ? Тэнд эв хавгүй, ганцаардсан, уйтгартай мэдрэмж төрүүлнэ гэдэгт би итгэлтэй байв. Тэгээд би явж орлоо.

Юуны түрүүнд, Халамжийн нийгэмлэгт огтхон ч уйтгартай байсангүй. Тэнд зөндөө инээд хөөр, баяр баясалтай байв. Тэд сонирхолтой, чин сэтгэлийн үгсээ хуваалцаж байсан ч инээлдэхээсээ эмээхгүй байв. Хоёрдугаарт, тэд надаас тийм ч их өөр байсангүй. Мэдээж тэд надаас эгчмэд, гэсэн ч яг л миний найз нөхөдтэйгөө хөгжилддөгтэй адил бие биетэйгээ хошигнон инээлдэж байв. Миний бодож байсан асуултыг хэн нэгэн нэг бус удаа асуусан. Харин тэр долоо хоногт дараагийн баяжуулалтын цуглааныг зарлахад би цочирдов. Тэд биеэ хамгаалах талаар сурах гэж байлаа. Би ч бас сурахыг хүсэж байв.

Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Ларсэн эгч надаас босоод өөрийгөө танилцуулахыг хүсэхэд би их сандарч байсан боловч энэ нь тийм ч хэцүү байсангүй. Хүн бүр над руу инээмсэглэн харж байлаа. Миний хоёр дахь жилийн семинарын ангийн багш байсан Эдвардс эгч эрхий хуруугаа өргөн намайг сайшааж, Хүүхдийн хэсэгт байх үеэс минь намайг мэдэх Ричардс эгч намайг аль хэдийн "том болсонд" итгэхгүй байна гэж хэлсэн юм. Тэд надтай үнэхээр "том болсон" мэт харьцаж байлаа. Надад гоё хувцас өмсөн тоглож байгаа хүүхэд мэт санагдсан ч тэр өдөр би ихэнх эмэгтэйн хувьд шинэ эгч байв.

Тэр өдрөөс хойш би ямар ч тойрогт байсан Халамжийн нийгэмлэгт дуртай болсон юм. Халамжийн нийгэмлэгийн анги руу оронгуут надад эгч дүүсийн холбоо, байх ёстой газраа байна гэсэн мэдрэмж төрдөг. Би Халамжийн нийгэмлэгийнхээ эгч нарыг дэмжихийн тулд чадах бүхнээ хийж, тэднээс сурч болох бүхнийг сурах дуртай.

Харин би жимстэй бялуу хийхдээ гарамгай сайн гэдгээ мэдэж авсан. ■

“Бид бүгдээрээ тэнгэрт хамтдаа зэрэгцэн суухын төлөө бие биеэ дэмжиж, анхаарч халамжлан, тайтгаруулж, заавар зөвлөгөө өгдөг байх ёстой.”

—Люси Мак Смит, бошиглогч Иосеф Смитийн ээж (*Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* [2011], 25).

ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Бошиглогч Иосеф Смит Халамжийн нийгэмлэгийг 1842 оны 3-р сарын 17-нд Иллиной мужийн Науву хотод байгуулсан юм. Тус байгууллага нь ядуус хийгээд гачигдагсдыг халамжилж, хүмүүсийг Христэд авчрах гэсэн хоёр үндсэн зорилготой. Халамжийн нийгэмлэг нь өнөөдрийг хүртэл дэлхийн хамгийн том эмэгтэйчүүдийн байгууллагын хувьд үйл ажиллагаагаа явуулсан хэвээр байгаа. Эгч нар ням гараг бүр мөн шаардлагатай өөр өдрүүдэд цуглардаг.

ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГЭЭС ЮУ ХҮСЭН ХҮЛЭЭЖ БОЛОХ ВЭ?

- Таныг хайрлаж, дэмждэг хэсэг бүлэг эмэгтэй
- Айлчлагч багшийн хувьд бусдыг хайрлаж, тэдэнд үйлчлэх боломж
- Таны хувийн амьдралд тусалж, эмэгтэй хүн, эх хүн, хэн нэгний охин, нагац, авга эгчийн хувьд хүлээсэн үүргээ хөгжүүлж, үйлчлэх боломжоор хангах Ням гаргийн хичээл болон бусад цугларалт

АХЛАГЧДЫН

ЧУУЛГАД ОРСОН АНХНЫ ӨДӨР

Би тэр үед залуухан, шинэхэн ахлагч байв. Би ахлагчдын чуулгад ямар хувь нэмэр оруулж чадах вэ? Үнэн хэрэгтээ маш их байв!

"Ах дүүстээ үнэгүйгээр өгч—тэднийг үргэлж хайрлан, бүхий л талаар тусалж байх нь гэгээнтэн бүрийн үүрэг юм. . . . Бид эцэггүй хүүхдүүд, бэлэвсэн эмэгтэйчүүдийг эргэж тойрч, зовж зүдэрсэн үед нь анхаарал халамж тавьдаг байх ёстой."

Иосеф Смит, Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007), 483.

Даллин Лудкэ

Би тэндээс юуг хүсэн хүлээж болохыг мэднэ гэж бодож байсан тул ахлагчдын чуулгад орохдоо тийм ч их сандарсангүй. Мөн би тойргийнхоо ахлагчдын чуулгынхныг бүгдийг нь таньдаг байлаа. Тэд найзуудын маань аавууд мөн сурган хүмүүжүүлдэг хүмүүсийн хувьд миний хүндэлж явдаг хүмүүс байв. Тэд аливаа зүйлийг ойлгоход минь туслахад бэлэн гэдгийг би мэдэж байсан тул ахлагчдын чуулгад тэдэнтэй нэгдэхдээ сандарсангүй.

Би хичээлд оролцохоос л бага зэрэг эмээж байлаа. Эхэндээ амьдралын арвин туршлагатай, намайг бодвол хамаагүй ухаалаг эрчүүдэд хэлчихмээр санаа оноо надад огт байхгүй мэт санагдаж байсан.

Энэ нь өөр байсан ч адилхан байв

Ахлагчдын чуулга яах аргагүй пристийн чуулгаас өөр байлаа. Ойролцоо насны залуучуудын оронд гэнэт томчуудтай хамт хичээлд суух болов. Эхний хоёр удаа очихдоо би бараг үг дуугарсангүй. Би хэтэрхий бага залуу бөгөөд хувь нэмэр болчихоор зүйл надад байхгүй гэдэгт санаа зовж байлаа.

Гэхдээ явах тусам би дассан бөгөөд хэдэн настай байхаас үл хамааран хүн бүрд хувь нэмэр оруулах зүйл байдаг гэдгийг ухааран ойлгосон юм. Хүн бүр сайн мэдээтэй холбоотой өөр өөрийн туршлагатай, өөр өөр зарчмын талаар янз бүрийн түвшний ойлголттой байв.

Надад бусадтай хуваалцах зүйл байсан

Нэг удаа Аврагчийн Цагаатгалын талаар ярилцаж байхад би гараа өргөлөө. Есүс Христ Цагаатгалынхаа ачаар биднийг гэм нүглээс маань чөлөөлөхөөс гадна бидэнд Өөртэйгөө болон Бурхантай илүү ойртоход тусалдаг хэмээн хэлэв. Түүнчлэн би Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй харилцах өөрийн харилцааны талаар мөн Цагаатгалын тухай миний ойлголт өсөж хөгжих тусам энэхүү харилцаа улам хүчирхэгжиж байдаг тухай ярилаа. Ангийн дараа нэг ах над руу дөхөн ирээд, хэлсэн зүйлд маань талархаж байгаагаа хэлсэн юм. Тэр бас аливаа зүйлийг хэзээ ч миний хэлсэнтэй адил байдлаар бодож байгаагүй бөгөөд санал бодлоо илэрхийлсэнд үнэхээр баярлаж байгаагаа хэлсэн билээ.

Гэрийн багшаар явах үнэхээр сайхан!

Ахлагчдын чуулгад та багшаасаа гадна Сүнснээс мөн чуулгад байх бүх хүнээс суралцдаг. Тэр бүх үзэл бодол нь сурсан зүйлээ илүү сайн ойлгоход танд тусалдаг. Мөн энэ нь Их Эзэний илүү сайн үйлчлэгч болоход танд тусалдаг юм. Жишээлбэл, би ахлагч болсноосоо хойш гэрийн багшаар явах дуртай болж эхэлсэн. Миний бодлоор би хэдэн сарын дараа номлогч болохдоо яг л гэрийн багшаар очиж заадагтай адил хүмүүс дээр очиж, сайн мэдээний захиасыг хуваалцах болно гэдгээ мэдэж байсан тул уг дуудлагыг арай илүү чухалчилж авч үздэг байсан. Зүгээр тэнд суугаад, хамтрагчаараа бүх хичээлийг заалгуулахын оронд гэрийн багшаар очихдоо би бэлддэг болсон юм. Би ярианд оролцохыг хичээдэг болсон. Энэ нь номлолын ажилд намайг сайн бэлдэхийн зэрэгцээ гэрийн багшаар явах дуудлагыг илүү утга учиртай болгож өгсөн билээ. Би одоо тойргийнхоо хүмүүст болон гэрийн багшаар очиж заадаг хүмүүстээ илүү их талархах болсон.

Би хийж чадсан юм чинь та ч бас хийж чадна

Та ахлагчдын чуулгынхнаас эмээх хэрэггүй, харин судалж байгаа сэдвийнхээ талаар илүү ухаалаг үгс сонсоно гэдэгтээ итгэлтэй байж болно. Мөн та Их Эзэний илүү сайн багш, удирдагч, үйлчлэгч болно гэдэгтээ итгэж болно. Ямар гайхалтай гээч! ■

Зохиогч нь АНУ-ын Калифорни мужид амьдардаг.

АХЛАГЧДЫН ЧУУЛГААС ЮУ ХҮСЭН ХҮЛЭЭХ ВЭ?

- Чуулгын гишүүдийн хуваалцах ойлголт, үзэл санаа нь Есүс Христ болон Түүний сайн мэдээний талаарх гэрчлэлийг тань хүчирхэгжүүлж, ирээдүйд нөхөр, эцэг мөн санваарын удирдагчийн үүрэг хариуцлагад тань таныг бэлдэж туслах ням гаргийн хичээлүүд орно.
- Санваарын үйлчлэл хийх боломж нь амьдралыг тань адислаж, таны болон чуулгын гишүүдийн хоорондын харилцаа холбоог бэхжүүлнэ.
- Чуулгад нэгдсэнээр та Мелкизедек санваартны шинэ үүрэг хариуцлагад суралцах явцдаа дэмжлэг туслалцаа хүлээн авна.

GETTY IMAGES-ИЙН УСАН ДООР АППАРАТТАЙ ШУМБАГЧИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Нэмэлт тусламж

Алий Арнэлл

Би өөрийн хурдаар доош шумбав. 1.5 метр . . . гэхэд урсгал намайг түрж байгааг би мэдэрлээ. Одоо 3 метр. Гэнэт харанхуйлав. Амьсгал маань давхцаж эхлэхийг би мэдэрлээ. Энэхүү хүйтэн, дүнсгэр далай бидний дасгал хийж байсан усан сантай огт адилгүй байлаа. Айж, харанхуйгаас эмээсэндээ би сумны хурдаар уснаас дээшээ гарч ирэв.

Багшийн туслах надаас "Юу болсон бэ?" гэж асуулаа. Багны дотуур нулимс урсах нь тэр. Би усан доор амьсгалах аппараттай шумбах эрх авах шалгалтынхаа дундуур, шалгалтыг амжилттай өгөхөд шаардлагатай 9 метрийн гүний шумбалт хийж байсан юм. Туслах намайг сандрахыг хараад, бүх зүйл зүгээр болно хэмээн тайвшруулав. Тэр урам зориг өгсөн ч намайг шахаж шаардсангүй. Тэр бүр нэг удаа "Чи үүнийг хийх шаардлагагүй" гэж хэлж билээ. Яг тэр мөчид би хийхийг хүсэж байгаагаа ухаарсан юм.

Хэдийгээр энэ нь хэцүү байгаа ч би шалгалтаа өгч, эрхээ авахыг хүсэж байлаа. Тиймээс би айдсаа дарж, шалгалтыг өгөхөд үзүүлэх шаардлагатай үлдсэн ур чадвараа ангийнхантайгаа хамт хийж гүйцэтгэв. Хэцүү байсан ч би урмын үг сонссоныхоо дараа хийж чадсан.

Олон сарын дараа би Перуд номлолд үйлчилж байхдаа буюу хүмүүсийг итгэлээ хүчирхэгжүүлэн, амьдралаа өөрчлөхөд урьж байхдаа усан доор аппараттай шумбахтай холбоотой хүнд хэцүү туршлагынхаа талаар санасан. Хамтрагч бид хоёрын очих дуртай байсан нэгэн гэр бүл бол Румайгийнхан байв. Карина, Энрикэ нар болон тэдний өсвөр насны Карэн, Никол гэх охид нь биднийг үргэлж найрсгаар хүлээн авдаг байсан бөгөөд бидний зүрх сэтгэлийг маш хурдан татсан юм. Карина, Карэн, Никол нар тун удалгүй сайн мэдээг хүлээн авч, сүмд нэгдэв.

Харин Энрикэд нэмэлт тусламж хэрэгтэй байлаа. Бидний захиас түүний өсөх насандаа сонсож байсан зүйлээс нь тэс өөр байсан тул түүний итгэлийг олж авахад бидэнд нэлээн их хугацаа шаардагдав. Энрикэд янз бүрийн асуудал байв. Сайн мэдээний талаар санааг нь зовоож байсан гол асуудал бол Мормоны Ном байсан юм. Тэр уг номын талаар огт сонсож байгаагүй бөгөөд уншиж, ойлгоход хэцүү байв. Уг номтой танил бус байсан нь Энрикэг эргэлзэхэд хүргэж байлаа.

Тэр үед Энрикэ, хүн бүр амархан шумбаж байхад ганцаараа айдаст автан уснаас дээш гарч ирсэн надтай адил байсан юм. Надад тусламж хэрэгтэй байсан шиг Энрикэд амжилтад хүрэхэд нь нэмэлт тусламж хэрэгтэй байв.

Номлолд байхад таны зарим сонирхогчид хажууд нь байж, үйл явцад хамт шумбан орох хүсэлтэй хүн хэрэгтэй байж магад.

Тэр тусламж янз бүрийн байдлаар ирж байлаа. Түүнд өөрийнхөө асуудлыг гарган илэрхийлж, Сүнсийг мэдрэхэд туслах номлогчид байсан. Түүнд бас найзалж нөхөрлөн, эцэг хүний үүрэг хариуцлага юу болохыг зааж өгсөн тойргийн гишүүд байв. Харин хамгийн том тусламж нь Энрикэгийн гэр бүлийнхнээс ирсэн юм.

Бүр баптисм хүртэхээсээ өмнө Румайгийнхан гэр бүлээрээ залбирч, судраас судлах дадал хэвшилтэй болсон байлаа. Энрикэд Мормоны Номыг судлах явцыг нь илүү хялбарчилж өгөх үүднээс тэд том үсгээр хэвлэгдсэн судрыг аудио бичлэгийн хувилбартай нь авч өгчээ. Эдгээр энгийн хүчин чармайлт Энрикэд хэмжээлшгүй ихээр тусалж билээ. Хэн ч түүнийг шавдуулсангүй, зүгээр л дэмжин тусалж байв. Өөрсдийн үйлдлээр тэд "Чамайг хийж чадна гэдгийг бид мэднэ" гэдгээ хэлж байсан юм.

Энэ нь Энрикэд Мормоны Номын хүчийг өөрөө олж нээхэд нь тусалсан. Нэг л өдөр тэрээр номыг бүтнээр нь сонссон бөгөөд Бурханы үг гэдгийг нь мэднэ гэдгээ хэлсэн юм. Эхнэр охид нь баптисм хүртсэнээс хойш ойролцоогоор дөрвөн сарын дараа Энрикэ тэдэнтэй адил алхмыг хийж, баптисм хүртсэн.

Тэднээс хүлээн авсан тусламж болон тэвчээртэй байсанд нь тэр талархдаг бөгөөд энэ нь өөрт нь өнөөдөр, энд байх боломжийг олгосон хэмээн Энрикэ хэлдэг. Энэ гэр бүлийнхнийг нөхөртөө, аавдаа эргэлзээгээ ялан дийлэхэд тусалж байхдаа үзүүлсэн хайрын үлгэр жишээг харах боломж олдсон явдал номлогч миний хувьд адислал байв. Түүнчлэн миний усан доогуур аппараттай шумбах туршлага надад Энрикэд ямар мэдрэмж төрж байсныг мөн бусад хөрвөгчийн хөрвөгдөх явцад тэдэнд ямархуу байсныг бага ч болов ойлгох боломжийг олгосонд би талархдаг.

Номлолдоо хүмүүсийг наманчилж, өөрчлөгдөхөд урихдаа заримдаа бүх хүнд амжилтад хүрэхэд нь нэмэлт урам зориг хэрэгтэй гэдгийг та бүү мартаарай. Тэдний хажууд найдвартай, туршлагатай мөн "Бүх зүйл зүгээр болно. Чи хийж чадна. Би чамд итгэж байна" гэж хэлэх хэн нэгэн байх хэрэгтэй байж магад. Тэдэнтэй хамт шумбаж, шинэ дадал хэвшил, ур чадварт суралцаж, эрхээ авахад нь буюу Их Эзэний зөвшөөрлийг хүлээн авахад туслах тэр хүнийг таныг байгаасай хэмээн тэд найдаж байж болно. ■

Зохиогч нь АНУ-ын Айова мужид амьдардаг.

БИДНИЙ ОРОН ЗАЙ



АМЬД БОШИГЛОГЧИЙН ҮГС НӨЛӨӨЛСӨН

БИ 15 НАСТАЙ БАЙХДАА СУПЕРМАРКЕТЫН ӨМНӨ хоёр номлогчийг харсан юм. Тэдний нэг нь намайг сүмд ирээрэй хэмээн урив. Би сонирхоогүй тул "Хэзээ нэгэн цагт магадгүй ээ" гэж хэлээд цааш явсан.

Маргааш нь нагац эгч маань ээж рүү утасдаад, гэрт нь ирж онцгой захиас сонсоорой гэв. Би ээжтэйгээ хамт гүйж очиход өмнөх өдөр нь харсан яг тэр номлогчид нагац эгчийн маань гэрт сууж байх нь тэр! Ээж тэдний захиасыг сонирхсон бөгөөд би ч бас сонсож эхлэв. Харин номлогчид надаас амьд бошиглогчдод итгэдэг үү гэж асуухад нь би эрс шийдэмгий үгүй гэж хариулсан юм. Нэг номлогч Томас С.Монсоны зургийг бариад, ерөнхийлөгч Монсон бол бошиглогч хэмээн гэрчлэв. Тэд намайг маргааш нь болох Ерөнхий чуулганд ирээд шийдвэрээ гаргаарай хэмээн урилаа. Би ч сонирхож, урилгыг нь хүлээн авав.

Дараа өдөр биднийг цуглааны байранд ирэхэд нээлтийн залбирал дуусаж байлаа. Би танхимд орж ирэхдээ ерөнхийлөгч Монсон дэлгэцэн дээр гарч ирэхийг харав. Тэр инээмсэглээд, "Хайрт ах, эгч нар аа, би та бүхнийг . . ." гэж хэллээ.

Ерөнхийлөгч Монсонг амаа нээнгүүт надад хүчтэй мэдрэмж төрж, тэр бол Бурханы бошиглогч гэдгийг баталсан юм. Чуулганы дараа би номлогчдод "Би баптисм хүртмээр байна" гэж хэлэв. Тэр өдрөөс хойш би өөрөө ч номлолд үйлчилж, сэргээгдсэн сайн мэдээний гайхалтай үнэнийг өөр олон хүнд заасан билээ.

Бурхан бошиглогчдыг дахин дуудаж биднийг адисалсан гэдгийг би мэднэ. Тэр биднийг хайрладаг бөгөөд орчин үед бошиглогчдоор дамжуулан бидэнтэй ярьдаг. ■

Майкон Б., Бразил, Сан Пауло

Бид бошиглогч, төлөөлөгчдийг хэрхэн дэмжин баталж болох вэ?

1. Бурхан дэлхийн хэнд заахын тулд Өөрийн бошиглогчдыг дуудсан гэсэн гэрчлэлийн төлөө залбир (Иеремиа 1:5, 7-г үзнэ үү).
2. Тэднийг хайрлаж, тэдний төлөө залбир.
3. Нэр алдартай биш ч тэднийг дэмж.
4. Тэдний сургаал болон үлгэр жишээг судал.
5. Тэднийг дага. Тэдний хэлсэн үгэнд итгэж, заасан зүйлийг нь дагахыг хичээ (С ба Г 21:4-6).

БИ ИЧИХГҮЙ

ДОТУУР БАЙРТАЙ СУРГУУЛЬД СУРЧ БАЙХДАА БИ бусад сурагчтай хамт дотуур байранд амьдардаг байв. Би залбирч, судруудаас тогтмол судалснаар сайн мэдээний зарчмуудын дагуу чадлынхаа хэрээр амьдрахыг хичээж байлаа.

Нэг өдөр ангийн маань хүүхэд намайг орондоо Мормоны Ном уншиж байхыг харчихав. Тэр яагаад манай сүмийг хуурамч гэж боддогоо уртай гэгч урсгаж гарлаа. Дараа нь тэр байрны бусад хүүхдэд миний “сонин” шашны талаар ярих болов. Ангийн маань зарим хүүхэд намайг болон миний шашин шүтлэгийг шоолж, харин зарим нь надаас дөлөх боллоо. Эцэст нь би Мормоны Номоо хувцасныхаа хайрцган доор нууж, ангийнхандаа шоолуулахгүйн тулд зөвхөн Библи уншиx болов.

Би Ром 1:16-д “Би сайн мэдээнээс ичихгүй. Яагаад гэвэл тэр нь итгэгч хүн бүрийг аврахад хүргэх Бурханы хүч мөн” хэмээх мэдэгдлийг унших хүртлээ Библиэс л суралцаж байв. Мормоны Номыг нууснаараа би ангийнхандаа шашин шүтлэгээсээ ичиж байгаагаа харуулж байна гэдгээ ухаарсан юм. Би Мормоны Номоо гаргаж ирээд, Тэнгэрлэг Эцэгээс уучлалт гуйв. Дараа нь би ангийнхан дээрээ очоод сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлээ хуваалцлаа. Ихэнх нь намайг шоолохоо больж, надтай дахин найзлах болсон.

Бидэнд тохиолддог сорилт бэрхшээлийг Бурхан ойлгодог гэдгийг би мэднэ. Бид шашин шүтлэгээ хамгаалж, “Христийн сайн мэдээнээс ичихгүй” гэдгээ харуулах юм бол Тэр бидэнд Өөрийн хүч, хамгаалалт, удирдамжийг өгөх болно. ■

Памэла О., Нигери, Абужа

ДОХИОНЫ ХЭЛЭЭР ДАМЖУУЛАН ҮЙЛЧЛЭХ

МИНИЙ ЗУРГААН САРТАЙ БАЙХДАА АНХ СУРСАН дохионы үг маань “сүү” гэсэн үг бөгөөд хэдэн долоо хоногийн дараа “панда” гэж анх хэлж сурсан гэдэг. Би сонсголтой ч миний анхны хэл америк дохионы хэл байсан юм. Ээж маань америк дохионы хэлний номлолд үйлчилж, дараа нь дохины хэлний сургуульд үргэлжлүүлэн сурсан бөгөөд надад заахыг бас хүсдэг байлаа.

Дохионы хэл амьдралын маань гайхамшигтай адислал байсан юм. Энэ нь надад үүнийг мэдэхгүй байснаас илүү ихийг олж харан, суралцах боломжийг олгосон. Энэ нь хүмүүсийг нэгтгэдэг. Би сурсан зүйлээ ганцаарчилсан сургалтаар зааж, сургууль болон сүм дээр танилцуулга хийх дуртай байв. Мөн Ерөнхий чуулган болон Сүмийн бусад видео бичлэгийг ээжтэйгээ хамт дохионы хэл дээр үзэх үнэхээр хөгжилтэй байдаг.

Дохионы хэл миний амьдралд байснаар гэрчлэлийг маань гайхалтай хөгжүүлсэн билээ. Би дохионы хэлийг сурснаар Бурханы олон хүүхэдтэй танилцах боломжтой болсон бөгөөд энэ нь бас бусдад хүрч үйлчлэх сайхан арга зам юм. Миний амьдралд энэ адислал байгаад мөн олон гайхалтай хүнтэй танилцаж, тэднээс суралцах боломжтой байгаадаа талархдаг. ■

Израил Х., АНУ, Орегон муж

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ Ж.БЭТ ЖЭПСОН

ХУУДАС БҮР ДЭЭР **"БИД ИТГЭДЭГ" ГЭСЭН БАЙЛАА**

Ангийн хүүхэд маань мормончууд Христэд итгэгчид биш гэсэн учраас би Мормоны Номыг цоо шинэ арга барилаар уншихаар шийдэв.

Ричард М.Ромни
Сүмийн сэтгүүлүүд

"Мормончууд Христийн шашинтнууд биш."

Ахлах сургуулийн ангийн хүүхдийн маань хэлсэн үг намайг цочролд оруулав.

"Мэдээж бид Христийн шашинтнууд мөн" гэж би хариуллаа.

"Тэгвэл яагаад та нар Мормоны Номыг уншдаг юм бэ?" гээд надад хариулах ч боломж олголгүй цааш явав.

Би энэ асуултын талаар их бодож билээ. Хариулт нь мэдээж *мормончууд* Христийн шашинтнууд мөн бөгөөд Мормоны Ном *бол* Есүс Христийн бас нэгэн гэрээ гэсэн хариулт юм. Бид уг номыг Библитэй хамт уншдаг бөгөөд Аврагчийн талаар илүү ихийг суралцдаг.

Би өмнө нь Мормоны Номыг уншиж байсан бөгөөд үнэн гэдгийг нь мэдэж байсан. Гэхдээ ангийнхаа хүүхдийн асуултын ачаар би үүнийг өөр арга замаар буюу уг номд Есүс Христийг хэдэн удаа дурдаж байгааг нь тэмдэглэж судал гэсэн сүнслэг өдөөлт хүлээн авсан юм. Үүнийг дагаснаар би гайхалтай зүйлийг олж мэдэв.

Би номыг дөнгөж нээнгүүт нүүр хуудсан дээр нь Мормоны Номыг "өөрийгөө бүх үндэстнүүдэд үзүүлэх тэр Есүс бол Христ, Мөнхийн Бурхан" гэдэгт уншигчдыг итгүүлэх зорилгоор бичсэн гэдгийг уншлаа.

Мормоны Номын удиртгал дээр "Мормоны Номонд товчоологдсон тэргүүн чухал үйл явдал нь Их Эзэн Есүс Христ амилсныхаа дараахан нифайчуудын дунд өөрийн биеэр тохинуулсан явдал юм" гэсэн байхыг уншив. Уг цэдэг үнэн гэсэн Ариун Сүнсний гэрчийг хүлээн авсан хүмүүс "мөнхүү хүчээр Есүс Христ бол энэ дэлхийн Аврагч . . . гэдгийг мэдэж авах болно" хэмээсэн байлаа.

Мормоны Номыг орчуулсан ялтаснуудыг тэнгэр элч тэдэнд үзүүлж мөн "бид үзсэнээ мөн эдгээр зүйлүүд үнэн гэдгийг бид гэрчилж байгаа нь Эцэг Бурханы, мөн Их

ХУВИЙН ЭРЭЛ ХАЙГУУЛ

Та Мормоны Номыг судлах юм бол Есүс Христийн талаар мэдэж авахад амархан байна. Та уншиж байхдаа тэмдэглэл хөтөлж эсвэл Судруудын удирдамж гэх мэт Мормоны Ном дээр Есүс Христийг эш татсан шүлгүүдийг жагсаасан суралцахад туслах материалыг ашиглаж болно. Мормоны Ном бол үнэхээр Есүс Христийн бас нэгэн гэрээ мөн.

Эзэн Есүс Христийн ач ивээлээр гэдгийг бид мэднэ" хэмээсэн "Гурван гэрчийн гэрчлэл"-ийг нээв.

Дараа нь "Бошиглогч Иосеф Смитийн гэрчлэл"-д тэнгэр элч Моронайн айлчлалын талаар дурдсан байсан бөгөөд тэрээр Мормоны Номонд "Аврагчаар эртний оршин суугчдад хүргэгдсэн" үүрдийн сайн мэдээний бүрэн байдал агуулагдсан гэдгийг хэлсэн байлаа.

Би 1 Нифай руу ороогүй байхдаа л аль хэдийн олон зүйлийг олсон байв.

Миний эрэл үргэлжилсээр. 1 Нифай дээрээс би Мессиагийн ирнэ гэдгийг Лихай мэдэж байсныг олж мэдэв (1 Нифай 1:19-ийг үзнэ үү). Би "бүх дэлхийн нүглийг үүрэх ёстой" Гэтэлгэгчийн талаарх түүнийг бошиглолуудыг уншлаа (1 Нифай 10:10; 4–10-р шүлгийг үзнэ үү). Есүс Христийн төрөлт, тохинууллал, үхэл, Амилалт болон ирээдүйд эртний Америкт хийх айлчлалынх нь талаарх Нифайн дүрслэлийг ч уншив (1 Нифай 10–12-ыг үзнэ үү).

Мормоны Ном Библи дээрх "бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүст Бурханы Хурга бол Мөнхийн Эцэгийн Хүү хийгээд дэлхийн Аврагч" хэмээх үнэнийг бататгана гэсэн бошиглолыг уншсан юм (1 Нифай 13:40). Түүнчлэн "бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүс хэрэв энэ нь түүнчлэн байж тэд наманчлах аваас Израилын Ариун Нэгэнд аюулгүйгээр орших болно" (1 Нифай 22:28) хэмээх Нифайн гэрчлэлийг уншив.

Нэг өдрийн дараа би 53-р хуудсан дээр очсон байв. Би Мормоны Ном дээрх номуудын *ганцхан* номыг нь уншиж дууссан ч хүчтэй гэрчүүдийг аль хэдийн хүлээн авсан байлаа.

Дараагийн долоо хоногт нь би хуудас бүрээс Есүс Христийн талаарх гэрчлэл, Түүний бошиглогчид дээр ирсэн үзэгдлүүд болон эртний америкчүүдийн дунд хийсэн тохинууллынх нь талаар дэлгэрэнгүй мэдээллийг олсон юм. Би Есүс Христийн талаар Моронайн хүчтэй гэрчлэлийг (Моронай 9-ийг үзнэ үү); "Бурхан, Мөнхийн Эцэгээс, *Христийн нэрээр* [Мормоны Ном] үнэн эсэхийг асуухыг" (Моронай 10:4; тодотгол нэмэгдсэн); мөн сүүлийн хуудсан дээрх "Христэд ир" (Моронай 10:30, 32) гэсэн урилгыг нь уншиж дуусгасан.

Мормоны Ном ангийн маань хүүхдийн хэлсэн үгийг няцааж байгааг би олж мэдсэн. Хэрэв Христэд итгэгч гэдэг нь Есүс Христэд итгэдэг хүнийг хэлдэг юм бол Мормоны Номын хуудас бүр дээр "Бид итгэдэг!" гэсэн байв.

Хэсэг хугацааны дараа би найзтайгаа дахин уулзсан. Би өөрийнхөө туршлагыг түүнд яриад, түүнийг Мормоны Номыг уншихад урив. Тэр эелдгээр татгалзсан ч Есүс Христийг өөрийн Аврагчаар хүлээн авсанд маань баярлаж байна гэсэн юм. Биднийг ийнхүү ярилцаны дараа "Мэдээж бид Христийн шашинтнууд мөн" гэснээрээ юу хэлэх гэснийг маань тэр илүү сайн ойлгосон гэж би бодож байна. ■

МОРМОНЫ НОМЫН ХӨРВҮҮЛЭХ ХҮЧ, БЭН СОВАРДС

“Би үргэлж өөрийгөө бусадтай, ялангуяа төгс амьдралтай мэт харагддаг хүмүүстэй харьцуулдаг. Би хэрхэн өөртөө илүү итгэлтэй болох вэ?”

“Бид өөрсдийгөө бусадтай харьцуулахад маш их цаг зав, эрч хүч зарцуулдаг… Энэ нь биднийг хүрэхийн аргагүй хэт өндөр хүлээлт рүү хөтөлдөг…

…[Бурхан] биднийг төгс байгаасай гэж хүсдэг ба хэрэв бид дагалдагчийн зам дээр үлдэх аваас нэг л өдөр төгс болно. Та нар хараахан төгс болоогүй бол санаа зовох хэрэггүй. Үргэлжлүүлэн үүн дээрээ ажилла, гэхдээ өөрийгөө шийтгэхээ зогсоо.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч, Дийтр Ф.Угдорф, “Намайг бүү март”, 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган.

Авьяас бэлгээ мэдэхийн тулд залбир

Танд Тэнгэрлэг Эцэгийн Өөрийн биеэр өгсөн олон авьяас, сүнслэг бэлэг бий. Зөвхөн та бусдын амьдралыг адисалж болох арга замууд ч бас бий. Энэ бол Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө юм. Танд ямар авьяас бэлэг өгснийг мэдэхийн тулд залбирч, нэмэлт удирдамж хэрэгтэй бол ойр дотных хүмүүсээсээ асуу. Та Сүнсийг сонсож, авьяас бэлэг, бурханлаг зан чанараа олж нээн, хөгжүүлэхийг хичээснээр урьд өмнөхөөсөө илүү ихээр өөртөө итгэдэг болно.

Ами П., нас 17, АНУ, Кентакки муж

Тэднийг илүү сайн мэдэж ав

Би өөрийгөө хэн нэгэнтэй харьцуулж байгаагаа олж мэдэх юм бол тэр хүнийхээ талаар илүү сайн мэдэхийг хичээдэг. Өөрийнхөө “шүтээн”-тэй танилцах үед дэлхий дээрх бүх хүнд бэрхшээлтэй зүйл тулгардаг юм байна гэсэн бодит байдал надад хүнд тусдаг. Би тэр хүнтэй ярилцах тусам төгс хүн гэдгээр нь биш, харин найзын хувиар харж эхэлдэг.

Амэлиа С., нас 15, АНУ, Айдахо муж



Зөвхөн Тэнгэрлэг Эцэгийн үзэл бодол чухал

2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн “Би хангалттай сайн байна уу? Би хаант улсад орж чадах уу?” хэмээх үгэндээ Далын ахлагч Ж.Дэвн Корниш “Тэнгэрлэг Эцэг маань биднийг юу гэж үзэх нь л бидэнд хамаарах цорын ганц үзэл бодол юм. Бидний талаар Түүний юу гэж бодож байгааг чин сэтгэлээсээ асууж залбирна уу. Тэрээр биднийг хайрлах бөгөөд сэтгэлээр унагах арга мэхийг ашиглалгүй, биднийг залруулах болно” хэмээн хэлсэн. Хэзээ ч эргэн тойрны хүмүүстэйгээ адил сайн болж чадахгүй гэсэн бодол орж ирэх үед би Тэнгэрлэг Эцэгтээ ханддаг ба Түүнийг эрэлхийлэх юм бол чадавхаа бүрэн хөгжүүлэн, Түүний мэдэж байгаа тийм хүн болоход минь туслахад бэлэн байдаг, намайг хайрладаг Бурханы охин гэдгээ санахыг хичээдэг.

Аманда М., нас 19, Бразил, Парана

Өөртөө итгэлтэй болохын төлөө залбир

Өөрөөсөө илүү гэж боддог, ялангуяа санхүүгийн хувьд хөл дээрээ тогтвортой зогссон хүмүүстэй би өөрийгөө харьцуулдаг байсан. Тэнгэрлэг Эцэгт хандан залбирах бүрд Тэрээр надад өөртөө итгэх итгэлийг өгдөг байсан юм. Ямар ч асуудал байсан Бурхан өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг зэхэлгүйгээр бидэнд үүрэг даалгавар өгөхгүй тул Тэрээр надад тусална гэдгийг би мэддэг байсан (1 Нифай 3:7; 17:3-ыг үзнэ үү).

Жошуа О., нас 19, АНУ, Айдахо муж

Хариултууд нь тусламж, ойлголт өгөх зорилготой бөгөөд Сүмийн сургаалын тухай албан ёсны мэдэгдэл биш юм.

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Ялган таних бэлэг гэж юу вэ?

Судруудад “сүнснүүдийг ялган таних” чадварыг Сүнсний бэлэг хэмээн дурдсан байдаг (1 Коринт 12:10; С ба Г 46:23). Энэ нь “аливаа зүйлийг Сүнсний хүчээр ойлгож, мэдэхийг хэлнэ. . . . Хүмүүсийн үнэн зан чанар болон сүнсний тунхаглалуудын утга учир, эх сурвалжийг мэдэх нь үүнд хамаардаг” (Судруудын удирдамж, “Ялган таних бэлэг,” scriptures.lds.org).

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар ялган таних бэлэг нь бидэнд (1) “бусдын нуун далдалсан алдаа, хилэнцийг олж харах,” (2) “өөрсдийн нуун далдалсан алдаа, хилэнцийг олж харах,” (3) “бусдын далд сайн зан чанарыг олж, гаргаж ирэх,” мөн (4) “өөрсдийн далд сайн зан чанарыг олж, гаргаж ирэхэд” тусалдаг болохыг заасан (“Quick to Observe,” *Liahona,* Dec. 2006, 19).

Та нар юу гэж бодож байна?

“Бид ялангуяа сүм дээр болон семинарт сууж байхдаа цахим хэрэгсэлд анхаарлаа хандуулахгүйн тулд юу хийж болох вэ?

Хэрэв хүсвэл хариултаа өндөр нягтралтай зургийн хамт liahona.lds.org хаягаар (“Submit an Article or Feedback” дээр дар) 2018 оны 7-р сарын 15-ны дотор илгээнэ үү.

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлах магадлалтай.

АВЬЯАС БЭЛГЭЭ

Жастина Лихнэр

Хүн бүр л "Чи өөрийгөө ямар сайн хүн гэдгээ мэддэг ч болоосой" гэж үргэлж хэлдэг юм шиг санагддаг. Үнэндээ та заримдаа өөрийгөө ямар сайн хүн гэдгээ мэддэггүй байж болох юм. Бид хамгийн ухаантай, сайхан, царайлаг, хөгжилтэй, авьяастай гэдгээ мэдрэхгүй л байх юм бол бидний өөртөө итгэх итгэл алга болчихдог мэт санагддаг.

Гэхдээ бид бүгд Тэнгэрлэг Эцэгийн охид, хөвгүүд гэдгээ бод. Тиймээс Тэр бидэнд өөрсдийн бурханлаг хүчин чадавхад хүрэхэд туслах өвөрмөц авьяас бэлгийг өгсөн байдаг. Бид эдгээр авьяас бэлгээ олж нээхийн хэрээр Бурханы хүүхдүүдийн хувьд тэнгэрлэг үнэ цэнтэй гэдгээ санан, Түүнд илүү ойртож мөн бусдад тийн үйлдэхэд нь туслах боломжтой байдаг.

АВЬЯАС БЭЛГЭЭ ОЛЖ МЭД

Энд өөрийнхөө зарим "тийм ч ил биш" авьяас бэлгээ нээж олоход туслах 9 санааг жагсаав. Үүнд:

1. **Өөрт тань хэлж өгөхийг бусдаас хүс.** Заримдаа бид бусдын биднээс олж харж байгаа зүйлийг өөрсдөөсөө олж хардаггүй. Найз нөхөд, хамаатан садан эсвэл Сүмийн удирдагчаасаа өөрөөс тань олж харсан бэлэг, авьяасын талаар бичиж өгөхийг хүс.

2. **Зовлон бэрхшээлээс бэлгээ олж хар.** Хүнд хэцүү үед бид өөрсдийн хамгийн сайн чанарыг гаргах уу эсвэл муу зан чанарыг гаргах уу гэдгээ сонгож болно. Хэцүү үед хамгийн сайн зан чанар, бэлгээ олж нээн, ашиглахад анхаарлаа төвлөрүүл.

3. **Авьяас бэлгээ таньж мэдэхээр тусламж хүсэн залбир.** Тэнгэрлэг Эцэг бидний тэнгэрлэг хүчин чадлыг мэддэг. Хэрэв бид энэ бүхнийг өөрсдөө олж харж чадахгүй байвал Тэр тусалж чадна. Та авьяас бэлгээ таньж мэдэхийн тулд тусламж хүсэн залбир.

4. **Шинэ зүйл хийж үзэхээс бүү ай.** Бид өмнө нь хийж байгаагүй учраас ямар нэгэн зүйлийг хийхээс айснаасаа болж зөвхөн өөрсдийн мэдэх авьяас бэлгийг л хөгжүүлдэг бус уу? Яг одоо ямар нэгэн шинэ зүйлийг хийж үзэн, мэдэхгүй авьяас бэлгээ олж нээ.

5. **Бурханы үгийг эрэлхийл.** Судруудаас олж болох сэжүүрээр буюу ихэвчлэн үйлдэх урилгаар дамжуулан Тэнгэрлэг Эцэг бидэнд авьяас бэлгээ олж нээн, хөгжүүлэхэд тусалдаг. "Бие биентэйгээ сэргэлдэхээ эцэслэ; бие биенийхээ тухай хилэнцэтийг ярихаа эцэслэ" (С ба Г 136:23) гэсэн судрын энэ жишээг авч үзнэ үү. Та энэ урилгаас ямар авьяас бэлгээ хөгжүүлж болох вэ? Эелдэг сайхан үг хэлэх, бусдыг тайтгаруулах, номхотгох гэх мэт олон бэлэг бий. Харин энэ бүхэн ганцхан мөр шүлгээс гарч ирж байна гээд бод доо! Судраас уншиж, Сүнсний өдөөлтийг сонсох нь танд авьяас бэлгээ олж нээхэд тусална.

6. **Өөрийнхөө хүрээнээс гадуур хар.** Заримдаа бид анхаарлаа өөр дээрээ биш, харин бусадтай хамт ажиллаж, тэдэнд туслахад төвлөрүүлэх юм бол бидний хамгийн сайн зан чанарууд илрэн гарч ирдэг. Бид ийнхүү хийснээр Христийнхтэй адил олон авьяас бэлэгтэй гэдгээ харах болно.

7. **Хүндэлж явдаг хүмүүсийнхээ талаар бод.** Хэн танд үлгэр жишээ болдог вэ? Та үлгэр жишээ болдог хүнийхээ бүх авьяас бэлгийн жагсаалтыг гарган, ямар ямар бэлэг нь өөр байна гэдэг дээр биш, харин адилхан бэлэг байгааг олж илрүүлэхдээ баярлаж болно.

8. **Гэр бүлийнхнийхээ талаар тунгаан бод.** Танд байдаг ямар ямар

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЛЭЙТОН ТОМПСОН

ОЛЖ МЭД

авьяас бэлэг ах, эгч, дүү, эцэг, эх, өвөө, эмээд тань бас байдаг вэ? Гүнзгийрүүлэн судал! Гэр бүлийн түүхээ судлан, түүхийг олж мэдэж, гэр бүлийнхэнд тань байдаг өөр олон адилхан авьяас бэлгийг олж тогтоо.

9. Патриархын адислалаа авч, унш. Таны адислал дээр өөрт тань байгаа мөн хөгжүүлэх ёстой авьяас бэлгийн талаар дурдсан байж болох бөгөөд энэ нь өөр бэлэг, авьяасуудаа олж нээхэд туслах арга замыг зааж өгч болох юм.

ТҮҮГЭЭР ТӨГӨЛДӨРЖИГТҮН

Бид Бурханы эрдэнэт хүүхдүүд гэдгээ мэдэхийн тулд бүх зүйлд төгс байх шаардлагагүй. Бид зөвхөн бэлэг, авьяас чадвараа олж нээн, хөгжүүлэхэд өөрсдийгөө зориулах хэрэгтэй. Тэгээд Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бид Түүгээр төгөлдөржиж чадна (Моронай 10:32-ыг үзнэ үү). ■

Зохиогч нь Германы Райнланд-Палатинатад амьдардаг.

ОЛЖ НЭЭХ ХҮСЭЛ

"Тэнгэрлэг Эцэгт бидэнд өгөхийг хүсдэг маш олон авьяас, бэлэг байгааг би мэднэ. Гэвч тэдгээр нь гуйсан үед л бидэнд өгөгдөх болно. Адислалууд нь өөрт оногдсоноо хийж, хөдөлмөрлөж, хичээл зүтгэл гаргасан үед л ирдэг' (Судруудын удирдамж, 'Залбирал')."

Далын ахлагч Мэрвин Б.Арнолд, "Би хаана байна вэ? How to Discover and Develop Your Spiritual Gifts and Talents," ***Лиахона,*** **2014 оны 12-р сар.**

БУСДАД АВЬЯАС БЭЛГЭЭ ОЛЖ НЭЭХЭД ТУСАЛ

Бусдын өөрсдөөсөө олж харж чадахгүй байж болох зүйлсийг бид хардаг. Энэ долоо хоногт эдгээр зүйлийг найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ хуваалцаарай. Бусдын авьяас бэлгийг олж нээхэд тань туслах зарим асуултыг энд оруулав.

1. Тэд танд туслахын тулд юу хийсэн бэ?
2. Танд тэдний юу нь таалагддаг вэ?
3. Тэд юунд сайн бэ?
4. Тэд юугаа сайжруулах гэж хичээж байгаа вэ?

СҮНСЛЭГ

ГЭРЭЛ

БУРХАНЫ БҮХ БҮТЭЭЛ ДЭЭР ТУССААР БАЙДАГ.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч
Дийтр Ф.Угдорф,
“Тэнгэрлэг гэрэл түгээгчид”,
2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган.

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Гэрэл үргэлж байдаг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч
Дийтр Ф.Угдорф

Нисэх онгоцны ахмад байхдаа дэлхийг тойрон олон удаа нисэж байхдаа харсан Бурханы бүтээлийн гоо үзэсгэлэн, төгс төгөлдөр байдал үргэлж намайг гайхшируулдаг байсан. Ялангуяа дэлхий, нар хоёрын харилцан хамаарал миний сэтгэлийг өөрийн эрхгүй татдаг байв. Энэ бол харанхуй, гэрэл хоёр хэрхэн оршдогийн бодит жишээ гэж би боддог.

Бид бүхний мэддэгчлэн 24 цагийн дотор өдөр, шөнө солигдож байдаг.

Тэгвэл шөнө гэж чухам юу вэ?

Шөнө бол сүүдэр төдий зүйл юм.

Хамгийн харанхуй шөнө ч нар гэрлээ цацруулсаар, хурцаар гэрэлтсэн хэвээр байдаг. Харин тэр үед дэлхийн тал нь харанхуйд байдаг.

Гэрэл байхгүй үед харанхуй бий болдог.

Шөнийн харанхуй ирэх үед бид нар дахин мандахгүй нь гэж санаа зовон цөхөрдөггүй. Нар үгүй боллоо эсвэл мөхчихлөө гэж бид ярьдаггүй. Бид сүүдэр талд нь байгаа ба дэлхий эргэлдсээр нарны туяа бидэн дээр дахин тусна гэдгийг мэддэг.

Харанхуй бол гэрэл байдаггүй гэсэн шинж тэмдэг биш. Ихэнхдээ энэ нь бид зүгээр л гэрлийг хүлээн авах зөв газартаа байхгүй байна гэсэн үг.

Сүнслэг гэрэл Бурханы бүх бүтээл дээр туссаар байдаг.

Есүс Христийн сайн мэдээний тэнгэрлэг гэрэл, үнэнийг харахын тулд зөв газартаа байх эсэх нь биднээс шалтгаална. Шөнө болж, дэлхий харанхуй мэт санагдавч бид Христийн гэрэлд алхаж, зарлигуудыг сахин, Түүний бодит байдал хийгээд сайн сайхныг зоригтой гэрчлэх сонголтыг хийж чадна.

Та нар даруухнаар залбирч, зүрх сэтгэлээ Бурханд хандуулах бүрдээ Түүний гэрлийг мэдэрдэг. Та нарыг судруудаас Түүний үг болон хүслийг эрэлхийлэх бүрд уг гэрэл улам хурц болдог. Та нарыг тусламж хэрэгтэй хэн нэгнийг анзаарч, хайраар хүрч туслахаар тав тухаа золиослох бүрд уг гэрэл өсөн нэмэгдэж байдаг. Та нарыг уруу таталтыг эсэргүүцэж, цэвэр ариун байдлыг сонгох бүрд, өршөөл эрэлхийлж мөн үзүүлэх болгонд, түүнчлэн үнэнийг зоригтойгоор гэрчлэх бүрд уг гэрэл харанхуйг үлдэн хөөж, гэрэл, үнэнийг эрэлхийлэгчдийг татаж байдаг. ■

Ахлагч Угдорфын Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх байх үеийн 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулганаас

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

1940 оны 11-р сарын 6-нд
Чехословакийн Острава
хотод төрсөн.

Тэр 1947 онд Германы Звикад Сүмд элссэн.

Түүнийг 2004 оны 10-р сарын 2-нд
Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын *гишүүнээр дэмжин баталсан.*

Бага байхдаа тэр гэр бүлийнхэнтэйгээ **цагаачилж,** *Чехословакаас Герман руу, дараа нь Зүүн Германаас Баруун Герман руу дүрвэжээ.*

1962 онд Харриет Рейхтэй
Швейцарийн Берн ариун сүмд
гэрлэжээ.



Тэр **Германы Луфтханза нислэгийн компанид нисгэгчээр** *ажиллаж байжээ. 29 насандаа тэр ахмад цолтой болсон байна.*

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ GETTY IMAGES БОЛОН АНДРЬЮ В.РОБЭРТС

Хайраа харуулах нь

САЙН БАЙНА УУ!

Намайг Хайр гэдэг.

Би гэр бүлийнхэндээ хайртай гэдгээ харуулснаар гэрлээ гэрэлтүүлдэг.

1 Миний тухай

Би Нигерид амьдардаг. Энэ бол Африкт оршдог улс. Би аав, ээж, эрэгтэй дүү нартайгаа амьдардаг. Миний дуртай дуу бол "Бүх дэлхийн хүүхдүүд" юм. Харин дуртай судар бол 1 Нифай 3:7.

2 Ариун сүмд ойрхон

Бид Нигерийн Аба ариун сүмтэй маш ойрхон амьдардаг. Тийшээ 5-хан минут алхаад л очихдог. Би ариун сүмд очихдоо маш их баярладаг. Би ариун сүм дотор орж, баптисм үйлддэг болох тэр цаг мөчид бэлдэж байгаа.

Байх хамгийн сайхан газар

Даваа гарагт би дүү нартаа гэр бүлийн үдшийн талаар сануулдаг. Аав маань оройн хоол хийж, бид бүгдээрээ хамтдаа бүжиглэхэд би дуртай. Гэр орон бол бидний байх ёстой хамгийн сайхан газар.

Дүү нартаа туслах

Өглөө бүр би эрэгтэй дүү нараа өглөөний гэр бүлийн онцгой цугларалтад оролцуулахаар сэрээдэг. Бид хамтдаа дуулж, судруудаас судалж, өвдөг сөгдөн залбирдаг. Дараа нь би тэдэнд сургуульдаа явахад бэлдэхэд нь тусалдаг. Дүү нараа хайрлаж, тэдэнд туслах нь Тэнгэрлэг Эцэгийн өмнө хүлээсэн миний үүрэг гэж би боддог.

Ажиллах ба тоглох

Хичээлийнхээ дараа би ээждээ гэр орны ажилд нь тусалдаг. Би бас дүү нартаа гэрийн даалгавраа хийхэд нь тусалдаг. Надад тоглох цаг бараг гардаггүй ч би дугуйгаа унаж, цаасан шувуу хийх дуртай. Би гэр бүлийнхэндээ хайртай гэдгээ харуулснаар Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдэрдэг.

ЧИ ХЭРХЭН ГЭРЭЛТЭЖ БОЛОХ ВЭ?

- Дүү нартаа үлгэр уншиж өг.
- Ээж, аавaасаа хэрхэн тусалж болохыг асуу.
- Гэрийнхэндээ гэр бүлийн залбирал хийхийг сануул.



БИДЭНД ОД ИЛГЭЭНЭ ҮҮ!

"Гэр[лээ] тэдний өмнө тийнхүү гэрэлт[үүл]" (Матай 5:16) хэмээн Есүс биднээс хүссэн. Чи гэрлээ хэрхэн гэрэлтүүлж чадах вэ? Та бидэнд одныхоо зургийг өөрийн түүх, зураг, эцэг эхийн зөвшөөрлийн хамт liahona@ldschurch.org хаягаар э-мэйлээр илгээгээрэй.

*“Би сайн, элдэг байж, мөн тааралдсан хүндээ туслахдаа их аз жаргалтай байдаг. Учир нь би өөрөө өөртөө тусалж байгаа гэсэн үг” (*Children’s Songbook, *197).*

Антон компьютерийн дэлгэцэн дээр хэдэн сая удаа уншигдаж байгаа мэт санагдах зургаадугаар түвшинг уншиж байгааг харж сууна. Тэр гүнзгий амьсгаа аваад, төөрдөг байшин дундуур өнгөлөг гадаснууд дээгүүр нисэж, галт хонгил дундуур хурдалж эхэллээ. Тэр барианы шугаманд ойртох тусам хөлөөрөө хурдан хурдан дэвсэлж байв.

“Антон?” гэх ээжийнх нь дуу сонсогдов. Түүнд тусламж хэрэгтэй бололтой.

Тэр дотроо “Одоо л биш шүү” гэж бодов. Тэр дахиад нэг гадсан дээгүүр үсрээд өөр нэгэн хонгилоор яаран орлоо. Тэр нүдээ дэлгэцнээс салгалгүй “Яасан бэ?” гэв.

“Чи Фэликсийн унтлагын хувцсыг өмсгүүлээд, түүнд ном уншаад өгөөч? Би гал тогоогоо цэвэрлэж дуусгах хэрэгтэй байна” гэж тэр хэллээ.

“Яа аая . . . ,” Тэр *тун* ойрхон байлаа! Хамгийн сүүлчийн гадастай хонгилоор эргэн, дахин нэг галын дээгүүр гарч, хэмлэгч мангасын хажуугаар өнгөрөөд . . . ТИЙМ ЭЭ! Барианы шугамд ирэх нь тэр!

Компьютер долоодугаар түвшинг гаргахаар уншиж байлаа. Арай хэцүү юм шиг харагдаж байсан ч Антон тоглож үзэхийг тэсэн ядан хүлээж байв. Тэр энэ түвшинд хүрэхийн тулд шаргуу хөдөлмөрлөсөн. Антон түр зогсох товчлуур дээр дараад, Фэликс дүү нь тэврэн зогсож буй ээж рүүгээ өнгийн харлаа. “Би дахиад хэдэн минут тоглочихъё, тэгэх үү? Би дөнгөж сая л долоодугаар түвшинд ирчихээд байна шүү дээ” хэмээн гуйхад нь

“Надад чиний тусламж үнэхээр хэрэгтэй байна. Чи Фэликсийг унтуулсныхаа дараа дахиад нэг түвшин тоглож болно” гэж ээж нь хэллээ.

Фэликс инээмсэглэв. Тэр “Гуйж байна” хэмээн хоёр настай хүүхдийн өхөөрдөм хоолойгоор хэллээ.

Фэликсийг оронд нь оруулах цаг

Бодит түүхээс сэдэвлэв
Хэйди Поэлмэн

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ СКОТТ САГУИБО

Антон компьютерын дэлгэц рүү харан, санаа алдсаар “За за” гэв. Тэр тоглоомоо үргэлжлүүлэн тоглохын тулд хурдлах хэрэгтэй.

Тэр Фэликсийг өргөөд, шатаар өгсөн, өрөө рүү нь орлоо.

“Миний хамгийн хайртай бяцхан дүү минь хэн билээ?” гээд тэр Фэликсийн бяцхан зөөлөн гэдсийг хуруугаараа хаттав. Тэр Фэликсийн гэдсэн дээр үлээгээд, түүнийг чанга хөхрөхөд нь инээмсэглэлээ.

Антон Фэликсийн дуртай динозавртай унтлагын хувцсыг нь өмсгүүлэв. Дараа нь тэр Фэликсийг оронд нь оруулаад хаалга руу дөхлөө. Ээж нь түүнд Фэликст үлгэр уншиж өг гэсэн ч тэр гол зүйлээ хийсэн байв. Тэр одоо унтах цаг болохоос өмнө дахин *хоёр* түвшин тоглоод амжчихаж магадгүй.

Яг тэр мөчид Антон цамцнаас нь угзрахыг мэдрэв. Тэр доош хартал Феликс орноосоо боссон байлаа.

“Баавгай?” хэмээн Фэликс гуйлаа. Тэр торон савтай ном руу очиж, нүүрэн талдаа цагаан баавгайн зурагтай ном барьсаар ирэв.

“Өө, Фэликс ээ, надад хийх ажил байна!” хэмээн Антон хэлэв. Фэликс номоо толгой дээрээ тавиад Антон руу том бор нүдээрээ харлаа.

Антон өөрийн эрхгүй инээв. “Чи үгүй гэсэн хариултыг хүлээж авахгүй, тийм үү? За, за” гэлээ.

Антоныг Фэликсийн орон дээр суухад тэр өвөр дээр нь гарлаа. Антон эхний хуудсыг нээгээд Феликсийг өөрт нь наалдан хэвтэх зуур уншив. Фэликс хуудсан дээрх бүх амьтанг нэг бүрчлэн зааж, нэрлэнэ. “Айаг тахь, . . . ягаан наль . . . далайн мой.”

Антон уншиж дуусаад, номыг нь хааж, Фэликсийг хөнжлөөр нь сайтар хучив. “Сайхан нойрсоорой, Фэликс” гэж тэр хэлээд, дүүгийнхээ духан дээр үнсээд явахаар бослоо.

Харин хаалга руу дөхөж очтол дахин түүний турьхан дуу сонсдов. “Тэврэлдэж хэвтэх үү?” гэхэд нь

Антон инээмсэглэсээр, “За. Цаашаа хэвтээрэй. Би хэсэг зуур хэвтье” гэлээ.

Антон дэрэн дээр толгойгоо тавив. Ямар ч байсан яг тэр мөчид түүнд өөр зүйл хийх хүсэл байсангүй. Фэликс том гэгч нь эвшээгээд, нүдээ анихад тэр инээмсэглэв. Яг тэр мөч түүний хувьд тэр өдрийн хамгийн аз жаргалтай цаг мөч байв. Харин тоглоом бол хүлээгээд байж л байх болно. ■

Зохиогч нь АНУ-ын Юта мужид амьдардаг.

Тортияа ба амигас (найз нөхөд)

Бодит түүхээс сэдэвлэв

Линдзий Стивэнс ба Марисса Дэннис

*“Найзтай болохыг хүсвэл анхаарал халамж тавих хэрэгтэй” (*Children’s Songbook, *262).*

Адриана уйдаж байлаа. Тэр өөрийн ихрийн өрөөсөн болох дүү Даианатайгаа тоглохыг хүсэж байв. Харин Даиана хоол хүнс авахаар ээжтэйгээ зах руу явсан байлаа. Адриана санаа алдав. Гэр хоосон хөндий санагдана. Тэдэнтэй хамт явдаг байж гэж тэр бодов.

Адриана хөрш Маргарита руугаа очихоор шийдлээ. Маргаритагийн хүүхдүүд бүгд өсөж том болсон бөгөөд тэр Адрианагийн эмээ шиг хүн байв. Тэд хамтдаа цагийг үргэлж тун хөгжилтэй өнгөрүүлдэг байлаа.

Адриана гадаа гарав. Маргаритагийн гэр рүү алхах зуур халуун нар түүний дээрээс төөнөнө. Тэр толгойгоо хаалганы завсраар цухуйлгаад, “Маргарита, та гэртээ байна уу?

“*Sí,* би гал тогоонд байна” гэж Маргарита хэллээ. Адриана түүнийг гал тогооны ширээний ард толгойгоо гудайлган сууж байгааг харав. Тэр Адрианаг орж ирэхэд толгойгоо өндийлгөн харав.

“Сайн уу, Адриана” гэж Маргарита хэлээд бага зэрэг инээмсэглэв. Гэхдээ яагаад ч юм гунигтай харагдлаа.

“Ямар нэг зүйл болсон уу?” хэмээн Адриана асуув.

Маргарита санаа алдан, “Чи санаа зовох хэрэггүй дээ” гэлээ.

“Би түүний сэтгэлийг засахын тулд юу хийж болох вэ?” гэж Адриана бодов. Хамтдаа хоол хийхэд Маргарита үргэлж баяр хөөртэй байгаа мэт байдаг байсан.

“Би танд тортияа хийхэд тусалж болох уу?” гэлээ.

“Би саяхан хэдийг хийж дууссан” гэж Маргарита хэлээд, даавуун алчуурыг сөхөн давхарлан өрсөн тортияа харуулав.

“Тэгвэл би танд тортияаг чинь *идэхэд* тусалж болох уу?” хэмээн Адриана инээмсэглэсээр асуулаа.

Маргарита чанга инээгээд, “Мэдээж хэрэг. Би хамт идэх шош халаагаадахъя” гэв.

Адриана Маргаритагийн хажууд зогсоод, саван доторх шарсан хар шошийг хутгав. Шош бэлэн болсны дараа тэр ширээн дээр авчирч тавилаа. Харин Маргарита тортилла болон бяслаг авчрав.

Адриана халуун тортилла аваад, дээр нь шошийг тараалаа. Тэгээд дээрээс нь бяслаг цацав. Арааны шүлс асгарам амттай харагдаж байлаа. Адриана хурдан идэхийг хүсэв. Гэхдээ түүнд эхлээд хийхийг хүссэн зүйл байлаа.

“Би залбирч болох уу?” хэмээн Адриана Маргаритагаас асуув.

Тэр “Тэг тэг” гэлээ.

Адриана нүдээ аниад, алгаа хавсран нийлүүлэв. “Тэнгэрлэг Эцэг минь, бидэнд энэ хоолыг өгсөн Танд баярлалаа. Биднийг эрүүл саруул, хүчтэй болгож болохын тулд энэ хоолыг адисална уу. Мөн Маргаритад хэрэгтэй зүйлсээр нь туслаарай. Тэр миний найз байгаад би баярладаг. Есүс Христийн нэрээр, амен.”

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖЭННИФЭР БРИКИНГ

Адриана нүдээ нээв. Маргарита инээмсэглэсэн байв. Харин энэ удаад чин сэтгэлийн инээмсэглэл байлаа. Тэд идэх зуураа сургууль, спорт, номын талаар ярилцав. Адриана Маргаритатай ярьж хөөрөх дуртай байлаа.

Идэж дууссаныхаа дараа Адриана Маргаритаг чанга тэврэв. “Зуушаар дайлсанд баярлалаа. Цагийг сайхан өнгөрүүллээ!” гэв.

Маргарита Адрианаг эргүүлэн тэврээд, “Адриана *чамд* ч гэсэн баярлалаа. Өнөөдөр надад найз хэрэгтэй байсан” гэв.

Адриана инээгээд, “Бид *амигас* байгаад би баярлаж байна” гэсэнд

“Бид найзууд байгаад би ч бас баяртай байна. Үлдсэн тортияаг чи гэр рүүгээ авч явах уу? Би үнэхээр цадчихлаа” хэмээн Маргарита хэлэв.

Адриана гэртээ харих замдаа дэгдэн гүйлээ. Тэр ч бас цадсан байлаа, гэхдээ зөвхөн тортияагаар биш. Тэрээр толгойноосоо хөл хүртлээ нөхөрлөлөөр цадсан байв. ■

Зохиогчид нь АНУ-ын Юта мужид амьдардаг.

НӨХӨРЛӨЛИЙН ТОРТИЯА

Хийхэд амархан эрдэнэ шишийн эдгээр тортияа найзтай болоход мөн тэдэнтэйгээ хуваалцахад яг тохирсон хоол юм гээч! Томчуудаас тусламж авна уу.

2 аяга маса фарина (эрдэнэ шишийн гурил)
1 1/2 аяга халуун ус

1. Маса фаринаг халуун устай хольж, гурилыг зөөлөн болтол нух.
2. Нухсан гурилыг жижигхэн бөөрөнхий хэлбэрт оруул. Нэг бөөрөнхийлсөн гурилыг наалддаггүй хоёр цаасны дунд хавчуул.
3. Таваг эсвэл хайруулын тавгаар бөөрөнхийлсөн гурилыг дээрээс хэд хэдэн удаа дар.
4. Тортияаг хайруулын тавганд хийгээд дунд зэргийн гал дээр шар. Дээд тал нь шаргалтахад эргүүлэн нөгөө талыг нь шар.
5. Дээр нь шош, бяслаг тавиад амтархан идээрэй!

1

2

3


4

5

Гайхамшиг

Үг, аяыг Шона Бэлт Эдвардс



© 2018 Шона Бэлт Эдвардс. Бүх эрх хамгаалагдсан.
Энэхүү дууг арилжааны бус зорилгоор сүмд болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан олшруулж болно.
Энэ мэдэгдлийг олшруулсан хуудас бүрд оруулна уу.



Та children.lds.org дээрээс энэ дууны дагаж дуулах видео бичлэгийг үзнэ үү. Эхлээд “Music” дараа нь “Sing-Along Videos” дээр дарна уу.

“Есүс Христ бол бидний Сайн Хоньчин бөгөөд биднийг хайрлаж, бидэнд санаа тавьдаг гэдгийг би гэрчилж байна. Тэр биднийг мэддэг мөн Өөрийн хоньдын төлөө амьдралаа өгсөн. Тэр бидний төлөө амьдардаг бөгөөд биднээс Өөрийг нь мэдээсэй мөн Өөрт нь итгэх итгэлээ хөгжүүлээсэй хэмээн хүсдэг. Би Түүнд хайртай мөн Түүнд их талархдаг.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Дэйл Г.Рэнланд

“Бидний сайн хоньчин,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, *15*.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КРИСТИН КВАН

Тэнгэрлэг Эцэг та нарыг мэднэ

Хүүхдийн хэсгийн
ерөнхий ерөнхийлөгчийн
зөвлөлийн
хоёрдугаар зөвлөх
Кристина Б.Франко эгч

Аргентины нэгэн жижигхэн хотхонд ням гараг бүр хэсэг бүлэг хүн модны доор цугларч, судраас уншиж, сайн мэдээний талаар суралцдаг байв. Тэдний зарим нь Сүмийн гишүүд байжээ. Гэхдээ ихэнх нь баптисм хүртээгүй ч хүртэхийг үнэхээр хүсэж байлаа.

Гэвч тэдэнд нэг асуудал байв. Тэд бусад хотоос алс хол амьдардаг байжээ. Сүмийн ямар ч удирдагчид хотхонд ирээгүй удсан байв.

Дараа нь тэд 4 цагийн зайтай оршдог хотхонд номлогчид байгаа гэсэн сураг сонсжээ. Тэд бүгдээрээ мөнгө нийлүүлэн, номлогчдын байдаг хотхон руу явдаг автобусны тасалбарыг нэгэндээ авч өгсөн байна. Тэр очсоныхоо дараа автобусны буудал дээр хүлээв. Энэ нь номлогчдыг олох хамгийн тохиромжтой газар гэж тэр бодсон байлаа.

Хэдэн цагийн дараа тэрээр хоёр залууг олж харав. Тэд номлогчид байлаа! Тэр хотхоныхоо хүмүүсийн талаар тэдэнд ярив. Тиймээс номлогчид болон номлолын ерөнхийлөгч тэр хүмүүстэй очиж уулзахаар болжээ.

Номлолын ерөнхийлөгч болон номлогчдыг хүрэлцэн ирсэн тэр өдөр тэдэнтэй уулзахаар олон хүн ирэв. Харин баптисм хүртээгүй байсан хүмүүс одоо баптисм хүртэх боломжтой болов. Хичээл заалгасныхаа дараа тэд бэлэн болсон байлаа.

Хамгийн ойрхон орших гол хол байсан тул тэд худгаас ус авч, зөөврийн усан санг дүүргэв. Усан санг дүүргэхэд бүхэл бүтэн 3 цаг зарцуулжээ. Нийт 27 эмэгтэй, эрэгтэй болон хүүхэд тэр өдөр баптисм хүртжээ. Тэд баяр хөөрөөр дүүрэн байв.

Баптисм хүртэхийг хүсэж байгааг нь Тэнгэр Эцэг мэдэж байсан бөгөөд тэдэнд номлогчдыг олоход тусалсан билээ. Тэнгэрлэг Эцэг таныг ч гэсэн мэднэ. Тэрээр таныг хаанаас ирсэн, хэн болох мөн танд юу хэрэгтэй гэдгийг мэднэ. Тэр таны залбирлыг сонсож, хариулдаг. Ганцаардсан ч гэлээ Тэрээр үргэлж тантай хамт байна. Та хэзээ ч ганцаар биш. Та хэзээ ч Түүнд хандаж болно. ■

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРЭД ТИАРЭ

Мосе Бурханыг дагадаг

Ким Вэбб Рэйд

Нэг өдөр Египетийн гүнж еврей нярай хүүг сагснаас олжээ. Гүнж хүүг Мосе хэмээн нэрлэж, ханхүү болгон өсгөжээ.

Мосе өсөх насандаа египетчүүд өөрсдийн боол еврейчүүдэд хэрхэн ханддаг байсанд дургүй байв. Харин Мосег тэдний талд ороход Египетийн хаан түүнийг алахыг хүсжээ. Мосе зугтах хэрэгтэй болсон. Дараа нь Бурхан түүнд эргэн очиж, еврейчүүдийг чөлөөл хэмээв.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЭЙПРИЛ СТОТТ

Мосе Фараоноос еврейчүүдийг суллаж явуулахыг хүслээ. Харин Фараон татгалзав. Фараоны бодлыг өөрчилж магадгүй хэмээн Моседгазар нутгийг нь харaахад Бурхан тусалжээ. Ялаа, бөөс, дараа нь мэлхийнүүд газар нутгийг нь бүрхэв. Эцэст нь Фараон боолуудад явж болно гэжээ.

Тэднийг явж байхад Фараон бодлоо өөрчилж, цэргүүдээ хойноос нь илгээв. Мосегийн хүмүүс Улаан тэнгист ирэхэд Бурхан тэнгисийн дундуур хуурай зам гаргаж, тэд зугтсан байна.

Бурхан Мосед арван зарлигийг өгөв. Мосе амлагдсан нутаг руу явах замдаа тэдгээрийг хүмүүст заажээ. Эцэст нь тэд аюулгүй, эрх чөлөөтэй болов.



Би ч гэсэн Мосетой адилхан болж, зарлигуудыг дагаж чадна. Тусламж хэрэгтэй хүмүүст туслахад Бурхан надад тусална. ■

Эхлэл 2–34-р бүлгээс авав.

Би амар тайванг тогтоогч байж чадна

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

Арван хоёр
Төлөөлөгчийн Чуулгын
ерөнхийлөгчийн үүрэг
гүйцэтгэгч

**Ерөнхийлөгч
М.Рассэлл Баллард**

ХҮНДЭТГЭЛИЙН ӨДРИЙН АРИУН ӨРГӨӨ

Хэрэв бид цуглааны байраа ариун ёслолын цуглаанд зориулсан итгэл, үнэнч байдлын ариун өргөө гэдгээр нь харж эхлэх юм бол бүгд адислагдана.

Ариун ёслолын цуглаан нь гайхалтай, эрхэм сайхан цаг юм. Бид цуглааны байранд хөл тавин, ариун ёслолоос хүртэхээр бэлдэхдээ өөрсдийгөө Христийн тухай болон Түүний агуу хийгээд гайхамшигт үйл хэргийн талаар тунгаан бодох боломжийг олгодог ариун өргөөнд, эрхэм нандин, онцгой газарт байна гэж бодох ёстой. Бид энэ дэлхийн зүйлсийг хойш тавьж, оронд нь мөнхийн зүйлсийн талаар бодох ёстой. Бид мөн гар утаснуудаа хойш тавьж, Есүс Христ, Амьд Бурханы Хүүгийн талаар бодох ёстой.

Бидэнд Аврагчийг хайрлах хайр дээрээ анхаарлаа төвлөрүүлэхэд долоо хоног бүр ердөө 70-хан минут байдаг. Хэрэв бид цуглааны байраа ариун ёслолын цуглаанд зориулсан итгэл, үнэнч байдлын ариун өргөө гэдгээр нь харж эхлэх юм бол бүгд адислагдана.

Бид Бурханы хаант улсыг барьж байгуулах явцдаа үг хэлж байгаа хүмүүс нь Христийн талаар ярьдаг, гэрчилдэг мөн судар болон бусад эх сурвалж дээрх төлөөлөгч, бошиглогчдын гэрчлэлийг хуваалцдаг, төлөвлөлт бэлтгэл сайтай ариун ёслолын цуглааныг хөтлөн явуулахаас өөр чухал зүйл миний толгойд орж ирэхгүй байна.

Сүмийн хувьд бид Хүндэтгэлийн өдөр дээр анхаарч ажиллаж байгаа. Ахиц гарсан ч хараахан төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна. Сүмийн гишүүн, номлогч бүр Хүндэтгэлийн өдрийн шүтэн биширэх цагаар сүнслэг өдөөлтийг мэдрэн, бүгд хөрш, сонирхогч, хамаатан садандаа “Ирээд, үз. Ирж, бидэнтэй хамт шүтэн бишир” гэж хэлэх хүртэл энэ ажлаа үргэлжлүүлэн хийнэ. Бид ийм л болгохыг хүсэж байна.

Хэрэв бид энэ бүхнийг Сүмдээ хийж чадах юм бол “ирээд, үз” хэмээх бидний урилгыг хүлээн авсан хүмүүс Есүс Христийн сэргээгдсэн Сүмийн захиасын хүчийг мэдрэх болно. Ариун ёслолын цуглаанаар бидэнтэй хамт шүтэн биширснээр тэдний сэтгэл зүрх хөндөгдөж, зүрх сэтгэл, оюун ухаанд нь сайн мэдээний гэрэл асах болно. ■

“The Chapel: Our Sabbath Sanctuary” prophets.lds.org-оос.



КЛАРК КЭЛЛИ ПРАЙС,
СҮҮЛЧИЙН ЗООГ

"Цаг болоход [Есүс] тухлан суулаа. Элч нар Түүнтэй хамт байв. . . .

Тэр талх авч, талархал өргөөд, тэдэнд хуваан өгөхдөө, -Энэ бол та нарын төлөө өгөх Миний бие мөн. Намайг дурсаж үүнийг үйлд гэж айлдав.

Тийн идэцгээсний дараа Тэр мөн аяга авч, -Энэ нь та нарын төлөө асгагдах Миний цусаар тогтоох шинэ гэрээ юм" (Лук 22:14, 19–20).

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

ТЭВЧЭЭР БОЛ ТЭНЦВЭРЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

Энэхүү гурван зарчмыг дагах нь бидэнд зөвхөн эцсээ хүртэл тэвчих биш, харин "эцсээ хүртэл баяр баясгалантай" байхад тусална.

44



18-ТАНГУУД

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨРИЙН ДАРАА ЮУ ХИЙХ ВЭ?

50

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

АВЬЯАС БЭЛГЭЭ ХЭРХЭН ХӨГЖҮҮЛЭХ ВЭ?

62

MONGOLIAN
4 02147 52363 1

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ